

DDC
363.2
Б-342

ЦАГДАА СУДЛАЛ

*Онол арга зүйн
улирал тутмын
сэтгүүл*

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Л.Гэрэлмаа

Хэвлэлийн хуудас ...

Цаасны хэмжээ: В.5

Хэвлэсэн газар: Номын цацал ХХК

Дугаарыг эрхлэн гаргасан: Докторант Г.Бямбадорж

ISBN 978-99962-8882-2-7

2018№1 (20)

“ЦАГДАА СУДЛАЛ” ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

Ж.Долгорсүрэн Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Б.Пүрэв Хууль зүйн доктор (Ph.D), хүндэт профессор

Ж.Заанхүү Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор

Г.Гантөмөр Хууль зүйн доктор,(Ph.D), профессор

З.Төрмандах Хууль зүйн доктор (Ph.D)

Т.Оюунчимэг Хууль зүйн доктор (Ph.D), профессор

Ж.Мөнхболд Хууль зүйн ухааны (Ph.D) дэд профессор

Сэтгүүлийн эрхлэгч: ХСИС-ийн тэргүүн дэд захирал Б.Бат-Эрдэнэ
Хууль зүйн доктор (Ph.D), профессор

Эрхлэн гаргасан, нарийн бичгийн дарга: Докторант Г.Бямбадорж

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

Т.Бямбаа Хууль зүйн доктор (Ph.D)

О.Цэцэгмаа Хууль зүйн доктор (Ph.D)

Д.Энхжаргал Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D)

Д.Мягмарцэрэн Хууль зүйн доктор (Ph.D)

Ш.Ариунбилэг Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Манай хаяг: Хууль сахиулахын их сургууль Баян зүрх дүүрэг, Цагдаагийн Академийн өргөн чөлөө, хилчиний гудамж-1, утас 70155011, 70155039, факс 976-11-70155039 мейл хаяг:police_journal@yahoo.com

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Ш.Чулуун Жагсаал цуглаан, нийтийн эмх замбараагүй байдал бий болсон үед төрийн байгууллагуудтай хамтарч ажиллах нь

Г.Бямбадорж Хэсгийн байцаагч, төлөөлөгчийн объектын судалгаанд орчны нөхцлийг үнэлэх онол загварыг ашиглах нь

Д.Бямбахүү Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ажлын эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлалын зарим асуудал

П.Эрдэнэбаатар Давтагдах хөдөлгөөний онолын ойлголт, практик хэрэглээ түүний ач холбогдол

Б.Хулан Галт зэвсгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг судалсан нь

Д.Ариунжин Хууль сахиулахын их сургуулийн мэдээллийн аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал

Х.Чинтөгс Хөрвөх мэргэжил эзэмшүүлэх нь цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааны нэг төрөл болох нь

О.Отгонтуяа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг сайжруулах зарим асуудал

С.Оюунчимэг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үзэл баримтлал шинэчлэлийн зарим асуудал

ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

В.Ганболор Зам тээврийн осол, жолооч нарын замын хөдөлгөөнд оролцох сахилга, соёлыг дээшлүүлэх нь

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Ж.Ууганчимэг Эвлэрүүлэн зуучлалын уламжлал шинэчлэл, хөгжлийн чиг хандлага, харьцуулсан судлал

ГАДААД ХЭЛ ДЭЭР БИЧИГДСЭН ӨГҮҮЛЭЛ НИЙТЛЭЛ

Даш Тамир Неприкосновенность личности и принуждение в уголовном процессе монголии в виде ареста подозреваемого

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЖАГСААЛ ЦУГЛААН, НИЙТИЙН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДАЛ БИЙ БОЛСОН ҮЕД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТАРЧ АЖИЛЛАХ НЬ

Ш.Чулуун

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн АТБТ-ийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга

Жагсаал цуглаан, нийтийн эмх замбараагүй байдал бий болсон үед цагдаагийн байгууллагын хийж гүйцэтгэх үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт хууль сахиулах тусгайлсан чиг үүрэгтэй болон бусад төрийн байгууллагуудын эрх үүрэг, хамтын ажиллагааны талаар авч үзсэн болно.

Түлхүүр үг

Жагсаал, цуглаан, эмх замбараагүй байдал, оролцоо, үүрэг, ажиллагаа

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг 1992 онд баталснаар хууль тогтоомжийг түүнд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажил эхэлсэн бөгөөд “Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөх ажлыг зохион байгуулах тухай” Улсын Бага Хурлын 1992 оны 14 дүгээр тогтоолын дагуу төрийн байгууллагын шинэтгэлийг хийх ажлын хүрээнд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын шинэчлэл эхэлсэн билээ.

Улмаар 1998 онд Улсын Их Хурал эрх зүйн бодлогын цаашдын чиг хандлагыг тодорхойлсон “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг баталж, Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санааны дагуу төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтны хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчныг бүрдүүлснийг тэмдэгдэх нь зүйтэй юм.

Тус хөтөлбөрт: “Эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхдээ төрт ёсныхоо олон зуун жилийн дэвшилт уламжлал, эрх зүйн тогтолцоо бүрэлдэн бий болсон арга, хэлбэрийг харгалзан, дэлхийн улс орнуудын нийтлэг чиг хандлага, өөрийн орны өвөрмөц нөхцөл байдал, үндэснийхээ ашиг сонирхолд нийцүүлэх зарчимд тулгуурлана” хэмээн заажээ.

Энэхүү ажлын хүрээнд Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээлгэсэн үндсэн чиг үүргээ биелүүлэхдээ Улсын Их Хурлаас баталсан Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баталсан холбогдох эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэгтэй ажиллах бөгөөд хууль сахиулах дээрх үүргээс гадна иргэнд үйлчлэх үйл ажиллагаа явуулдаг.

Нийтийг хамарсан арга хэмжээ гэдэг нь хүмүүсийн улс төр, бие бялдар, оюуны хэрэгцээг хангах зорилготой тэдгээрийн эрх ашигт нийцсэн олон түмний оролцоотойгоор явагдаж байгаа иргэдийн хүний эрх, эрх чөлөө хэрэгжих, өөр хоорондоо харилцах хэлбэр бие хүн, хамт олон, нийгэм бүхэлдээ үзэл бодол, үйл хөдлөл чиглэлээ нэгтгэх арга хэрэгсэл болсон зохион байгуулалттай үйлдлийн нийлбэр юм.

Монгол Улсын Үндсэн хуулинд “Монгол Улсын иргэн нь итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй”¹, мөн жагсаал, цуглааныг Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд

¹МУ-ын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 16 дахь хэсэг

бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага зохион байгуулах эрхтэй гэж тусгайлан заажээ.²

Дээр дурьдсан субъектууд нь гудамж, талбайд жагсаал, цуглаан хийхдээ энэ тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлэх үүрэгтэй байна. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ³ гэж газар нутгийн байршлыг нь тодорхой нарийвчлан тусгаж өгчээ.

Жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдэлд түүний зорилго, эхлэх, дуусах хугацаа, оролцогчдын баримжаа тоо, хэрэглэх техник хэрэгсэл, цуглах, жагсан явах гудамж, талбай зэргийг тодорхой заана. Засаг дарга жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор түүнийг бүртгэсэн эсэхээ бичгээр мэдэгдэнэ.

Жагсаал, цуглаан хийх мэдэгдлийг бүртгэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэхийн тулд нэмж тодруулах буюу зохицуулбал зохих асуудал гарвал Засаг дарга нь жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9-р зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу ажлын 3 өдрийн дотор зохион байгуулагчтай харилцаж зохицуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд жагсан явах чиглэлийг өөрчлөх эрхтэй байна.

Засаг дарга дээр дурдсан хуулийн хугацааны дотор хариу мэдэгдээгүй бол зохион байгуулагч нь мэдэгдэлд дурдсан газарт, түүнд заасан хугацааны дотор жагсаал, цуглааныг зохион байгуулах эрхтэй байхаар жагсаал цуглаан хийх журмын тухай хуулинд⁴ нарийвчлан заасан байна.

Гэвч иргэдийн тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийг ашиглан зөвшөөрөгдсөн газарт хуулийн дагуу явуулахгүй, хууль зөрчин улс төр хийх, бусдыг хууль бус халдлагад өдөөн турхирах, энгийн ард иргэдийн болон төрийн тангараг өргөсөн алба хаагчдын эрх чөлөөнд халдах, бусдын болон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэн гэмтээх, устгах, шатаах, иргэдийн нэр төр, алдар хүнд, эрх чөлөөнд бүдүүлгээр, хууль бусаар халдах, олон нийтийн зорчих хэсгийг хаах, төрийн тусгай хамгаалалтын бүсэд дур зоргоор нэвтэрч танхайрах зэрэг нийгмийн гажууд үзэгдэл гарсаар байна. Тухайлбал: Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн нэгдсэн дүнг улс төрийн зарим нам хүчин хүлээн зөвшөөрөөгүйгээс үүдэлтэй жагсаал болж улмаар түүнийг зохион байгуулагчийн хяналтаас гарч 2008 оны 07-р сарын 01-ны өдөр болсон нийтийн эмх замбараагүй байдлыг дурдаж болно.

Монгол Улсын Үндсэн хуулинд эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.⁵ Мөн "Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон" үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлахыг холбогдох хуулинд тодорхой тусгасан байна⁶.

Мөн нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.⁷

Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд, нутгийн

²Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 4-р зүйлийн 1 дэх хэсэг

³Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9-р зүйл

⁴Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9-р зүйлийн 5 дахь хэсэг

⁵МУ-ын Үндсэн хууль 11-р зүйлийн 1 дэх хэсэг

⁶МУ-ын Үндсэн хууль 25-р зүйлийн 2 дахь хэсэг

⁷МУ-ын Засгийн газрын тухай хууль 14-р зүйлийн 7 дахь хэсэг

өөрөө удирдах байгууллагууд нь үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтыг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн тус тусын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үүрэгтэй.⁸

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагад эрх хэмжээнийхээ дагуу үүрэг даалгавар өгөх, шаардлага тавих бүрэн эрхтэй⁹ гэж тус тус хууль болон эрх зүйн актуудад төр болон төрийн эрх бүхий байгууллагуудын эрх, үүргийг тодорхой заасан байна.

Цагдаагийн байгууллага нь шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуульд¹⁰ заасан үндсэн үүргийнхээ хүрээнд гудамж талбай, авто тээврийн хэрэгслийн зорчих хэсэгт жагсаал цуглаан, олон нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх таслан зогсоох, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдал, эрх, эрх чөлөөг ханган ажиллах, зохион байгуулах үүрэгтэй.

Нийтийг хамарсан арга хэмжээ нь нийтийн эмх замбараагүй байдлаас ялгагдах гол онцлог нь тайван замаар болдогт оршино. Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэдэг нь нийгмийн хэв журмыг зөрчин олон нийтийн газарт нийгэм, олон нийтэд аюултай нөхцөл байдлыг үүсгэж буй үйлдлийг хэлнэ.¹¹

Нийтийг хамарсан арга хэмжээ ямарч нөхцөлд нийтийн эмх замбараагүй байдал болон өөрчлөгдөж болно. Тиймээс хаана, хэдийд, ямар зорилго, чиглэлтэй нийтийн эмх замбараагүй байдал үүсч болзошгүйг судлан Цагдаагийн байгууллагаас ажиллах шуурхай төлөвлөгөөнүүдийг хэд хэдэн хувилбараар боловсруулж байнгын бэлтгэлтэй байх нь чухал ач холбогдолтой юм.

Нийтийн эмх замбараагүй байдал нь онцгой нөхцөл байдлын нэг хэлбэр бөгөөд энэ талаархи ойлголтыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12-р сарын 28-ны өдөр шинэчлэн батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд: Олныг хамарсан түйвээн үймүүлэх, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх нөхцөл байдал гэж тодорхойлсон байна.¹²

Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсч бий болсон тохиолдолд цагдаагийн байгууллагаас авч явуулах арга хэмжээг удирдахаар шуурхай удирдлагын штаб байгуулагдах бөгөөд түүнд зохион байгуулах, нөхцөл байдлыг үнэлэх, харилцан ажиллагааг хангах бүлгүүд багтана. Жагсаал цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдлын үеийн хамгаалалтыг Цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар томилогдсон Шуурхай удирдлагын штаб /Цаашид “Удирдлагын штаб” гэнэ/ удирдаж, хяналт тавина. Уг штабын ажиллах чиг үүргийг Цагдаагийн төв байгууллагын дарга батална.¹³

Тусгай ажиллагаа гэдэг нь эмх замбараагүй байдал үүссэн үед нийгмийн хэв журам хамгаалах, аюулгүй байдлыг хангах, эд хөрөнгийг устгах, шатаах, тэсэлж дэлбэлэх гэмт этгээдүүдийг баривчлах зорилгоор цагдаагийн байгууллагаас явуулж буй тандан судлах, мөрдөн байцаалтын, гүйцэтгэх ажлын, урьдчилан сэргийлэх болон таслан зогсоох арга хэмжээний нэгдэл бөгөөд түүнийг шуурхай удирдлагын штабын даргын удирдлаганд зохион байгуулж явуулна.

Тусгай ажиллагааг эмх замбараагүй байдал хаана үүсэж бий болсноос шалтгаалан

⁸МУ-ын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 6-р зүйлийн 2 дахь хэсэг

⁹МУ-ын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7-р зүйлийн 1.4 дэх хэсэг

¹⁰2017 оны 02-р сарын 09-ны өдөр шинэчлэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн 4-р зүйл

¹¹Таванжин Д., “Монгол Улсын цагдаагийн эрх зүй”, УБ 2006 он.

¹²2017 оны 02-р сарын 28-ны өдөр шинэчлэн баталсан ЦБҮАЖ код-504 “Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам”-ын 504.2 дахь хэсэг

¹³2017 оны 02-р сарын 28-ны өдөр шинэчлэн баталсан ЦБҮАЖ код-500 “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам”-ын 500.6.1 дэх заалт

тодорхой газар нутаг, дүүрэг, хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд явуулна. Анх хуулинд зааснаар албан ёсны зөвшөөрөл авч зохион байгуулагдсан жагсаал, цуглаан нь явцдаа зорилго нь өөрчлөгдөж жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд¹⁴ заасан доорхи агуулга, шинжтэй болбол тус жагсаал, цуглааныг цаашид үргэлжлүүлэн хийхийг хориглосон байхаар тусгажээ. **Үүнийг тодотговол:**

➤ Дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа,хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах

➤ Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгохоор бол гэжээ.

Эдгээр нөхцөл байдал нэгэнт бий болсон үед төр болон төрийн ба төрийн бус байгууллагууд нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөн өөр өөрийнхөө гүйцэтгэх эрх хэмжээ, үүргийнхээ хүрээнд харилцан хамтарч ажиллан гарч болох хохирол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нэгэнт гарсан тохиолдолд хор уршигийг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Энэхүү эрх, үүргийг нь Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд¹⁵ дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Үндэсний аюулгүй байдлыг хангахад Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын бүрэн эрх

Улсын Их Хурал нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг тодорхойлж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг батална.

Монгол Улсын Ерөнхийлөгч нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж, үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар холбогдох байгууллагуудын ажилтай танилцаж, чиглэл өгнө.

Монгол Улсын Засгийн газар нь үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

2. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын оролцоо

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал үүсэхээс сэрэмжилж, энэ талаар үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албадад мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахуулах асуудлаар санал өгнө.

3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын оролцоо

Нутгийн өөрөө удирдах байгууллага төрийн бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар бодлого боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

4. Бүх шатны Засаг дарга нарын оролцоо

Бүх шатны Засаг дарга үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх, таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцлийг судлан тогтоох, арилгах арга хэмжээ авч, энэ асуудлаар нутаг дэвсгэртээ байгаа үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албадад чиглэл өгч, холбогдох байгууллагад санал, хүсэлт тавина.

5. Төрийн байгууллага, албан тушаалтны оролцоо

Төрийн байгууллага, албан тушаалтан үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар Зөвлөлд санал, хүсэлтээ тавих эрхтэй.

¹⁴ Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 8-р зүйлийн 8.1 дэх хэсэг

¹⁵ Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3-р бүлгийн 8-14-р зүйл

6. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоо

Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж үндэсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлж, үндэсний язгуур ашиг сонирхлыг дээдлэх үүрэгтэй.

Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн байгууллага, албан тушаалтанд санал, хүсэлтээ тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

7. Иргэний оролцоо

Монгол Улсын иргэн үндэсний язгуур ашиг сонирхлоо дээдэлж, хуулиар тогтоосон үүргээ биелүүлэх, төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

Монгол Улсын иргэн үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй асуудлаар төрийн зохих байгууллага, албан тушаалтанд санал, гомдлоо тавьж шийдвэрлүүлэх эрхтэй гэж тус тус тусгайлан заажээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар жагсаал цуглааныг албадан тараах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед цагдаагийн нийт бие бүрэлдэхүүнийг удирдах Шуурхай удирдлагын штаб байгуулагдан бусад төрийн байгууллагатай хамтарч оролцох бөгөөд энэ үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, барилга байгууламжийг гадны халдлагаас хамгаалах, гэмт этгээдийг баривчлах, хууль бус жагсаал цуглаанд оролцогчдын үйлдлийг түргэн шуурхай богино хугацаанд таслан зогсоох зорилгоор Цагдаагийн албаны тухай хуулинд¹⁶ заасан эрхийнхээ хүрээнд албадлагын тусгай арга хэмжээ буюу аминд халгүй зэвсэг /тусгай хэрэгсэл/-ийг хэрэглэдэг, ялангуяа олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг ашигладаг тул алба хаагчдын албаны мэдлэг, хэрэглэх ур чадварыг сайжруулах шаардлагатай байна.

Мөн Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу төр болон төрийн бусад байгууллага үүргээ биелүүлж шаардлагатай тохиолдолд хамтарч ажиллах, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, энэ чиглэлээр хамтарч нэгдсэн сургалт, дадлага хийх хэрэгтэй байна.

Санал

1. Жагсаал цуглаанаас үүсэлтэйгээр бий болж үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж нийтийн эмх замбараагүй байдал бий болсон үед төрийн байгууллагууд ялангуяа /Цагдаа, Тагнуул, Хил, Төрийн тусгай хамгаалалт, Онцгой байдал, Эмнэлэг, Засаг дарга, Нутгийн захиргааны байгууллага гэх мэт/ хамтарч ажиллах хэрэгцээ шаардлага нэн тэргүүнд байгаа тул энэ талаар нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан баталж улмаар биелэлтийг хангаж ажилласнаар байгууллага хоорондын харилцан хамтарч ажиллах нөхцөл бүрдэж хэн нь ямар үүрэг чиглэл, уялдаа холбоотойгоор тухайн ажиллагаанд оролцох нөхцөл байдал нь тодорхой болно.

2. Мөн дээр дурдсан байгууллагуудын хооронд хамтарсан нэгдсэн дадлага, сургалтыг зохион байгуулж явуулснаар үйл ажиллагаанд оролцож байгаа тухайн байгууллагын удирдлага, алба хаагчдын хамтын ажиллагаанд эерэг нөхцөл байдал бий болж шаардлагатай тохиолдолд үүргээ гүйцэтгэх мэдлэг, ур чадвар, дадлыг нэгдсэн байдлаар эзэмшсэн байна.

3. Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар нийтийг эмх замбараагүй байдлын үед цагдаагийн нийт бие бүрэлдэхүүнийг удирдах Шуурхай удирдлагын штаб байгуулагдан штабын даргын шийдвэрээр олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх бөгөөд энэ ажиллагааг гардан зохион байгуулдаг алба, хэлтсийн алба хаагчдад сургалт, дадлагыг тухай бүр зохион байгуулж явуулснаар мэдлэг, ур чадвар нь төлөвшин тогтворжиж улмаар ажиллагааны үед хүчийг зөв тохируулан хэрэглэж эрхээ хэтрүүлэхгүй байх, хариуцсан ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ.

¹⁶ 2017.02.09-ны өдөр шинэчлэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн 5-р бүлгийн 54-р зүйл

**ХЭСГИЙН БАЙЦААГЧ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ОБЪЕКТЫН СУДАЛГААНД ОРЧНЫ
НӨХЦЛИЙГ ҮНЭЛЭХ ОНОЛ ЗАГВАРЫГ АШИГЛАХ НЬ**
(Эрүү, хэв журмын нөхцөл байдлын судалгааны жишээн дээр)

Г.Бямбадорж

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
ахлах багш, докторант, цагдаагийн хошууч

Товч агуулга. Цагдаагийн байгууллагаас хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг шинжлэх ухааны онол, загваруудад тулгуурлан хийж түүнийг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд хэрхэн ашиглах, үйл ажиллагаагаа төлөвлөх, шийдвэр гаргах талаар авч үзэн түүнийг үнэлэх талаар шинэ загвар боловсруулж, түүний үр нөлөөг дээшлүүлэх талаар энэхүү нийтлэлдээ авч үзсэн.

Түлхүүр үг: Онол, судалгаа, арга, нөхцөл байдал, төлөвлөлт, нэгдсэн байршил, орчин

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүн амын төвлөрөл, барилгажилт, хот төлөвлөлт, хотын амьдралын хэв маяг, нийгмийн ёс суртахууны доройтол, хотжилтыг даган эрчимжиж буй гэмт явдлын чиг хандлага, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл зэргийг харьцуулан судалж цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ онолын болон практикийн түвшинд тодорхойлж, ажиллах шаардлага зүй ёсоор тулгарсаар байна¹⁷.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүн амын төвлөрөл, барилгажилт, хот төлөвлөлт, хотын амьдралын хэв маяг, нийгмийн ёс суртахууны доройтол, хотжилтыг даган эрчимжиж буй гэмт явдлын чиг хандлага, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл зэргийг харьцуулан судалж цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ онолын болон практикийн түвшинд тодорхойлж, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг сайжруулж, түүнд дүн шинжилгээ хийж түүний мөрөөр үр дүнтэй ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Цагдаагийн байгууллагаас хийх хариуцсан нутаг дэвсгэрийн объектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болох “Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаа” хийх ажлын эрх зүйн үндэсийг шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуульд нарийн тодорхой зааж өгөөгүй боловч, энэхүү ажлын эрх зүйн үндэс нь цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэгтэй шууд холбоотойгоор хуульчлагдсан байна. Үүнд: Шинэчлэн найруулсан цагдаагийн албаны тухай хуулийн 18-р зүйлд Цагдаагийн байгууллагын судалгааны төв доор дурдсан чиглэлээр сан бүрдүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах, санал боловсруулах үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

18.1.1.цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх стандарт, дүрэм, журам, зааврыг боловсронгуй болгох;

18.1.2.гэмт хэрэг, зөрчлийн ул мөр илрүүлэх, буулган авах, бэхжүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг нотлох, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, гүйцэтгэх ажил явуулах арга тактикийг боловсронгуй болгох;

18.1.3.зам тээврийн осол, хэрэг болон насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;

¹⁷ Цагдаа судлал сэтгүүл 2013 №3. 47 дахь тал

18.1.4.гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах асуудлаар бодлого боловсруулах чиглэлээр дүн шинжилгээ хийж, цагдаагийн байгууллагыг мэдээллээр хангах¹⁸ гэсэн заалт нь цагдаагийн байгууллага алба хаагч хариуцсан нутаг дэвсгэрийн хүн объектыг судалхаас гадна үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг судлах, нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлаж нөхцөл байдлаа үнэлэн үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бий болсон. Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаа гэдгийг бид дараах байдлаар тодорхойлж авч үзсэн.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаа гэдэг нь: Хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн ангилал, төрөл, өсөлт, бууралт, үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн давтамж, үйлдэгдсэн өдөр гариг, цаг хугацаа, гэмт хэрэг зөрчлийн нягтаршил, гэмт халдлагын зүйл, хөндөгдөж буй нийгмийн харилцаа зэрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцлийг нарийн тодорхойлж хийсэн дүн шинжилгээ гэж бид тодорхойлж болохоор байна¹⁹.

Мөн түүнчлэн хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг хийх нь дараах ач холбогдолтой байна. Үүнд:

- Үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн гаралтийг тодорхойлох
- Үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн ангилал, төрлийг тодорхойлох
- Үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нягтрал байршил тодорхойлох
- Үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн циклийг тодорхойлох
- Гэмт явдлын прогноз гаргах
- Гэмт явдлын шалгаан нөхцлийг тогтоох
- Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх
- Цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой болгох
- Гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх ажлын алдаа дутагдлыг ирүүлж, арилгуулах
- Эргүүлийн нэгдсэн байшил, чиглэлийг оновчтой тодорхойлох
- Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх
- Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа үнэлэлт өгөх гэх мэт ач холбогдолтой байна.

Цагдаагийн хэв журмын эргүүлийн төлөвлөлтийг судлан үзэхэд жилд хоёр удаа эргүүлийн чиглэл (эргүүлийн нэгдсэн байршил)-ийг шинэчлэн батлаж байгаа нь учир дутагдалтай оновчтой бус байгаа бөгөөд эргүүлийн чиглэл бүрийг тухайн чиглэлд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн байдал өөрөөр хэлбэл эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд тулгуурлах ёстойг орхигдуулснаас гудамж тайлбайд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчил буурахгүй байх шалтгаан болсоор байна.Тиймээс хэсгийн байцаагч, төлөөлөгч, хороо сум хариуцсан цагдаа нар нь хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг сайжруулж, цагдаагийн хэв журмын эргүүл харуулын нэгдсэн байшилтыг батлуулах эргүүлийн чиглэлийг шинээр нэмэгдүүлэх, гэмт хэрэг зөрчлийн гаралт багатай эргүүлийн чиглэлийг цуцлах, уг чиглэлд ажиллах алба хаагчийн тоог цөөрүүлэх, гэмт хэрэг зөрчил байнга үйлдэгддэг, гэмт хэрэг зөрчлийн тоо өсөж байгаа нутаг дэвсгэрт эргүүлийн чиглэлийг нэмэгдүүлж эргүүлийн чиглэлд ажиллах алба хаагч нарын тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

Цагдаагийн байгууллагын мэдээлэл судалгааны алба үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн гаралт, гэмт хэрэг, зөрчлийн төрөл, өсөлт бууралт, хэрэг, зөрчлийн ангилал, халдаж буй нийгмийн харилцаагаар нь, гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаагаар сар бүр дүн шинжилгээ хийж байгаа ч энэхүү статистик мэдээг гэмт хэрэгтэй тэмцэх үйл

¹⁸ Цагдаагийн албаны тухай хууль

¹⁹ Г.Бямбадорж. Архидан согтуурах явдалтай тэмцэх үйл ажиллагаа, УБ хот 2013 он. 76 дахь тал

ажиллагаанд ашиглахад төдийлөн үр дүнд хүрэхгүй байгааг өнөөгийн үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоо шинж байдлаас харж болно.

Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаа нь үндсэндээ гэмт хэргийн статистик үзүүлэлт, ажлын тайлан хэлбэрээс хэтрэхгүй байгаа нь нууц биш. Бидний үзэж байгаагаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүн шинжилгээ хийж аль дүүрэг хороонд ямар төрлийн гэмт хэрэг өсөж байна тэр дүүрэг хороонд эргүүлийн чиглэл, хүн хүчийг түлхүү ажиллуулах, олон нийтийн цагдаагийн ажилтан болон сайн дурын цагдаагийн ажилтан ажлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Түүнээс гадна эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаа хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга хэлбэрийг сайжруулах үүднээс дараах онол загваруудтай холбон авч үзье. Үүнд:

Хүрээлэн буй орчны онолыг АНУ-ын судлаач Бурнс болон Сталкер нар уг онолыг санааччилсан юм. Тэдний хувьд байгууллагуудын удирдагчид аливаа нөхцөл байдлыг сайтар судалж, “хүрээлэн буй орчныг нь сайтар унших буюу судлан” байж тухайн байгууллагад “тохирсон” бүтцийн загвар болон үйл ажиллагааг тодорхойлон сонгох ёстой гэж үздэг юм²⁰

Энэхүү онолыг үндэслэн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны орчин, нөхцөл байдалд сайтар дүн шинжилгээ хийсний үндсэн дээр Цагдаагийн байгууллагын загвар бүтэц, үйл ажиллагааны төлөвлөлт, арга тактикийг тодорхойлж болно.

Өөрөөр хэлбэл Цагдаагийн байгууллага хатуу тогтоосон бүтэцтэй байх бус харин хариуцсан нутаг дэвсгэрийнхээ нөхцөл байдалд тохирсон бүтэц, зохион байгуулалттай байж болохоор байна. Үүний нэг жишээ нь: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25-р зүйлийн 25.2 дахь хэсэгт Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно. гэж заасан нь тухай нөхцөл байдлыг судлаж түүнд тохирсон бүтэцтэй байж болохоор байгаа нь энэхүү онол үндэслэлтэй болохыг нотлож байна.

Нөөцийн хамаарлын онолыг үндэслэлтэй тайлбарлаж чадсан судлаачид бол Преффер болон Сланцик нар юм. Тухайн онолын үндсэн санаа нь аливаа агентлаг үйл ажиллагаа явуулахын тулд заавал хүрээлэн буй орчноос нөөц хэрэгслийг авах ёстой байдаг гэсэн үзэл юм. Энэ нь нөөц хэрэгслээс хэт хамааралтай байх нөхцөл байдлыг бий болгодог.

Нөөц хэрэгслийн хувиарлалтанд анхаарч хүрээлэн буй орчинг судлан хянаснаар агентлагуудыг захирч, улмаар тэднийг хүрээлэн буй орчноос хамааралтай болгодог гэж үзсэн²¹. Өөрөөр хэлбэр эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хянаж чадахгүй бол цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлаас хамааралтай болж зөвхөн түүнд тохирсон үйл ажиллагаа явуулж түүнийг хянаж чаддаггүй ба эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хяналтандаа авсны дараа түүнээс хамааралгүй болж байгууллага амжилтанд хүрнэ хэмээн үзсэн байна.

Нөгөө талаар цагдаагийн байгууллага хүн хүч, чадавхаа нэмэгдүүлэх, нөөц хэрэгслийг хангах нь амжилтанд хүрэх чухал хэрэгсэл гэдгийг нотолжээ.

Хүн амын экологийн онолыг Герман Улсын эрдэмтэн Ханнан болон Фриман нар үндэслэсэн бөгөөд 1970-аад оны сүүл үеэс эхлэн газар авч эхэлсэн ба уг онолоор нэг чиг үүрэгтэй олон байгууллагууд өрсөлдөн хүн амын нягтаршил, газар нутгийн байрлал, түүний онцлог зэрэгт илүү анхаарал хандуулснаар байгууллагууд илүү их амжилтад хүрнэ гэдгийг тодорхойлох оролдлого хийжээ.²² Өөрөөр хэлбэл: Гэмт хэрэгтэй тэмцэх

²⁰ Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration , 2011. 124-139 дэхь тал

²¹ Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration , 2011. 124-136 дахь тал

²² Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration , 2011. 124-129 дэхь тал

нэг чиг үүрэг бүхий нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага хариуцсан нутаг дэвсгэрийн хүн амын тоо, оршин суух иргэдийн нягтаршил газар нутгийн хэмжээ, байрлал онцлог зэргийг судлаж, дүн шинжилгээ хийх гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Мөн зэргэлдээ орших аймаг, дүүрэг, сум, баг, хорооны хүн амын нягтаршил, газар нутгийн байрлал, түүний онцлог зэргийг судлан мэдэж байх нь үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах ажил явуулах зэрэг цагдаагийн байгууллагын чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх үндэс болно хэмээн тайлбарлаж болох юм. Иймд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг хийхдээ энэхүү онолыг иш үндэс болгон өөрийн хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлаад зогсохгүй зэргэлдээ орших аймаг, дүүрэг, сум, баг, хорооны хүн амын нягтаршил судалгааг хийх шаардлагатай.

Судлаач бид хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлахдаа дээр дурьдсан онолыг үндэслэл болгон нөхцөл байдлыг судлах дараах онол загвар байж болно гэж үзэж байна.

Хүснэгт №1.Хүрээлэн буй орчныг үнэлэх загвар

№	Ангилал	Хүрээлэн буй орчин	Хүрээлэн буй орчны хүчин зүйлс
1	Дотоод орчин	Цагдаагийн алба хаагч нарын орон тоо	Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт
2		ЦАХ-ын ур чадвар арга тактик	Албаны сургалтын агуулга, чанар, үр дүн
3		ЦАХ нарын ажлын ачаалал	Шалгаж буй өргөдөл гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийн тоо
4		Гүйцэтгэх ажлын мэдээлэл	Тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн судалгаа, тэдний яриа өгүүлэл үйл хөдлөл, үйлдэж буй гэмт хэрэг, зөрчил
5		Хорихоос сулдагдсан ХӨТЯШ хүмүүстэй ажиллаж буй байдал	Гэмт хэрэг үйлдээд суллагдсан болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийн ажил хөдөлмөр эрхлэлт, тэдний нийгмийн байдал
6		Туслах хүчний байдал	Туслах хүч, сайн дурын ба олон нийтийн цагдаагийн ажилтны тоо, тэдний үйл ажиллагаа үр дүн
7		Байгууллагын төлөвлөлт зохион байгуулалт	Байгууллагын төлөвлөсөн ажлын тоо Төлөвлөсөн ажлын зорилго, үр дүн Үйл ажиллагаа чиг үүргийг давхардал Үйл ажиллагааны алдаа дутагдал хийдэл Удирдлын зохион байгуулах ур чадвар
8		Бусад байгууллага нэгжийн үйл ажиллагаа	Алба нэгжийн үйл ажиллагааны уялдаа холбоо хамтын ажиллагаа Үндсэн чиг үүрэгтэйгээс бусад алба нэгжийн үйл ажиллагаа, тэдгээрийн нөөц боломж Бусад агентлагууд байгууллагуудын үйл ажиллагаа Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын

			ажиллагаа, оролцоо
9	Гадаад орчин	Эдийн засгийн орчин	Эдийн засгийн өнөөгийн байдал Эдийн засгийн төлөв Эдийн засгийн уналт Эдийн засгийн өсөлт Үнийн хөөрөгдөл
10		Улс төрийн орчин	Улс төрийн төлөв байдал Улс төрийн тогтоортой байдал ЗГ-ын бодлого үйл ажиллагаа Эрх мэдэлтнүүдийн нөлөөлөл
11		Улс орны нийгмийн байдал	Ажилгүй иргэдийн тоо-Үүнээс гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийн эзлэх хувь Ядууралын түвшин-Үүнээс гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийн эзлэх хувь Архидалт- Үүнээс согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн эзлэх хувь Мансуурах явдал-Үүнээс мансуурсан үедээ, мансууруулах бодистой холбоотой үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн тоо Биеэ үнэлэлт Үйлдвэр, аж ахуй эрхлэлт Нийгмийн халамжийн үйлчилгээ, тэтгэвэр тэтгэмж
12		Үйл явдал гэмт хэрэг	Гэмт хэрэг зөрчлийн өсөлт Гэмт хэрэг зөрчлийн бууралт Гэмт хэрэг үйлдэж буй арга, хэрэгсэл Гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж буй цаг хугацаа, газар орон Гэмт хэрэг үйлдэгч нарын нас хүйс Гэмт бүлэг, бөөгнөрөл тэдний байдал Байгалийн гамшиг, жагсаал цуглаан бослого тэмцэл, томоохон үйлдвэрлэлийн осол, олныг айдаст автуулсан хүнд, онц хүнд гэмт хэрэг аллага, мансууруулах бодис, хүний наймаатай холбоотой гэмт хэрэг зэрэг улс төр, нийгэм, эдийн засагт хор хохирол учруулсан гэмт хэргийн ертөнцтэй холбоотой үйлдэл, нэмэлт төсөв хөрөнгө шаардлагатай ажил арга хэмжээнүүд
13		Боловсролын орчин	Боловсролын тогтолцоо Боловсролын агуулга, чанар Гэмт хэрэг, зөрчил үйлдэгч нарын боловсролын түвшин Гэмт хэрэг, зөрчил үйлдэгч нарын эзэмшсэн мэргэжил Боловсрол эзэмшээгүй иргэдийн тоо
14		Эрх зүйн орчин	Үндсэн хууль бусад хууль тогтоомж Үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж Тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам Эрх зүйн хамгаалалт бий болсон орчин Эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдэл
15		Хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа	Хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа Шүүхийн ял оногдуулалтын байдал Захиргааны шийтгэл ногдуулалт

		Ялтныг нийгэмшүүлэх ажил, түүний үр дүн Ялтныг хүмүүжүүлэх ажил, түүний үр дүн Өмгөөлөлийн үйл ажиллагаа Цагдаагийн байгууллага, алба хаагч нарын үйл ажиллагаа
16	Техник технологи	Үйл ажиллагаагааны ил тод байдал, шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ашиглалт шинэ арга, технологи нэвтрүүлж ашиглах бодлого, түүний хэрэгжилт

Дээр дурьдсан онол загварыг иш үндэс болгохын зэрэгцээ эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлахдаа байгууллагын зорилго зорилт, хэрэгцээ шаардлагад тохирсон шинжлэх ухааны анализийн арга, синтезийн арга, индукцийн арга, дидукцийн арга, аналогийн арга, харьцуулалтын арга, системт хандлагын арга, бүтэц үүргийн арга, хэмжилтийн арга, түүврийн арга, ажиглалтын арга, баримт бичиг судлах арга, социометрийн арга, бүлэглэх арга, сурвалжлагын зэрэг аргыг өргөнөөр ашиглах нь зүйн хэрэг.

Цагдаагийн байгууллага эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаа нь эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хянах, үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг илааршуулахын тулд авч хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлохуйц түвшинд хийгдсэн байх бөгөөд бид үйл ажиллагаандаа шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник технологи ашиглахын зэрэгцээ цагдаагийн эргүүлийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай.

Цагдаагийн эргүүл нь зөвхөн хариуцсан нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг гүйцэтгэх бус тухай нутаг дэвсгэрт оршин сууж байгаа гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүс, гэмт хэрэг үйлдээд батлан даалтанд байгаа хүмүүс, хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн зэрэг хүмүүст хяналт тавих зэргээр тэднийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэх, үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой болох тул эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагч нарын үүргийг энэ чиглэлд хандуулж ажилуулснаар эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хянах боломжтой болно.

Тэрчлэн үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралтанд дүн шинжилгээ хийж аль дүүрэг хороо, хэсэгт ямар төрлийн гэмт хэрэг өсөж байна тэр дүүрэг хороонд эргүүлийн чиглэлийг түлхүү ажиллуулах, цагдаагийн алба хаагч болон урамшилт эргүүл, сайн дурын цагдаагийн ажилтныг байрлуулан ажлуулж цагдаагийн хүн хүчийг зөв хувиарлах ач холбогдолтой болно.

Мөн нутаг дэвсгэрийн хүн амын нягтаршил үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралтын тоо, хэргийн ангилал, үйлдлийн арга зэрэгт дүн шинжилгээ хийж шаардлагатай бол нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэсэг бий болгож ажилуулж болно.

Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг илааршуулахын тулд **street police** буюу Гудамж талбайд цагдаагийн алба хаагч нарыг оновчтой байрлуулж ажлуулах ёстой.

Нөгөө талаар гудамжид үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагч нь цагдаагийн байгууллагын имидж болж байдаг. Тухайлбал: Тэд олон нийттэй харилцаж, цагдаагийн байгууллагын бодлого, зорилтыг хэрэгжүүдэг. Ингэхдээ тэд хоёр янзаар ажил үүргээ гүйцэтгэдэг. Үүнд:

(1) “Төрийн ажилтны эрх үүрэг гүйцэтгэх” буюу хууль дүрмийг сахиулах бодлогыг хэрэгжүүлж байгууллага, иргэдийг дагаж мөрдүүлэх.

(2) “Иргэний цагдаагийн үүрэг гүйцэтгэх” буюу хууль дүрмийг сурталчилж цагдаагийн үйл ажиллагаанд иргэд олон нийтийн татан оролцуулж, иргэдэд түшиглэх зарчмыг хэрэгжүүлэх гэсэн хоёр хэлбэртэй байдаг.

Хэдийгээр зарим нэг цагдаагийн алба хаагч нар дээрх хоёр хэлбэрийн нэг талыг илүү баримтлах нь элбэг байдаг ч, олонх нь аль алийг нь баримтлан ажил үүргээ гүйцэтгэдэг учир энэхүү хоёр хэлбэрийг ашигласан нь тодорхой үр дүнг үзүүлсэн байна.²³

Дүгнэлт

Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааны статистик үзүүлэлтийн хэмжээнд хийгдсэн уламжлалт загварыг өөрчилж, шинжлэх ухааны онол, аргуудыг ашиглан эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг гарган хэсгийн байцаагч, төлөөлөгчийн объектын судалгааны төрөл болох эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаанд түшиглэн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа төлөвлөх, үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн гаралт, ангилал төрөл, гэмт хэрэг зөрчлийн нягтрал, гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгийг тодорхойлох, гэмт явдлын прогноз гаргах, гэмт явдлын шалгаан нөхцлийг тогтоох, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх ажлын алдаа дутагдлыг ирүүлж, арилгуулах, эргүүлийн нэгдсэн байшил, эргүүлийн чиглэлийг оновчтой тодорхойлох, үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх, гэмт хэргийн илрүүлэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлох нөхцлийг бүрдүүлсэн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг хийж ашиглах шаардлагатай гэж бид дүгнэж байна.

Санал

- Цагдаагийн байгууллагаас хийх объектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болох эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг хийхдээ шинжлэх ухааны онол загвар, арга зүйд тулгуурлан нэг хэлбэр бүхий (хэвшмэл) загварыг өөрчилж, хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг шаардлагын хэмжээнд өргөн хүрээтэй хийж хэвших

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хянах, илааршуулахын тулд comp.stat, crime mapping зэрэг эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд тус дөхөм болох системүүдийг нэвтрүүлж ашиглах

- Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаанд түшиглэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах асуудлаар бодлого боловсруулах, хэрэгжүүлэх

- ЦЕГ-ын даргын 2011 оны 12-р сарын 28 өдөр А/264 тоот тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код (400) “Эргүүл харуулын дүрмийн хэрэгжүүлэх” журмын 400.4.2. “Эргүүлийн нэгдсэн байршилтыг жилд хоёр удаа шинэчлэн баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг өөрчилж “Эргүүлийн нэгдсэн байршилтыг эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлаас шалтгаалан тухай бүр шинэчлэн баталж, мөрдөж ажиллана” гэж өөрчлөх зэрэг болно.

- Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн зүйлд 18-р зүйлд заасан судалгааны төвийн судалгаа хийх чиглэлд “орчны нөхцлийг судлах” гэж нэмэлт оруулах гэх мэт.

²³ Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration , 2011. 154 дэх тал

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Д.Бямбахүү

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн
эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн хошууч

Товч агуулга

Цагдаагийн байгууллагын хөгжлийн явцад гэмт хэрэгтэй тэмцэх ажил нь шинэ арга хэлбэр буй болгож ирсний үр дүнд цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ажил үүсч, улмаар өсөн хөгжиж улам боловсронгуй болж ирсэн.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ажил нь ямарваа нэг алдаа дутагдалгүй, хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй, үүрэгт ажлаа хуулийн хүрээнд бүрэн дүүрэн биелүүлэн ажиллах нь цагдаагийн байгууллагын анхаарах асуудлын нэг болж энэ талаар шинэчлэл хийгдсээр байна.

Энэхүү өгүүлэлдээ 1921 оноо хойш Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуул буй дүрэм, журам, хууль, мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж ирсэн хууль тогтоомжийн хүрээнд эрх зүйн зохицуулалтыг судалж үзлээ.

Түлхүүр үг

Эрэн сурвалжлах ажил, эрх зүйн зохицуулалт, түүхэн хөгжил

Үндсэн хэсэг

Эрэн сурвалжлах гэдэг үгийн үндэс болох эрх гэдэг үгийг монгол хэлний товч тайлбар тольд “*мэдье, олъё*” гэж хайх сурвалжлах эрэх сурах, эрж хайх, эрж сурвалжлах гэсэн хоршоо үг²⁴ гэснээс үзэхэд аливаа зүйлийг мэдэх эсхүл олох зорилгоор тодорхой этгээдээс хийх үйлдэл буюу үйл ажиллагаа байна.

1921 оны 07 дугаар сарын 19-нд Засгийн газрын 6 дугаар хуралдаанаар цагдаагийн байгууллагыг Цэргийн яамны дэргэд “Сэргийлэх цэрэг” нэртэйгээр байгуулж, улмаар дүрмийг боловсруулах ажлын хэсэг байгуулж, 1923 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн Засгын газрын 18 дугаар хуралдаанаар “Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрэм, хэмжээ”-г баталсан.

“Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрэм, хэмжээ”-ний 26 дугаар зүйлд “Цахилгаан утас ба цахилгаан гэрлийн багана мод ба утас зүйлийг цаггүй цагдан байцааж, хааяа эвдэх хулгайлах нь буй авбаас эрхгүй даруй түргэнээ сурвалжлан байцаан барьж шүүх явдлын яамнаа мэдүүлж хүргүүлж нягтлан шийтгүүлвээс зохимой”. 27 дугаар зүйлд “Аливаа хулгай ба булаан уулаглах жич хүний амины зэрэг тохиолдвоос харьяа ялт хүнийг даруй түргэнээ санаа сүвэгчлэн байцаан барьж, шүүх явдлын яамнаа мэдүүлэн хүргүүлж, шүүх шийтгүүлвээс зохимой”.

1924 онд Улсын анхдугаар хуралдаанаар Цагдан сэргийлэхийг Цэргийн яамны харьяанаас гаргаж, Дотоод яамны харьяанаас гаргаж Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрыг байгуулсан. 1926 оны 1 дүгээр сарын 15-нд баталсан БНМАУ-ын Цагдан сэргийлэх газрын дүрмийн 61 дүгээр зүйлд “Аливаа хулгай худал ба булаан уулаглах жич хүний амины зэрэг тохиолдвоос харьяа ялт хүнийг даруй түргэнээ санаа сүвэгчлэн байцаан барьж, шүүх явдлын яамнаа мэдүүлэн хүргүүлж шүүх шийтгүүлвээс зохимой”.

1926 оны 5 дугаар сарын 12-ны хуралдаанаар цагдан сэргийлэхийг орон нутагт байгуулахыг түдгэлзүүлж, УЦСЕГ-г татан буулгаж, Улаанбаатар хотын захиргааны харьяанд Цагдан сэргийлэх хэлтэс байгуулж “Цагдаа бүхий хэсгийг оргодол ба ноцтой

²⁴Я.Цэвэл Монгол хэлний товч тайлбар толь УБ 1966

гэмт хэргийг эрж баривчлах, шоронд хоригдогсдыг харгалзаж байх” үүрэгтэйгээр Шүүх яаманд шилжүүлсэн бөгөөд 1929 онд Цагдан сэргийлэх газрын дагаж явах дүрмийг баталсан.

Уг дүрмийн 35 дугаар зүйлд “Аливаа алдагдал мал буюу жич янагш чанагш явах хүмүүс бие дор авч явсан ба тээн явсан юм зүйлийг гээгдүүлэх нь тохиолдвоос даруй уул эзэн хүн дор таниулан тушаан өгвөөс зохимой. Хэрэв эзэн хүнд дав дув эс олдвоос зохих газраа мэдүүлж данслуулан уг зүйлийг сайнаар хадгалуулж, нэгэн тээгүүр учрыг тодорхойлон нийтэд зарлаваас зохимой²⁵. 45 дугаар зүйлд “Аливаа хулгай худал ба булаан уулаглах жич хүний амины зэрэг тохиолдвоос харьяа ялт хүнийг даруй түргэнээ санаа сүвэгчлэн байцан барьж, шүүх явдлын яамнаа мэдүүлэн хүргүүлж, шүүх шийтгүүлвээс зохимой. “ гэж тус тус заасан.

Цагдаагийн байгууллагын шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа нь улсыг аюулаас хамгаалах байгууллагын арга туршлагаар анх үүсч хөгжсөн түүхтэй. 1921-1932 онд цагдаагийн байгууллага нь Бүх цэргийн зөвлөл, Дотоод яам, Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны харьяа Цагдан сэргийлэх хороо, хэлтэс, газар байжээ. Энэ үед гүйцэтгэх ажил гэж байсангүй. Харин 1932 онд Дотоодыг хамгаалах газрын харьяанд шилжүүлэн авснаар Цагдан сэргийлэх байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг Дотоодыг хамгаалах газрын эсэргүүцэн тагнах үйл ажиллагааны туршлагаар нууц далд аргаар явуулах” болжээ.²⁶

Шуурхай эрэн сурвалжлах үйл ажиллагааг нууц аргаар тусгай хүч хэрэгслээр зохиох анхны аппарат 1934 онд “Эрүүгийн эрэн сурвалжлах тасаг” гэж байгуулагдсан бөгөөд 1936 оны 9 дүгээр сард Гүйцэтгэх хэлтэс болон өргөжсөн байна.

Цагдаагийн байгууллагын шуурхай эрэн сурвалжлах ажиллагааг эрүүгийн хэргийг эрэн сурвалжлах өмч ашиглан шамшигдуулагчидтай тэмцэх, насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх албадын гүйцэтгэх ажилтнууд эрхэлдэг байсан.

1940 оны Үндсэн хуулийн агуулга зарчимд нийцүүлэн 1949 оны 7 дугаар сарын 30-ны өдөр Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 4 дүгээр зарлигаар БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг баталсан. Энэ хууль нь 5 хэсэг, 26 бүлэг, 440 зүйлтэй тэр үеийн ЗСБНХУ-н Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хуулбарласан гэж зарим судлаачид үздэг. Энэ үеэс эрэн сурвалжилж баривчлахад тогтоолыг прокуророор батлуулж хүний эрхийг хангах тал дээр нилээд дэвшил гарчээ.

Нэг зуун жаран ес. Яллагдагчийн суугаа газар мэдэхгүй буюу оргон зайлсан бол мөрдөн байцаагчаас түүнийг эрж олох тухай тогтоол гаргана гэж хуульчилжээ.

1950-иад оноос Цагдан сэргийлэх байгууллагын бэхжүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлсний дүнд Цагдан сэргийлэх байгууллагыг Улсын цагдан сэргийлэх ерөнхий газар болон өргөтгөсөн.

БНМАУ-ын Дотоод явдлын яамны харьяа Улсын цагдан сэргийлэхийн дүрмийг 1955 оны 3 дугаар сарын 29-ний өдөр баталсан. Дүрмийн 3 дугаар зүйлд Улсын Цагдан сэргийлэхийн үүргийг тусгасан ба уг зүйлийн Ж-д “16 хүртэл насны багачууд ба бусад хүмүүс алга болж тэднийг гэмт хэрэг буюу цаг бусын аюулд хэлмэгдсэн гэж үзэх үндэс байвал уг хүмүүсийг эрэн сурвалжлана”²⁷ дүрмийн 6 дугаар зүйлийн Ж-д “Гэмт хэрэгт сэрдэгдсэн буюу хорих газраас оргон зугтсан хүмүүсийг мөрдөн хөөх ба эрэн сурвалжлах гэмт хэрэг өдүүлэх ба мөн олон нийтийн байдалд аюул учруулах явдлыг таслан зогсоох эрүүгийн хэргийг мөрдөн байцаахад эрүүгийн байцаан шийтгэх хуульд заагдсан ажиллагааг гүйцэтгэх, буу зэвсэг дэлбэрэх материал ба бодисыг хадгалах журмыг хэрхэн сахиж байгааг шалгах, паспортын журмыг хэрхэн сахиж байгааг шалгах зэрэг цагдан

²⁵ А.Думбарай БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын зарим эрхийн актууд УБ 1988

²⁶ А.Думбарай, С.Цэрэнхорлоо БНМАУ-ын ЦСБ-н түүх УБ 1984

²⁷ А.Думбарай БНМАУ-н ЦСБ-н зарим эрхийн актууд УБ 1988

сэргийлэх байгууллагуудын эхлэх ажил хамаарагдах бусад асуудлын талаар хүмүүсийн орон сууц, албан үйлдвэрийн газар, байгууллагуудаар нэвтрэн орно.”²⁸ БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1963 оны 10 дугаар сарын 25 ны өдрийн 499 дүгээр тогтоолоор БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын дүрмийг шинэчлэн баталсан. Энэ дүрмээр Цагдан сэргийлэх байгууллагын хэрэг бүртгэх болон шуурхай эрэн сурвалжлах ажилтай холбогдсон эдлэх эрх, үүргийг тодорхойлсон байна.

Энэхүү дүрмийн ерөнхий анги буюу 2 бүлэгт цагдан сэргийлэх байгууллагын үүргийг тусгажээ. Уг бүлгийн 4 дүгээр зүйлд “Хойно заасан хүмүүс ба эд хөрөнгийг эрэн сурвалжлана.”

А. Мөрдөн байцаалт ба шүүхийн байгууллага тэрчлэн эрүүгийн ба захиргааны шийтгэлийг эдэлж буй газраас оргон нуугдагчид

Б. Хүүхдэдээ хууль ёсоор тэтгэвэр төлөх явдлаас зайлсхийн нуугдсан хүмүүс

В. Улс, олон нийтийн байгууллага, ард иргэдийн хулгайлагдсан эд хөрөнгө

15-р зүйлд гэнт алга болсон хүмүүс нь гэмт хэрэг буюу аюул осолд хэлмэгдсэн гэж үзэх үндэстэй байдал тэднийг эрэн сурвалжлана.

27-р зүйлд Хулгайд алдагдсан ба оргон зугтсан гэмт этгээдэд ашиглагдсан авто машин, мотоцикл болон тээврийн бусад механикжсан хэрэглүүрийг эрэн сурвалжлана.

БНМАУ-ын АИХ-ын чуулганаар 1963 оны 12 дугаар сарын 24-ний өдөр ЭБШХ-ийг шинэчлэн баталсан нь 7 хэсэг, 36 бүлэг, 410 зүйлтэй бөгөөд 1964 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн байна²⁹. Энэ хуульд шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэх байгууллага өөр өөрсдийн эрх хэмжээний үүрэг хэмээн хуульчилж өгсөн давуу талтай.

Бүгд найрамдах монгол ард улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль 4-р зүйл. Эрүүгийн хэргийг үүсгэн явуулах ба гэмт хэргийг илрүүлэх үүрэгт. Гэмт хэргийн шинж тэмдэг илэрсэн тухайд шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэх байгууллага өөр өөрсдийн эрх хэмжээний дотор эрүүгийн хэрэг үүсгэж, гэмт хэрэг гарсан байдал ба гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох, түүнд ял шийтгэл оногдуулах талаар хуульд заасан бүх арга хэмжээ авах үүрэгтэй.

Уг хуулийн 122-р зүйлийн Хэрэг бүртгэх байгууллагын үүрэгт. Хэрэг бүртгэх байгууллага нь гэмт хэрэг ба түүнийг үйлдсэн этгээдийг олж илрүүлэхийн тулд зайлшгүй шаардлагатай шуурхай эрэн сурвалжлах ба эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан бусад арга хэмжээг авах үүрэгтэй.

Хэрэг бүртгэх байгууллага, гэмт хэргийг илрүүлсэн ба түүнийг бүртгэж эхэлсэн тухайгаа нэн даруй прокурорт мэдэгдэнэ. Хэрэг бүртгэх байгууллага мөрдөн байцаалтын хойшлуулшгүй ажиллагаануудыг арван дөрвөн хоногийн дотор гүйцэтгэж, мөн хугацааны дотор хэргийг мөрдөн байцаагчид шилжүүлнэ.

Гэмт хэргийг илрүүлэх ба хэрэгтэнг олох бололцоо байгаагүй хэргийг мөрдөн байцаагчид шилжүүлсний дараа хэрэг бүртгэх байгууллага нь мөрдөн байцаагчийн даалгавраар гэмт хэргийг илрүүлэх ба хэрэгтнийг олох талаар зайлшгүй шаардлагатай шуурхай эрэн сурвалжлах ажиллагаануудыг үргэлжлэн хийх үүрэгтэй. Гүйцэтгэсэн ажлынхаа дүнг тухай бүр мөрдөн байцаагчид мэдэгдэж байна.

Хэрэг бүртгэх, урьдчилсан мөрдөн байцаалт явуулах ерөнхий нөхцөлийн 135-р зүйл. Зарим даалгаварт. Хэрэг бүртгэгч буюу мөрдөн байцаагч өөр орон нутагт гүйцэтгэх шаардлагатай мөрдөн байцаалтын ба эрэн сурвалжлах зарим ажиллагааг өөрөө гүйцэтгэх буюу тухайн орон нутгийн хэрэг бүртгэх зохих байгууллага буюу мөрдөн байцаагчаар гүйцэтгүүлэхээр даалгах эрхтэй бөгөөд тэд нь тэрхүү даалгаврыг арав хоногийн дотор биелүүлэх үүрэгтэй. Урьдчилсан мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэс ба хугацаа 192-р

²⁸ А.Думбарай БНМАУ-н ЦСБ-н зарим эрхийн актууд УБ 1988

²⁹ БНМАУ хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл 1963 он. БНМАУ-ын хуулиуд 1. УБ., 180 дахь тал

зүйлд. Урьдчилсан мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэхийн өмнө мөрдөн байцаагч яллагдагчийн байхгүйгээр гүйцэтгэж болох мөрдөн байцаалтын бүх ажиллагааг гүйцэтгэх, яллагдагчийг олж илрүүлэх буюу гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тогтоох бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

Уг хуулийн яллагдагчийг эрэн сурвалжлах буюу 193-р зүйлд яллагдагчийн байгаа газар мэдэгдэхгүй байвал мөрдөн байцаагч эрэн сурвалжлах шаардлагатай арга хэмжээг авна. Мөрдөн байцаагч эрэн сурвалжлах ажлыг гүйцэтгүүлэхээр цагдан сэргийлэх байгууллагад даалгах эрхтэй бөгөөд энэ тухай тусгай тогтоол гаргана.

Эрэн сурвалжлах явдлыг урьдчилсан мөрдөн байцаалтын үед буюу хэргийг түдгэлзүүлэхийн хамт зарлана. Энэ хуулийн 87, 94-р зүйлд заасан үндэс бүхий байвал мөрдөн байцаагч эрэн сурвалжлуулж байгаа этгээдийн хувьд прокурорын зөвшөөрөлтэйгөөр цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авч болно³⁰.

Монгол Улсад социалист нийгмийн сүүлийн жилүүдэд цагдан сэргийлэх байгууллагын зохион байгуулалт үйл ажиллагааг үндсээр нь өөрчлөн сайжруулж боловсронгуй болгох шаардлага хурцаар тавигдах болсон. “БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын үндсэн үүрэг, эрхийн тухай” 96 зарлигийг АИХТ-ээс гаргаж, улмаар 1985 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Сайд нарын зөвлөлийн 95 тогтоолоор “БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын дүрэм”-ийг баталсан. “Гэмт хэрэг түнийг үйлдсэн этгээдийг олж, илрүүлэх, урьдчилан сэргийлэх таслан зогсоох зорилгоор зайлшгүй шаардлагатай шуурхай эрэн сурвалжлах үйл ажиллагааг явуулах”, “Эрэн сурвалжлах, мөрдөн байцаах ажиллагаа явуулах тухай прокурор мөрдөн байцаагчаас БНМАУ-ын ЭБШ хуулийн дагуу өгсөн заалт, даалгаврыг биелүүлэх мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад тэдэнд тус дэмжлэг үзүүлэх”, “Мөрдөн байцаалт шүүхээс оргосон яллагдагч, шүүгдэгч, шүүхийн таслан сэргийлэх тогтоол биелүүлэхээс зайлсхийсэн ялтан сураггүй алга болсон, хүүхдийн тэтгэвэр төлхөөс болон улс хоршоолол олон нийтийн байгууллагууд төлөх их хэмжээний өр төлбөрөөс зайлсхийсэн хүмүүс, түүнчлэн улс хоршоолол олон нийтийн байгууллага, иргэдийн хулгайлагдсан хөрөнгө алдагдсан буюу гээгдсэн байлдааны болон бусад галт зэвсгийг эрэн сурвалжлах” гэж үүрэг болгосон.³¹

Эндээс үзэхэд БНМАУ-ын Үндсэн хууль, БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн холбогдох зарлиг, НАХЯ-ны болон Улсын цагдан сэргийлэх байгууллын дүрмийн заалтад эрэн сурвалжлах ажил явуулах эрх зүйн үндсийг тусгаж, шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа явуулах нарийвчилсан зохицуулалтыг Цагдан сэргийлэх байгууллагын эрэн сурвалжлах ажлын тухай заавар, нэгдсэн тоо бүртгэлийн заавар, цагдан сэргийлэх байгууллагын эрэн сурвалжлах ажлын заавар, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах тухай заавар, эрүүгийн хэрэг үүсгэх, мөрдөн байцаалт явуулах хамтын ажиллагааны тухай зааварт тодорхойлсон байна.

1987 оны Цагдаагийн байгууллагын шуурхай эрэн сурвалжлах ажлын зааварт “Цагдаагийн байгууллага шуурхай эрэн сурвалжлах үйл ажиллагаандаа БНМАУ-ын хуулиуд, цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг, эрхийн тухай БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлиг, цагдан сэргийлэх байгууллагын дүрэм болон энэхүү заавар НАХЯ-ны сайд, УЦСЕГ-ын даргын тушаал, албан даалгаврыг удирдлага болгоно” гэжээ.³²

³⁰Б. Баярсайхан, Ч.Дашням, Д.Батжаргал, Ж.Энхнасан, Г.Оюунболд, Д.Сумъяацэрэн. Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал.2012он. 133-151 дахь тал

³¹ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт УБ 2000

³² А.Думбарай, С.Цэрэнхорлоо БНМАУ-н ЦСБ-н түүх УБ 1984

Монгол Улсад 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа баталж, улмаар 1993 онд УИХ-аас Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийг баталсан. Уг хуулийн 12-р зүйлд “Цагдаагийн байгууллага сураггүй алга болсон хүн, оргон нуугдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлана” гэж эрэн сурвалжлах ажлын эрх зүйн үндсийг заажээ.

1992 онд шинэ Үндсэн хууль батлан мөрдүүлсний дараа 1994 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар ЭБШХ-д зарчмын, томоохон нэмэлт өөрчлөлт оруулжээ. Энэ хуулийн 193-р зүйлд. Сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах. Сэжигтэн, яллагдагч оргон зайлсан байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрэн сурвалжлах шаардлагатай арга хэмжээг авна. Мөрдөн байцаагч эрэн сурвалжлах ажлыг гүйцэтгүүлэхээр цагдаагийн байгууллагад даалгах эрхтэй бөгөөд энэ тухай тогтоол гаргана.

Эрэн сурвалжлах явдлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед буюу хэргийг түдгэлзүүлэхийн хамт зарлана. Энэ хуулийн 87, 94 дүгээр зүйлд заасан үндэслэл байвал мөрдөн байцаагч эрэн сурвалжилж байгаа этгээдийг прокурорын зөвшөөрөлтэйгөөр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно³³.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох арга хэмжээ 94-р зүйлд. Энэ хуулийн 192 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан тохиолдолд хэргийг түдгэлзүүлсний дараа мөрдөн байцаах байгууллага өөрөө буюу цагдаагийн болон хэрэг бүртгэх бусад байгууллагатай хамтран гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох арга хэмжээ авах үүрэгтэй³⁴ хэмээн хамтын ажиллагааг хуульчилсан байна.

ЭБШХ-ийг 2001 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталж мөн оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн. Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын дүгнэснээр хэргийн бодит үнэнийг тогтоох, талуудын байцаан шийтгэх ажиллагаанд оролцох үүргийн бодит-практик тэнцвэрт байдлыг хангаж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг эрх зүйт төрийн үзэлд тохируулж олон улсын жишигт нийцсэн хууль болжээ.

Хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчийн эрх үүрэг буюу энэ хуулийн 28.2.15. өөр орон нутагт байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах, түүнчлэн гүйцэтгэх тодорхой ажиллагаа явуулах шаардлагатай бол энэ тухай даалгаврыг бичгээр гаргах ба түүнийг хүлээн авсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага заасан хугацаанд заавал биелүүлж хариуг цугларсан нотлох баримтын хамтаар хүргүүлэх гэж үүрэг болгосон байна.

Мөн хуулийн 29.1.1. хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны даргын эрх хэмжээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах замаар гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шуурхай зохицуулалт хийнэ гэж тусгажээ. Энэ хуулийн 205.2.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэхийн өмнө хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтэн, яллагдагчийн байхгүйд гүйцэтгэж болох бүх ажиллагааг явуулах, гэмт хэрэг үйлдсэн болон оргон зайлсан этгээдийг олж илрүүлэх бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

Энэ хуулийн 206 дугаар зүйлд Сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах гэж хуульчилжээ. 206.1-д Сэжигтэн, яллагдагч оргон зайлсан бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрэн сурвалжлах арга хэмжээг авна.

206.2.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор эрэн сурвалжлах ажлыг гүйцэтгүүлэхээр цагдаагийн байгууллагад даалгаж, энэ тухай тогтоол гаргана гэж заажээ³⁵.

³³Төрийн мэдээлэл. УБ 1994 он. №5

³⁴Б. Баярсайхан, Ч. Дашням, Д. Батжаргал, Ж. Энхнасан, Г. Оюунболд, Д. Сумъяацэрэн. Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. 2012 он. 339-340 дахь тал

³⁵Төрийн мэдээлэл. УБ 2002 он. №6.

1992 оны Захиргааны хариуцлагын тухай хуулийн 5-р зүйлийн 4-д зөрчил гаргасан этгээд захиргааны хариуцлага хүлээхээс оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно. Энэ тохиолдолд уг этгээдийг олж илрүүлсэн буюу түүний хэргээ илчлэн ирсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно.

2013 онд УИХ-аас баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 9.2.2-т “гэмт хэрэг, зөрчил гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах”, 12 зүйлд “цагдаагийн байгууллагын захиргааны үүрэгт 12.1.6 эрх бүхий байгууллага албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах”³⁶ гэж тус тус заасан.

2017 онд шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн 10 зүйл 10.1.3-д гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;

Мөн хуулийн 13дугаар зүйл захиргааны хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах, хэн болох нь тогтоогдоогүй цогцсыг таниулах ажиллагаа явуулах; нь захиргааны хяналт гэж үзсэн байна. Энэ хуулийн 38 дугаар зүйл 38.1.Цагдаагийн байгууллага дараахь хүн, эд зүйлийг олох зорилгоор эрэн сурвалжлах ажиллагааг шүүхийн шийдвэр, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн даалгаврын дагуу, эсхүл өөрөө санаачлан явуулна:

38.1.1.гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүн, эсхүл оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, ял оногдуулахыг тэнсэж албадлагын арга хэмжээ авагдсан хүн;

38.1.2.хулгайлагдсан, барьцаалагдсан хүн;

38.1.3.хэн болох нь тодорхойгүй цогцсыг тогтоох;

38.1.4.оршин суугаа газраасаа алга болсон хүн;

38.1.5.сураггүй алга болсон хүн;

38.1.6.эмнэлгээс оргосон сэтгэцийн өвчтэй хүн;

38.1.7.шүүхээс даалгасан бусад этгээд;

38.1.8.алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, тээврийн хэрэгсэл, мал, амьтан, түүх соёлын дурсгалт, үнэт болон бусад эд зүйл;

38.1.9.зам тээврийн ослын газраас зугтсан, алдагдсан тээврийн хэрэгсэл.

38.2.Хүнийг эрэн сурвалжлах тохиолдолд түүний ургийн овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүйс, төрсөн он, сар, өдөр, газар, үндсэн захиргаа, гэрэл зураг, биеийн өндөр, жин, онцлох содон тэмдэг, эрэн сурвалжлах үндэслэл зэрэг Хувь хүний нууцын тухай хуулиар хориглоогүй мэдээллийг олон нийтэд мэдээлж болно.

38.3.Хүний амь нас, эрүүл мэнд, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор террор үйлдэх, хүн худалдаалах, хүнийг алах, авлига, хүүхдийн эсрэг, гэр бүлийн хүчирхийллийн болон зохион байгуулалттай гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа хүн, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтны хувийн эрүүл мэндийн нууцад хамаарах бие эрхтний гажиг, халдварт өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг хуульд заасны дагуу олон нийтэд мэдээлж болно.

38.4.Эрэн сурвалжлах ажиллагааны үед шүүхийн зөвшөөрлөөр орон байр, бусад газарт нэвтэрч болно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.4 дүгээр зүйл. Эрэн сурвалжлах ажиллагаа

³⁶Цагдаагийн байгууллагын тухай хууль УБ 1993

1.Мөрдөгч дараахь хүн, хуулийн этгээд, эд зүйл, хөрөнгийг олох зорилгоор эрэн сурвалжлах ажиллагааг өөрийн санаачилгаар, эсхүл шүүхийн шийдвэр, прокурорын даалгавраар явуулна:

1.1.байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний хариуцагч, гэрч;

1.2.оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;

1.3.хулгайлагдсан, барьцаалагдсан хохирогч;

1.4.хэн болох нь тодорхойгүй цогцсыг тогтоох;

1.5.эмнэлгээс оргосон сэтгэцийн өвчтэй хүн;

1.6.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл.

2.Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага прокурорын шийдвэрийн дагуу яллагдагчийг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж, үр дүнг прокуророос тогтоосон хугацаанд танилцуулна гэж тус тус хуульчилсан байна.

2017 оны 05-р сарын 18-нд баталсан зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд судалгаа хийхэд эрэн сурвалжлах ажиллагаа явуулах талаар огт тусгаагүй байна. Мөн 2017 оны 05-р сарын 11-нд баталсан зөрчлийн тухай хуулинд зөрчил үйлдээд оргосон бол шийтгэл оногдуулах, хүндрүүлэх зүйл заалт ч хуульчлагдаагүй байна.

Дүгнэлт: Энэ бүхнээс үзэхэд цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ажиллагааны эрх зүйн хэм хэмжээ нь цагдаагийн байгууллагын хөгжилтэй салшгүй холбоотой байжээ. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг БНМАУ-ын АИХТ-с гаргасан зарлиг, Сайд нарын зөвлөлөөс баталсан цагдан сэргийлэх байгууллагын дүрэм, УИХ-ас баталсан хууль зэрэг эрх зүйн актуудыг тогтоож, тэдгээр эрх зүйн актуудыг үндэслэн эрэн сурвалжлах ажлыг зохицуулсан хэм хэмжээг НАХЯ, УЦСЕГ, ЦЕГ өөрсдийн эрх хэмжээний хүрээнд тогтоож байжээ.

1934 онд “Эрүүгийн эрэн сурвалжлах тасаг” гэж байгуулагдсан бөгөөд энэ үеээс эрэн сурвалжлах гэсэн нэр томъёо хэрэглэгдэх болон ба эрх зүйн зохицуулалтанд даруй түргэнээ санаа сүвэгчлэн байцаан барь, олох гэх зэрэг нэр томъёог хэргэлэн ирсэн. Харин 1955 оноос хойш эрэн сурвалжлах гэж нэрлэгдэх болсон байна. Одоо мөрдөгдөж байгаа Цагдаагийн албаны тухай хуулийн 38.1.1. зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүн эрэн сурвалжлахаар заасан байна. Зөрчлийн тухай хуулинд зөрчил үйлдээд оргосон бол шийтгэл оногдуулах, хүндрүүлэх зүйл заалт байхгүй. Мөн зөрчилд сэрдэгдсэн этгээд оргон зайлсан бол зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль эрэн сурвалжлах ажиллагаа явуулах талаар огт тусгаагүй байна. Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ASAP санд зөрчилд үйлдээд оргож эрэн сурвалжлагдаж байгаа нэгч зарлан мэдээлэл алга байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 38.1.1 Гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүн эрэн сурвалжлахаар заасан хэдийч Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хэргийн хянан шалгах тухай хуульд гэмт хэрэгт сэрдэгдсэн хүн гэх нэр томъёо, ойлголт байхгүй байна.

Санал

- Эрэн сурвалжлах ажлын талаар сүүлийн жилүүдэд дорвитой судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй байх тул онол практикийн түвшинд судлах
- Одоо мөрдөгдөж байгаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд эрэн сурвалжлах ажил явуулах үндэслэл болон эрэн сурвалжлах ажил явуулах процессийн ажиллагааг зааж өгөх
- Зөрчлийн тухай хуульд зөрчил үйлдээд, оргон зайлсан үйлдлийг зөрчилд тооцох
- Цагдаагийн байгууллагазөрчил үйлдээд оргосон этгээдийг эрэн сурвалжлах ASAP санд бүртгэн алба хаагчдад мэдээлдэг болох нь зүйтэй байна.

ДАВТАГДАХ ХӨДӨЛГӨӨНИЙ ОНОЛЫН ОЙЛГОЛТ, ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

П.Эрдэнэбаатар

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЭХХШЭЗ-ийн
тэнхимийн багш, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга

Гэмт хэргийн зураглалын ойлголт, түүний ач холбогдолын талаар энэхүү өгүүлэлд авч үзсэн болно.

Түлхүүр үг

Гэмт хэргийн зураглал, Гэмт хэргийн зураглал үйлдэх, Газар зүйн байрлал тодорхойлох, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хүрээлэн буй орчныг загварчлах.

2017 оны 07 дугаар сарын 01-ны өдөр шинээр батлагдан дагаж мөрдөгдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дүгээр зүйлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ. Баримтат мэдээлэл энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн авсан зураглал³⁷ байж болно гэсэн байна. Ийм учраас зураглал буюу гэмт хэргийн зураглалын талаар та бүхэнтэй саналаа солилцохыг хүслээ.

Гэмт хэргийн зураглал гэсэн ойлголт нь Монгол улсын хувьд шинэ бөгөөд тус системийг нэвтрүүлснээр гэмт хэргийн гаралтыг бууруулах, түүнчлэн гаралтаас урьчилан сэргийлэхэд ач холбогдолтой юм³⁸.

Хүн төрөлхтөний хөгжлийн түүхэн явцад газрын зураг нь гурван хэмжээст хөгжих хүртлээ 8000³⁹ гаруй жилийг замналыг туулсан байна.

Газрын зураг нь ямар нэг нутаг дэвсгэр дээрх объект болон бүс нутаг тэдгээрийн тайлбар, харилцан хамаарлыг тусгай дүрс тэмдэглэгээ ашиглан дүрсэлсэн зураглал юм⁴⁰.

Хүмүүс анх газрын зургийг хад чулууг агуйн хананд зурж эхлээд улмаар мал, амьтаны ширийг ашиглан зурж хүрээлэн буй орчноо дүрсэлдэг байсан. Газрын зураглалд аливаа газар орны уул, гол мөрөн, төмөр зам, нисэх онгоцны буудал, гудамж талбайн хаяг, нэрс, барилга байгууламжийг дүрслэн харуулахаас гадна, улс орнуудын хил хязгаарын зааглалыг тусгасан байдаг.

Дэлхийн улс орнуудын цагдаагийн байгууллагууд гэмт хэргийн илрүүлэлт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд гэмт хэргийн газрын зургийг өргөнөөр нэвтрүүлэн амжилттай ашиглаж байна.

Гэмт хэргийн газрын зураглал гэдэг нь гэмт хэрэг үйлдэгдсэн газрын байршлыг газрын зурагт тэмдэглэж байгаа үйлдэл юм.

Өөр хэлбэл гэмт хэргийн бүртгэлийг үйлдэгдсэн газартай нь уялдуулан байршуулж буй газар зүйн болон криминологийн шинжлэх ухааны мэдээллийн систем юм. Тухайлбал цагдаагийн алба хаагчийн өдөр бүр албандаа хэрэглэдэг хэрэгсэлтэй адил гэмт хэргийн газрын зураг нь гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн багаж болон хөгжиж байна.

Гэмт хэргийн газрын зураглалын үндэс нь 1800 оны дунд үед Францын сэтгэл судлаач Андре Гейри, Адолф Кютлет нар гэмт хэргийн гаралтыг бүртгэхээс эхэлсэн гэж үздэг.

³⁷ Uri Friedman (2013) “12 Maps That Changed the” нийтлэл

³⁸ Г. Оюунболд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. УБ., 2017. 31 дэх тал

³⁹ Цагдаа эмхэтгэл. УБ., 2015 /№3/ 122., 32 дахь тал

⁴⁰ <https://mn.Wikipedia.org>

1900 оны эхээр Америкийн Нэгдсэн Улсын Чикагогийн их сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ухааны эрдэмтэн багш нар гэмт хэргийн зураглалыг өнөөгийн түвшинд хүргэсэн гэж үздэг бөгөөд “Чикагогийн сургуулийн баг” гэж дэлхий дахинаа нэрлэгджээ. Энэхүү аргыг Иллинойс мужийн цагдаагийн газрын ажилтнууд 1926 оноос хүн амины гэмт хэргийн зураглалыг анх удаа харицсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг түүний төрөл, зүйлээр нь ялган өнгө өнгийн туг /зүү/ хатган нэвтрүүлж эхэлсэн.

Гэмт хэргийн зураглалын /Routine activity/ онол⁴¹ 1950-1979 онд Амос Хавлеу, Маркус Фалсон нарын хамтын бүтээлээс эхлэлтэй бөгөөд криминологийн шинжлэх ухааны нэгэн онол болон хөгжиж хэлсэн. Энэ онолын үндсэн санаа нь гэмт үйл явдлыг хүрээлэн буй орчинтой холбон тайлбарлах арга юм. Тухайлбал гэмт хэрэг, зөрчил үйлдэх эрсдэлтэй хүн, эсхүл аль хэдийнээ гэмт хэрэг үйлдсэн хүний зан авир, эцэг, эхийн удамшил, хувь хүний боловсрол, хүмүүжлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдэж буй эсэхийг судалдаг бусад онолоос ялгаатай. Өөр хэлбэл “ямар төрлийн гэмт хэрэг хаана хэдэн цагт үйлдэгдээд байна гэсэн асуултад хариулт өгдөгөөрөө онцлогтой юм.

Давдагдах хөдөлгөөний онолын үндэслэлээр гэмт хэргийн газрын зураглал үйлдэх аргыг цагдаагийн байгууллагууд хот, суурин, орон нутаг, нутаг дэвсгэрт бүртгэгдэж байгаа гэмт хэргийг бууруулах зорилгоор өргөн ашиглаж байна. Тухайлбал, Австрали, Бразил, Канад, Энэтхэг, Япон, Норвеги, Их Британи зэрэг олон орны цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үндсэн үүрэгтээ ашиглаж байна⁴².

Гэмт хэргийн зураглал үйлдэх аргыг хэрэглэсний дараагаар түүнд газар зүйн байрлалын хувьд үнэлгээ өгөх нь чухал бөгөөд хот, суурин, нутаг дэвсгэрийн хэмжээнд хаана, аль газарт, хэнд ямар хугацаанд чиглсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ явуулах бэ гэдгийг тодорхойлоход ач холбогдолтой.

Гэмт хэрэг гарч буй газар орны онцлог байдлыг ихэнх цагдаагийн байгууллагын ажилтнууд хэсэг хугацааны дараа мартдаг бөгөөд зураглал үйлдэх нь аливаа үйлдлийг эргэн сануулж байх түүнд харьцуулсан дүгнэлт өгөхөд тустай байна.

Цагдаагийн байгууллагын ажилтан, мөрдөгчийн объектын судалгаа үүнтэй төсөөтэй боловч бүхэлд нь гэмт хэргийн талаар мэдээлэл авахад хэрэглэгддэггүй талтай.

Сүүлийн үед бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй гэмт хэрэг, зөрчил, гэмт хэрэг болон тэдгээрийг үйлдсэн хүний талаарх мэдээ олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд тун хурдан тархаж байна. Энэ мэдээлэл үнэн эсэхээс үл шалтгааланнийгэмд айдас түгшүүр бий болгож байна. Үүнийг дагаад иргэд стресст орж бухамдан Хууль сахиулах байгууллага, Хууль тогтоох байгууллага, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдэл, нутаг дэвсгэр, засаг захиргааны удирдлагаа шүүмжлэх, ялангуяа цагдаагийн байгууллагад үл итгэх хандлага үүсэх, эрүүл, аюулгүй орчинд амьдарч байгаадаа эргэлзэх зэрэг маш олон сөрөг нөлөөллийг үүсгэдэг байна. Эндээс дүгнэн үзэхэд эрүү, нийтийн хэв журмын нөхцөл байдал жил ирэх бүр өсөн нэмэгдэх, цагдаагийн байгууллагын алба хаагч нарын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх уламжлалт арга барилыг өөрчлөх, нийгэмд үүссэн айдас, түгшүүрийг багасгах арилгах нь гэмт хэргийн газрын зураглал үйлдэх аргыг нэвтрүүлэх хэвших зүй ёсны шаардлага тулгарч байна.

Иймд гэмт хэргийн газрын зураглалыг практикт нэвтрүүлж өргөнөөр ашиглан хэрэглэснээр доорхи дурдсан дүгнэлтэнд хүрч болохоор байна. Үүнд:

1. Гэмт хэргийн зураглалыг тодорхойлж ашигласнаар тухайн хот, аймаг дүүрэг, хорооны нутаг дэвсгэрийн аль хэсэгт гэмт хэрэг, зөрчил гарч байгааг тодорхойлох, аль хэсэгт нь бага гарч байгааг тодорхойлох;

⁴¹Nicholas Brains (2015). Routine Activity Theory, University of California, Irvine

⁴² <http://www.criminology.mn>

2. Гэмт хэргийн бүртгэлийг нутаг дэвсгэрийн байршилтай уялдуулснаар бар, рестарон, сургууль, дэлгүүр, худалдааны төв, байрны орц, автомашины граж, олон нийтийн газар байгаа байршлийг тодорхойлох;

3. Гэмт хэргийн гаралтад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох;

4. Хүүхэд, гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргүүдийн гарч буй байршлыг тодорхойлох;

5. Автомашинт болон явган эргүүлийн хариуцан явах, хяналт тавих чиглэл, маршрутыг оновчтой тодорхой зохион байгуулах боломж гарах;

6. Цагдаагийн байгууллагаас тодорхой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор явуулдаг нэгдсэн арга хэмжээг оновчтой үр дүнтэй зохион байгуулах үндэс болох;

8. Гэмт хэрэг үйлдэж буй шалтгааныг, ямар хүн, хуулийн этгээд хохирогч болдог, гэмт хэрэг үйлдэгдэж буй цаг хугацааг тодорхойлох;

9. Тодорхой төрлийн ямар хэргүүд ямар давтамжтайгаар үйлдэгдэж байгааг тодорхойлох;

10. Эрүү болон нийтийн хэв журмын нөхцөл байдал ямар байгааг дүгнэх боломжийг бий болгох;

11. Мэдээлэл бодитой болсноор тухайн хот, дүүрэг, хорооны талаарх таагүй ойлголт өөрчлөгдөх хиймлээр үүссэн гэмт хэрэг, зөрчил, гэмт этгээдүүдийн талаар ойлголт алга болох;

12. Гэмт хэрэг гардаг эмзэг цэгүүд дээр ямар арга хэмжээ авч өөрчлөх зэрэг судалгаанд үндэслэсэн үр дүнтэй ажил зохион байгуулах, эерэг үр дүн авчирах;

13. Гэмт хэрэг, зөрчил ихээр гардаг гудамж талбайг камержуулах бодитой ажил хийхэд ач холбогдол өгөх;

14. Шинжлэх ухаан технологи ашиглан газар зүйн томоохон өгөгдлийн нэг болох Geocoding буюу хаяг байршлын системд тулгуурлан хийх;

14. Гэмт хэргийг мөрдөн шалгах явцад тухайн хэргийн олдсон эд мөрийн баримт, гэрчийн үзсэн харсан, хэрэгтэн аль байршилд харагдсан болон зугтсан гэх мэт олон үзүүлэлтүүдийг илүү дэлгэрэнгүй байдлаар дэлгэн гэмт хэргийн илрүүлэлтэнд ашиглахад ач холбогдолтой юм.

ГАЛТ ЗЭВСГИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ СУДАЛСАН НЬ

Б.Хулан

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
багш, магистр, цагдаагийн дэслэгч

Удиртгал

Төр нийгэм, эдийн засгийн хөгжлийн хурдацыг тэнцвэржүүлэх, нийгмийн үйлдвэрлэлийг өсгөх зорилгоо хэрэгжүүлэхдээ татварын механизмыг ашиглана. Аливаа татвар төрийн байр суурь, бодлого дээр үндэслэх бөгөөд төрийн бодлого, нийгэм эдийн засгийн бааз, татвар төлөгчийн санхүүгийн чадавхи, татвараа төлөх ухамсар зэрэг олон хүчин зүйлүүдээс хамаарал ихтэй. Татварын бодлого нь улс төрчдөөс тодорхойлогдож, хууль тогтоох байгууллагаас батлагдаж, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаагаар хэрэгжинэ.

Тогтвортой хөгжлийн нэг зорилт нь төсөв, худалдааны тэнцлийг тэнцвэржүүлэхэд оршдог бол нийгмийн хөгжилд улсын санхүүгийн хэрэгцээг бүрдүүлэх, улс нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлэхэд татвар жолоодлого болно.

Татвар ногдуулалтад тэгш, шударга хандах нөхцлийг бүрдүүлэх нь төрийнбодлого зохицуулалтын үүргээ хэрэгжүүлэх түүн дотроо орлого хуваарилалтын үүрэгтэй нягтуялдаатай учир нийгмийн бүх гишүүдийн эрх ашгийг хөнддөг асуудал юм. Иймээс улсорнууд татварын бодлогодоо татвар ногдуулах суурь, татварын хувь хэмжээнд ялгаатай янзбүрийн төрөл хэлбэрүүдийг ашигладаг байна.

Энэ нь татварын системийг шударгатэгш байдалд уруу чиглүүлэх янз бүрийн арга замуудыг хайж буй оролдлого болно.Татварын бодлого засгийн газар (төр), татвар төлөгчийн аль алиных нь амьдрахчадварт сөрөг нөлөөлөхгүй, татвар ногдуулах бааз суурь бага, татварын хувь хэмжээ өндөр байвал татварын хөнгөлөлт,чөлөөлөлт, зээл нэмэгдэнэ. Энэ нь татвар төлөгчдөд ачааллыг нэмэгдүүлэх, мөнхөнгөлөлт, чөлөөлөлт, татварын зээл нэмэгдснээр татварын тэгш, шударга хандах зарчималдагдаж, ялгаварлыг бий болгоход хүргэнэ.

Манай улсад 2015 оноос өмнө галт зэвсгийн албан татварын асуудал нь “Бууны албан татварын тухай” хуулиар зохицуулагдаж байсан ба энэхүү хууль нь 1993 оны 5 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан бөгөөд 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр IV зүйлд албан татварын хэмжээг зааж улмаар 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдөр шинэчлэн найруулж “Галт зэвсгийн албан татварын тухай” хууль болж батлагдсан ба 2015 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Түлхүүр үг

Галт зэвсэг, татвар, татвар төлөгч, өмчлөгч

Галт зэвсгийн албан татварын тухай хуульд заасан галт зэвсгийн албан татвар төлөгч өөрийн өмчлөлд байгаа галт зэвсгийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор Цагдаагийн байгууллагад бүртгүүлж албан татварыг тогтоосон хугацаанд төлөх, эвдэрч ашиглагдахгүй болсон галт зэвсгийг зохих журмын дагуу бүртгэлээс хасуулах үүрэгтэй.

Харин цагдаагийн байгууллага галт зэвсгийн бүртгэл, хөдөлгөөний мэдээг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний дотор тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд гаргаж өгөх үүрэгтэй.

Одоогийн байдлаар 2017 онд иргэн, хуулийн этгээдэд 47256 галт зэвсэг бүртгэлтэй байснаас бүртгэл, тооллогонд 41093 галт зэвсэг буюу бүртгэлтэй галт зэвсгийн 86.9 хувь хамрагдсан.

Тооллогонд хамрагдсан галт зэвсгийг зориулалтаар нь авч үзвэл:

- ан агнах – 44592
- харуул хамгаалалтын – 1522
- спорт-сургалтын – 634
- үзмэр урлагын – 301
- цуглуулгын – 225

Нийт 47256 галт зэвсэг иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байна.

Аймгуудын болон нийслэлийн галт зэвсгий албан татвар төлөгчийн статистикийг авч үзье.

Хүснэгт №1. Галт зэвсгийн албан татвар төлөгчийн тоо /аймгаар/

Аймаг	006	007	008	009	010	011	012	013	014	015	016
Архангай	,472	,691	,714	,907	,842	,146	,133	,512	,525	,316	,402
Баян-Өлгий	,797	,961	,063	,932	,718	,674	,666	,542	,740	,954	,275
Баянхонгор	,941	,032	,191	,196	,666	,843	,790	,355	,765	,945	,996
Булган	,783	,780	,810	,731	,593	,585	,583	,265	,902	,945	,936
Говь-Алтай	,185	,172	,319	,932	,656	,483	,471	,445	,452	,432	,600
Дорноговь	,023	,044	,088	,019	,009	69	44	,123	22	90	,000
Дорнод	,189	,126	,170	,180	,176	,125	,125	,126	,157	,164	,312
Дундговь	26	84	23	46	97	04	79	21	78	44	28
Завхан	,120	,135	,952	,097	,159	,057	,042	,255	,467	,100	,991
Өвөрхангай	,469	,515	,472	,364	,295	,283	,301	,228	,331	,453	,656
Өмнөговь	21	93	53	78	97	,040	,046	,017	,216	,150	,178
Сүхбаатар	15	45	04	57	01	26	91	10	29	06	26
Сэлэнгэ	27	81	27	16	47	43	77	42	35	51	,022
Төв	74	89	46	26	79	45	47	13	14	03	08
Увс	,398	,489	,615	,432	,287	,342	,222	,249	,345	,341	,419
Ховд	,642	,826	,649	,797	,398	,352	,231	,113	,414	,358	,279
Хөвсгөл	,230	,974	,192	,246	,495	,432	,430	,516	,718	,903	,157
Хэнтий	,504	,594	,740	,865	,278	,310	,310	,431	,421	,575	,492
Дархан-Уул	65	61	20	81	06	31	28	42	36	00	38
Орхон											

	22	25	73	58	43	68	74	26	23	20	61
Нийт	2,60 3	2,21 7	2,92 1	1,66 0	9,24 2	7,25 8	6,79 0	5,63 1	8,59 0	0,15 0	0,37 6

Эх сурвалж: <http://www.mta.mn>

Дээрх хүснэгтээс үзэхэд Хөвсгөл, Архангай, Завхан аймгууд галт зэвсгийн албан татвар төлөгчийн тоогоороо тэргүүлдэг байна. Харин Дархан-Уул, Дундговь, орхон аймгууд хамгийн бага татвар төлөгчтэй байна.


Хүснэгт №2. Нийслэлийн галт зэвсгийн албан татвар төлөгчийн тоо /дүүргээр/.

Татварын хэлтэс	005	006	007	008	009	010	011	012	013	014	015	016
Хан-Уул	67	02	54	88	35	53	21	17	45	44	65	,043
Баянзүрх	28	21	23	65	20	83	,129	,130	,348	567	,642	,795
Сүхбаатар	88	17	96	33	28	32	31	25	56	54	,051	,136
Баянгол	25	90	20	34	90	,028	,205	,206	,390	407	,694	,550
Багануур	66	99	93	72	66	97	05	11	18	56	72	70
Багахангай	6	7	7	5	5	5	5	5	5	5	4	4
Налайх	63	65	69	77	70	81	78	94	71	70	99	97
Говьсүмбэр	02	3	00	4	2	4	1	3	5	4		4
Сонгино хайрхан	30	98	88	60	66	52	71	91	75	72	,087	,109
Чингэлтэй	14	95	42	78	85	03	29	18	37	38	05	13
Нийт	,419	,617	,722	,236	,687	,958	,195	,220	,990	,857	,754	,031

Эх сурвалж: <http://www.mta.mn>

2016 оны байдлаар нийслэлийн хэмжээнд Сүхбаатар болон Баянгол дүүргүүдэд галт зэвсгийн албан татвар төлөгч хамгийн их байдаг бол Говьсүмбэр аймаг энэ төрлийн албан татвар төлөгч хамгийн бага байдаг байна. Мөн сүүлийн жилүүдэд энэ төрлийн албан татвар төлөгч ихэнх дүүргүүдэд нэмэгдсэн байна. Нийслэлийн галт зэвсгийн албан татвар төлөгч нийт татвар төлөгчийн хэдэн хувийг эзэлж байгааг дараах графикт харуулав.

График №1. Нийслэлийн галт зэвсгийн албан татвар төлөгчийн нийт татвар төлөгчийн тоонд эзлэх хувь



Эх сурвалж: <http://www.mta.mn>

Дээрх графикаас харахад ногоон өнгийн буюу Багахангай дүүргийн үзүүлэлт хамгийн өндөр байна. 2016 оны байдлаар Багахангай дүүргийн нийт татвар төлөгчийн 6.79% нь галт зэвсгийн албан татвар төлөгч байгаа ба өмнөх онуудтай харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна. Гэвч татвар төлөгчийн тоог үзвэл тогтмол үзүүлэлттэй байна. Харин бусад дүүргүүдийг ерөнхийд нь авч үзвэл 2005 оноос 2016 оныг хүртэл уг албан татвар төлөгчийн эзлэх хувь зарим жилүүдэд багахан өссөнийг үл тооцвол тогтмол буурсан боловч хүснэгтээс харахад сүүлийн хоёр жилд уг татвар төлөгчийн тоо өссөн байна.

Галт зэвсгийн албан татварыг бууны төрлөөс нь хамууруулан тогтмол дүнгээр ногдуулдаг бөгөөд 1993 оноос 2014 оныг хүртэл зөвхөн нэг л удаа 1997 онд хувь хэмжээ нь өөрчлөгдөж байсан. Харин 2015 онд тус татварын хувь хэмжээнд дахин өөрчлөлт орсон. Ийнхүү өөрчлөлт орохоос өмнө дараах хэмжээний албар татвар ногдуулдаг байсан. Үүнд:

- Үрлэн сумтай болон 6.4 мм хүртэлх калибрын бүх төрлийн галт зэвсэгт 4000 төгрөг
- 6.5 ба түүнээс дээш мм-ийн калибрын бүх төрлийн галт зэвсэгт 6000 төгрөгийн албан татвар тус тус ногдуулна.⁴³

Дээрх хэмжээгээр 20 гаруй жил татвар ногдуулсан бөгөөд галт зэвсэг эзэмшигчдийн эзэмшиж буй галт зэвсгийн төрлөөс хамаарч ногдох татварын хэмжээ өөр өөр байх бөгөөд 2015 оноос жил бүр дараах хэмжээний албан татвар төлөх болсон. Үүнд:

- Үзмэр, цуглуулга, спорт-сургалтын зориулалттай галт зэвсэгт 15000 төгрөг
- Үрлэн сумтай болон 6.4 мм хүртэлх калибрын бүх төрлийн ан агнуур, харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэгт 30000 төгрөг

⁴³ <http://license.police.gov.mn/news/content/id/1044/type/123/menuid/67>

- 6.5 ба түүнээс дээш мм-ийн калибрын бүх төрлийн ан агнуур, харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэгт 60000 төгрөгийн албан татвар тус тус ногдуулна.⁴⁴

Дээрх хувь хэмжээг 1993 оны хуулийн заалттай харьцуулахад үзмэр, цуглуулга, спорт-сургалтын зориулалттай галт зэвсэгт албан татвар ногдуулах болсон бөгөөд үрлэн сумтай болон 6.4 мм хүртэлх калибрын бүх төрлийн галт зэвсэгт ногдуулах албан татвар 7.5 дахин, 6.5 ба түүнээс дээш мм-ийн калибрын бүх төрлийн галт зэвсэгт ногдуулах татвар 10 дахин нэмэгдсэн байна.


Цагдаагийн байгууллага галт зэвсгийн бүртгэл, тооллого явуулах ажлыг хариуцан гүйцэтгэх бөгөөд холбогдох хуулийн дагуу хяналт тавин ажилладаг. Жил бүрийн 12 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө цагдаагийн байгууллага олон нийтэд зарлан галт зэвсгийн тооллогын ажлыг гүйцэтгэх бөгөөд 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор татварын албанд мэдээ гаргаж өгдөг.

Галт зэвсэгтэй холбогдох аливаа асуудалд цагдаагийн байгууллага хяналт тавих ба албан татвар төлөлтөнд татварын алба хяналт тавьж ажиллана. Өөрөөр хэлбэл галт зэвсгийн албан татварын хуулинд хяналт тавихад татварын албанаас гадна цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нягт хамааралтай ажилладаг.

Аливаа улсын татварын бодлогын хэрэгжилт, тогтолцооны төлөв байдал, түүнийг бүрдүүлж буй бүтцийн үр дүнгээр тодорхойлогддог ба татвар нь тодорхой хэсгүүдээс тогтох бөгөөд тэдгээр нь өөр хоорондоо харилцан нэгдлийн хангах систем гэж үзвэл түүний элементүүд, тэдгээрийн өөрчлөлт хувьсал нь тухайн сиситемийн бүтцийг өөрчлөлтийг харуулна.

Бүтцийг шинжлэх нь судлагдахууны бүтцийн дотоод элементүүдийг илрүүлэх, түүний оршин буй тогтолцоог судлах арга болно. Манай улсын төсвийн орлогын дийлэнх хувийг буюу 78-аас дээш хувийг татварын орлого дангаараа эзэлдэг. Өөрөөр хэлбэл, татвар бол манай улсын төсвийн орлогын гол эх үүсвэр мөн. Дараах графикт Монгол улсын төсвийн орлогын бүтцийг хувиар илэрхийлсэн, 2002–2017 оны үзүүлэлтийг харууллаа.

График 2.МУ-ын төсвийн орлогын бүтэц /2005-2017 он, хувиар/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, www.nso.mn

⁴⁴ “Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 3.1-р зүйл

Дээрх графикаас харахад 2005–2017 оны төсвийн орлогод татварын орлогын эзлэх дүн тогтвортой, 78 хувиас дээш байгаа тул татварын орлого, түүнтэй холбогдох аливаа асуудлууд судлаачдын хувьд чухал асуудал байсаар байна. Улмаар шууд татварын нэгэн төрөл болох галт зэвсгийн албан татварын өнөөгийн байдал, өмнөх жилүүдийн үзүүлэлтүүдээс хэрхэн өөрчлөгдсөнийг судлав. Дараах графикт татварын орлогод галт зэвсгийн албан татварын эзлэх хувийг харууллаа.

График №3. Галт зэвсгийн татварын орлого /2002-2016/



Эх сурвалж: <http://www.1212.mn>, www.mta.mn

Дээрх графикаас харахад манай улсын галт зэвсгийн татварын орлого 2002-2010 оныг хүртэл тогтмол байснаа 2015 он хүртэл аажмаар өсөөд 2016 онд огцом өсч тус татварын орлогын түүхэн дэх хамгийн өндөр дүнд хүрсэн байна. Харин татварын нийт орлогод эзлэх хувиар нь авч үзвэл 2002 болон 2003 онд 0.06-аас дээш хувийг эзэлж байсан ба түүнээс хойш тасралтгүй буураад 2016 онд 0.046%-ийг эзэлжээ. Тухайн татварын орлого өссөн ч нийт татварын орлогод эзлэх хувь

1%-д ч хүрэхгүй байна.

2016 онд уг татварын орлогын дүн ийнхүү өссөн гол шалтгаан нь хуулийн өөрчлөлттэй холбоотой. Өөрөөр хэлбэл 2015 оны 3 дугаар улирлаас уг татварын хувь хэмжээ нэмэгдсэн тул 2016 онд галт зэвсгийн албан татварын орлого өмнөх жилүүдийн дунджаас 7 дахин өссөн байна.

Албан татвар төлөлтөөрөө буюу галт зэвсгийн албан татварын орлогоороо Архангай, Хөвсгөл аймгууд болон Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүд тэргүүлдэг боловч нийт татварын орлогод эзлэх хувиар нь авч үзэхэд Баян-Өлгий, Говь-Алтай, Архангай, Хөвсгөл, Завхан аймгууд болон Багануур, Налайх дүүргүүдийн үзүүлэлт бусад аймаг, дүүргийн үзүүлэлтээс өндөр байна.

Өмнө нь Бууны албан татварын тухай хуулиар галт зэвсэг эзэмшигчид ердөө жилд 4-6 мянган төгрөгийн татвар улсад төлдөг байсан. Энэ нь сумны үнээс ч хямд өртөг юм. Харин хууль шинэчлэгдсэнээр энэ хувь хэмжээ 7.5-10 дахин нэмэгдсэн бөгөөд ингэснээр тус татварын орлого 1,413,576,000 төгрөгөөр мөн нэмэгдсэн байна.

Галт зэвсгийн албан татварыг тайлагнадаггүй бөгөөд зөвхөн гэрчилгээний 15 дугаар хуудсанд татвар төлсөн тэмдэглэгээ хийлгэдэг.

Галт зэвсгийг хэрэглэж, эзэмших иргэдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Тухайлбал манай улсад 47 мянга гаруй галт зэвсэг иргэн, байгууллагын нэр дээр бүртгэлтэй байдгаас 44 мянга нь ангийн буу юм. Өмчлөлд байгаа галт зэвсгийг марк, төрлөөр нь авч үзвэл Тоз-8, Сайга, ЗКК-600, Винтов, Карабин, Иж-18 зэргийг ихэвчлэн ашигладаг бөгөөд зарим тохиолдолд байлдааны зориулалттай АКМ, Бирдан, Медведь, Мазаров гэх мэт галт зэвсгийг өмчилж, ашиглаж байна.

Галт зэвсэг гэдэг орчин тойрон, бусдад аюул учруулж болзошгүй онцгой бараа билээ. Тиймээс галт зэвсэг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулсан хуультай болж, түүнийгээ дагаж мөрдөх шаардлага тулгарсан юм.

Энэ ч үүднээс 2001 онд батлагдсан Галт зэвсгийн тухай хуулийг хуучирсан, ач холбогдолгүй гэж үзэн шинэчлэн найруулсан нь 2015 онд батлагдсан. Галт зэвсгийн албан татварын тухай хууль нь галт зэвсгийн тухай хууль, түүнд холбогдох бусад хууль эрх зүйн акттай холбогдон хэрэгждэг тул галт зэвсгийн тухай хууль өөрчлөгдөхөд мөн шинэчлэн батлагдсан. Галт зэвсгийн албан татварын хуулийг бусад татварын хуультай харьцуулахад 1993 оноос буюу батлагдсанаасаа хойш хамгийн бага өөрчлөлт орж, тогтмол мөрдөгдсөн хууль юм.

Галт зэвсгийн тухай хуульд галт зэвсгийг дөрвөн зориулалтаар ашиглахыг зөвшөөрчээ. Үүнд:

- Иргэний
- Харуул хамгаалалтын
- Хууль сахиулах албаны
- Байлдааны зориулалттай зэрэг болно.

Энэ заалттай холбогдон татвар ногдох галт зэвсэгт иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг хамаарч байна.

Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангахад татварын алба цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг. Өөрөөр хэлбэл, галт зэвсгийн тооллого болон бүртгэл, хасалтыг цагдаагийн байгууллага хариуцан хийнэ. Улмаар тооллогын дүн мэдээг татварын албанд хүргүүлдэг. Уг албан татварыг тогтмол дүнгээр ногдуулдаг бөгөөд тайлагнадаггүй.

Энэ татварын хуулийн хэрэгжилтийг илэрхийлэх гол үзүүлэлт бол төсөвт төвлөрсөн орлогын хэмжээ юм. 2016 онд татварын орлого огцом өссөн нь тус хуулийн хувь хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой бөгөөд энэ нь хууль хэрэгжилтийн байдлыг илтгэж байна. Харин бүх татвар ногдох галт зэвсэг эзэмшигчид албан татвараа төлж байгаа эсэх нь бүртгэлтэй галт зэвсгээс тооллогонд хамрагдаж улмаар татвараа төлсөн байдлаар тодорхойлогдох бөгөөд цагдаагийн байгууллагын жил бүр цахим хуудсандаа мэдээллэсэн тооллогын мэдээнээс үзэхэд тооллогонд бүртгэлтэй бүх галт зэвсэг тоологддоггүй байна. Тиймээс галт зэвсгийн тооллогод бүх галт зэвсэг хамрагдаж байгаа эсэх нь эргэлзээтэй бөгөөд галт зэвсэг худалдан борлуулах, импортлох зэрэг асуудалд өндөр хяналт тавих, хууль эрх зүйн орчныг нь сайжруулах шаардлагатай байна.

Хэрэв тооллогын хугацаанд галт зэвсгээ бүртгүүлээгүй, эзэмшигчийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн хуулийн дагуу иргэнийг 40-80 мянга, хуулийн этгээдийг 100-250 мянган төгрөгөөр тус тус торгоно.⁴⁵ Сүүлийн жилүүдэд галт зэвсэгтэй холбоотой үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо буурахгүй байна. Галт зэвсэг ашиглан хууль бусаар ан амьтан агнадаг, цаашлаад хүний амь насанд халддаг, галт зэвсгийн хулгайн гэмт хэрэг гарах тохиолдол байгаа. Ер нь зэвсгийн тооллого явуулж, галт зэвсэг тухайн эзэмшигчдээ байгаа эсэхийг шалгаж, бусдад шилжүүлсэн эсэхийг тодруулсанаар дээр

⁴⁵ <http://www.montsame.mn/read/72414>

дурьдсан гэмт хэргүүд үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх болон татвар төлөлтийг хянах ач холбогдолтой юм.

Дүгнэлт

Манай улсад 2015 оноос өмнө галт зэвсгийн албан татварын асуудал нь “Бууны албан татварын тухай” хуулиар зохицуулагдаж байсан. Энэ хууль нь 1993 оны 5 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан бөгөөд 8 зүйлтэй, 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр IV зүйлд (албан татварын хэмжээ) өөрчлөлт орж байсан. Харин уг хууль нь галт зэвсгийн тухай хуулийн шинэчлэлтэй холбогдон шинэчлэн батлагдсан. Ийнхүү гол өөрчлөгдсөн зүйл нь татварын хувь хэмжээ юм. 2015 оны 3 дугаар улирлаас дагаж мөрдөгдөж буй хувь хэмжээний өөрчлөлт цаг үеэ мэдэрсэн өөрчлөлт байлаа. Учир нь уг хувь хэмжээ өөрчлөгдөөгүй 20 гаруй жил болжээ. Жилд дөрвөөс зургаан мянган төгрөгний татвар төлж байсан нь сумны үнээс ч бага дүн юм.

Одоо мөрдөгдөж буй хувь хэмжээг 1993 оны хуулийн заалттай харьцуулахад үзмэр, цуглуулга, спорт-сургалтын зориулалттай галт зэвсэгт албан татвар ногдуулах болсон бөгөөд үрлэн сумтай болон 6.4 мм хүртэлх калибрын бүх төрлийн галт зэвсэгт ногдуулах албан татвар 7.5 дахин, 6.5 ба түүнээс дээш мм-ийн калибрын бүх төрлийн галт зэвсэгт ногдуулах татвар 10 дахин нэмэгдсэн байна. Энэхүү өөрчлөлт нь уг татварын орлогыг мөн өөрчлөхөд шууд нөлөөлсөн. 2016 онд галт зэвсгийн албан татварын орлого өмнөх жилүүдийн дунджаас 7 дахин өссөн байна.

Манай улсын төсвийн орлогын дийлэнх хувийг буюу 78-аас дээш хувийг татварын орлого дангаараа эзэлдэг. Галт зэвсгийн албан татварын нийт татварын орлогод эзлэх дүн 2015 оныг хүртэл тогтмол байсан ч 2016 онд түүхэн дэх хамгийн өндөр хэмжээнд хүрсэн бөгөөд дийлэнх ангын зориулалттай бууны татварын орлого эзэлж байгаа нь ангын зориулалттай галт зэвсэг эзэмшигч их байгааг илэрхийлж байна.

Галт зэвсгийг хэрэглэж, эзэмших иргэдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Тухайлбал манай улсад 47 мянга гаруй галт зэвсэг иргэн, байгууллагын нэр дээр бүртгэлтэй байдгаас 44 мянга нь ангын буу юм. Өмчлөлд байгаа галт зэвсгийг марк, төрлөөр нь авч үзвэл Тоз-8, Сайга, ЗКК-600, Винтов, Карабин, Иж-18 зэргийг ихэвчлэн ашигладаг бөгөөд зарим тохиолдолд байлдааны зориулалттай АКМ, Бирдан, Медведь, Мазаров гэх мэт галт зэвсгийг өмчилж, ашиглаж байна. Үүнийгээ дагаад холбогдох хуулийн хэрэгжилт, хяналтын асуудал чухал болж байна.

Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангахад татварын алба цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг. Өөрөөр хэлбэл, галт зэвсгийн тооллого болон бүртгэл, хасалтыг цагдаагийн байгууллага хариуцан хийнэ. Улмаар тооллогын дүн мэдээг татварын албанд хүргүүлдэг. Уг албан татварыг тогтмол дүнгээр ногдуулдаг бөгөөд тайлагнадаггүй.

Санал

Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, татвар төлөгч, татвар ногдуулалтын өнөөгийн байдалтай холбогдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Татварын алба татварын орлогын дийлэнхийг бүрдүүлдэг ААНОАТ, ХХОАТ, НОАТ, ГАТ зэргээс бусад буюу 1 хүрэхгүй хувийг бүрдүүлдэг галт зэвсгийн албан татвар болон бусад татварын хуулийн хэрэгжилт, статистик мэдээллийг тогтмол шинэчилж, судалж байх, статистик мэдээ гаргалтыг сайжруулж, дэлгэрүүлэх;
- Галт зэвсэг эзэмшигчийн тоо өсөхийн хэрээр холбогдох байгууллагууд тавих хяналтаа сайжруулах шаардлагатай тул татвар ногдох галт зэвсгийн бүртгэлийг шинэчилж байх;
- Малчдын галт зэвсгийн албан татвар төлөлтөнд хяналт тавих;

- Татвар ногдох бууны статистик мэдээллийг нарийвчлан гаргадаг байх. Жишээ нь АНУ-ын галт зэвсгийн албан татвар төлөлт болон галт зэвсгийн хөдөлгөөний мэдээ боловсруулалтын туршлагаас суралцах;
- Татвар төлөх ухамсарыг багаас нь төлөвшүүлж, татварын боловсролыг анхаарах. Тухайлбал:Иргэд зэвсгийн гэрчилгээний арын хуудастай танилцдаггүй, мэддэггүй учраас галт зэвсэг эзэмшигчийнхээ үүргийг бүрэн мэддэг болгох талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;
- Галт зэвсгийн нэгдсэн санг боловсонгуй болгох гэх мэт.

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Д.Ариужин

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн ахлах багш

Мэдээлэл технологийн хөгжил хувь хүн, байгууллагын хөгжил төдийгүй улс орныг хөгжлийг илэрхийлэх чухал хэмжигдэхүүн болоод байна.

Мэдээлэл харилцаа, холбооны нэгдсэн сүлжээнд холбогдох нь аливаа байгууллагын аюулгүй байдал, түүний дотор мэдээллийн аюулгүй байдалд тодорхой хэмжээгээр нөлөөлж, хууль эрх зүй, энэ талаар хэрэгжүүлэх бодлого зэрэгт харгалзан үзэж, өөрчлөн шинэчлэх шаардлагыг бий болгож байна.

Мэдээлэл технологийн чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч аюулгүй байдал, хөгжлийн бодлого, эрх зүйн орчин хоцрогдож буй нь ажиглагдаж байна⁴⁶.

Тиймээс энэхүү илтгэлийн хүрээнд ХСИС-ийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт хэрхэн бүрдсэн байдал, мэдээллийн сүлжээний зохион байгуулалт, техник технологийн түвшин, техник хэрэгслийн ашиглалт, хамгаалалт, “Check point” ашиглан сүлжээний урсгалд хийсэн шинжилгээний тайлан, судалгааны дүн, цаашид анхаарах зарим асуудлыг хөндөхийг зорилоо.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 229 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн салбарын боловсон хүчин бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уялдааг сайжруулах зорилгоор Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд Дотоод хэргийн их сургууль байгуулсан билээ.

Улмаар МУ-ын Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 87 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийг хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд “Хууль сахиулахын их сургууль” болгон өөрчлөн зохион байгуулж, Хууль зүйн сайдын 2015 оны 7 дугаар сарын 3-ний өдрийн А/148 дугаар тушаалаар ХСИС-ийн дүрмийг шинэчлэн баталсан байна. Уг дүрэмд зааснаар “Их сургууль нь төрийн өмчид суурилсан, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай, эрдэм шинжилгээ-сургалт үйлдвэрлэлийн хэв шинж бүхий дээд боловсролын, төрийн тусгай чиг үүргийн бие даасан байгууллага мөн”.

Их сургууль нь хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах байгууллагын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх чиг үүрэг бүхий бүрэлдэхүүн сургууль болон харьяа сургуультай байхаас гадна мэдээлэл, технологийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх цэргийн албаны зохион байгуулалт, аюулгүй байдлын газар, түүний харьяа алба нэгжтэй байна. Энэ талаар ХСИС-ийн дүрмийн 25 дугаар зүйлийн 25.2-д “Цэргийн аюулгүй байдлын газарт Цэргийн зохион байгуулалтын, Мэдээлэл, технологи, аюулгүй байдлын, Соёл, олон нийт, хамтын ажиллагааны алба харьяалагдана” гэж заасан байдаг.

Мөн дүрэмд “Цэргийн албаны зохион байгуулалт, аюулгүй байдлын газрын дарга мэдээллийн технологийн аюулгүй байдлын хүрээнд их сургуулийн мэдээлэл, холбооны найдвартай, гадаад, дотоод сүлжээний аюулгүй байх, хүртээмжтэй байх, тасралтгүй бэлэн байдлыг хангах; их сургуулийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулахад

⁴⁶ Ч.Оргил (2016), Мэдээллийн аюулгүй байдлын хандлага. Стратегийн судалгаа сэтгүүл. 4/2016 №76, 67 дах тал

ашиглагдах хэрэглээний программуудыг зохиож, үйл ажиллагаандаа бүрэн ашиглах нөхцлийг бүрдүүлэх, аюулгүй бэлэн байдлыг хангах; мэдээллийн технологи, холбооны дэвшилтэт технологийг ашиглан шуурхай удирдлагын нэгдсэн сүлжээ бий болгох, аюулгүй байдлыг хангах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ⁴⁷.

Энэ нь их сургуулийн хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг тодорхойлж, мэдээлэл, холбооны дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа бүрэн ашиглах, аюулгүй байдлыг хангах чиг үүргийг сургуулийн үндсэн бүтцийн нэгж цэргийн албаны зохион байгуулалт, аюулгүй байдлын газрын дарга, түүний харьяа Мэдээлэл, технологи, аюулгүй байдлын алба хэрэгжүүлэхээр тусгагдсан байгаа нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах удирдлагын тогтолцоо бүрдсэн болохыг харуулж байна.

Хэрэгжүүлэх чиг үүргийг тогтоосон хэм хэмжээнээс харахад мэдээлэл, холбооны дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа ашиглах, аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар зааж өгсөн хэдий ч мэдээллийн орчны хамгаалалт, хэрэглэгчийн хариуцлага, техник болон программ хангамж, ашиглалт, сүлжээний нууцлалыг хэрхэн хангах талаар зааж өгөөгүй байгаа нь энэ талаар бодлогын баримт бичгийг боловсруулж батлан гаргах шаардлагатай болохыг тэмдэглэж байна. Иймд дараах бичиг баримтыг боловсруулан гарган ажилласан.

Хууль сахиулахын их сургуулийн Мэдээлэл, холбоо, технологийн бодлого, журам

Уг журам нь 72 зүйлтэй, 11 бүлэгтэй дараах байдлаар боловсруулан хийгдсэн. Үүнд:

- ✓ Мэдээллийн аюулгүй байдлыг хангах
- ✓ Мэдээллийн технологийн техник хэрэгсэл ашиглах
- ✓ Сүлжээ, сервер компьютер ашиглах
- ✓ Цахим шуудан ашиглах
- ✓ Програм хангамжийн систем ашиглах
- ✓ Цахим хуудас ажиллуулах, мэдээллийн баяжилт хийх
- ✓ Радио болон телефон холбоо ашиглах
- ✓ Телехяналтын камерын систем ашиглах
- ✓ Сургалт
- ✓ Санхүүжилт
- ✓ Хариуцлага

Дээрх журмын 4.3-т Мэдээлэл, мэдээллийн систем гадны халдлагад өртөх, найдвартай байдал алдагдах, ашиглах боломжгүй болохоос үүдэн гарч болзошгүй эрсдлийг үндэслэн мэдээллийн нууцлалын ангиллыг дараах 4 түвшинд авч үзнэ гэж заасан байгаа.

Хүснэгт №1. Нууцлалын түвшин

Нууцлалын түвшин		Ашиглах боломж
1	Нийтэд зориулсан /C-1/	Хандах эрхийг хязгаарлаагүй.
2	Албан хэрэгцээнд зориулсан /C-2/	Хандах эрхийг албан тушаалд үндэслэн хязгаарласан.
3	Нууц /C-3/	Эрх бүхий албан хаагчид

⁴⁷ Хууль сахиулах их сургууль. (2015) Хууль сахиулахын их сургуулийн дүрмийн 25.6 дах заалт

		хамгаалалттай орчинд нэвтэрнэ.
4	Машнууц /С-4/	Эрх бүхий албан хаагчид нэвтрэх боломжийг хязгаарласан орчинд сайжруулсан хамгаалалттайгаар нэвтэрнэ.

Гэвч уг журам одоог хүртэл батлагдаагүй Их сургуулийн албан хаагчид дагаж мөрдөж ажил хэрэг болох шаардлага нэн тэргүүнд тулгараад байна.

ХСИС нь “Цахим их сургууль” болох зорилго тавиад 4 жил болж байгаа боловч хэрхэн шийдвэрлэх арга замыг дараах бүтцээр харуулж байна.



ХСИС нь Мэдээллийн аюулгүй байдлаа хэрхэн хангаж байна гэвэл улиг болсон механик ажил буюу компьютер форматлаж вирусны програм суулгаж л аюулгүй байдлаа хангаж байна.

Одоогийн байдлаар ХСИС-ийн нэгдсэн интернэтийн сүлжээтэй, Сансар кабелийн телевизийн шилэн кабелиуд болон телефон холбооны физик кабелиуд хичээлийн шинэ байранд сувагчлалаар татагдаж, серверийн өрөөнөөс давхар бүрийн хуваарилах самбарууд, албан хаагчийн өрөө, хичээлийн анги, танхимтай холбогдсон. Одоогийн байдлаар 15 mbps хурд бүхий интернэтийн сүлжээнд 650 гаруй хэрэглэгч тогтмол холбогдон ажиллаж байна.

Иймд ХСИС-ийн дэд бүтэц, сүлжээ, интернэтийн оролт гаралт дээр хяналтын сүлжээний аюулгүй байдлын төхөөрөмж байрлуулах шаардлага тулгарч байна. Интерэт сүлжээгээр орж ирж байгаа хэдэн мянган хадлага, вирусуудыг зогсоох ямарч боломжгүй алба хаагчид өөрсдийн хэрэглэж байгаа компьютертоо хувийн вирусны програм ашиглаж байгаа боловч энэ нь үр дүнд хүрэхгүй байгааг дараах жишээн дээр дурьяа.

Интерент сүлжээний аюулгүй байдлын хамгаалалтын төхөөрөмж хяналтын /Check point 5200/

Check point төхөөрөмж нь интернэтийн оролт, гаралтын урсгалыг хянаж, сүлжээний аюулгүй байдлыг хангах, аюулаас урьдчилан сэргийлэх, олборлох, мэдээллийг аюулгүй дамжуулах, ялгаатай файлуудыг ангилах, зайлсхийх, дамжуулах боломжгүй файлуудад саатал, үнэлгээ хийх, аюултай файлыг аюулыг зогсоож сүлжээнд нэвтрүүлэхгүй шалгаж, кибер халдлагын эсрэг хамгаалах, оролт, гаралтын хяналтыг уян хатан зохицуулах зорилготой юм.

Иймд тухайн төхөөрөмжийг ХСИС-ийн интернэтийг урсгал дээр 14 хоног байршуулан хяналт хийж дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдал үүсэж байна.

Хүснэгт №2. Сүлжээний эрсдэлийн статистик дүн

Generated by Check Point SmartEvent®, on March 17, 2017 01:11 PM



Дээрх хүснэгтийг харахад ХСИС-руу чигэлсэн болон 12,000 гаруй халдлага буюу вирус нэвтрэн орж ирж байна. Мөн 51 компьютер халдлагад өртөж өөрийн мэдээллээ алдах бүрэн бололцоотой болсон байгааг харж болно.

Хүснэгт №3. Вирусны төрөл


Host With High or Critical Severity Incidents (1 out of 2)

	Host	Severity	Protection Name	Num. of Incidents	Sent Traffic
Found Bot Activity	10.0.1.23	Critical	Trojan-PSW.Win32.Jenxcus.A	6	16.6KB
	10.0.1.23	Critical	Backdoor.Win32.VBS.E	6	0B
	10.0.1.223	Critical	Virus.Win32.Sality.S	4	0B
	10.0.1.223	Critical	Virus.Win32.Sality.CE	4	0B
	10.0.1.23	Critical	Virus.Win32.Sality.W	4	10.5KB
	10.0.1.223	Critical	Virus.Win32.Sality.CB	4	0B
	10.0.1.23	Critical	Virus.Win32.Sality.S	4	2KB
	10.0.1.223	Critical	Virus.Win32.Sality.W	4	5.6KB
	10.0.1.20	Critical	Virus.Win32.Sality.W	3	816B
	10.0.1.22	Critical	Virus.Win32.Sality.CB	3	0B
	10.0.1.22	Critical	Virus.Win32.Sality.S	3	1KB
	10.0.1.23	Critical	Virus.Win32.Sality.CE	3	0B
	10.0.1.22	Critical	Virus.Win32.Sality.W	3	5.2KB
	10.0.1.20	Critical	Virus.Win32.Sality.S	3	0B
	10.0.1.23	Critical	Virus.Win32.Sality.CB	3	0B
	10.0.1.22	Critical	Virus.Win32.Sality.CE	3	0B
	10.0.1.22	Critical	Virus.Win32.Sality.Q	2	0B
	10.0.1.17	Critical	Virus.Win32.Sality.S	2	0B
	10.0.1.130	Critical	Virus.Win32.Sality.S	2	415B
	10.0.1.17	Critical	Virus.Win32.Sality.CB	2	0B
	Others (29)			72	147.9KB
Total (49)				140	190.1KB
Downloaded a Malware	10.0.3.184	Critical	Trojan.Win32.Generic.T.bnxnp	1	0B
	10.0.1.190	Critical	Malware.yrdcz	14	25.3KB
	10.0.3.204	Critical	Malware.yrdcz	12	20.2KB
	10.0.3.171	Critical	Malware.ysagp	9	3.8KB

Дээрх IP хаягтай компьютерууд вирусуудыг дотоод сүлжээнд оруулж ирж бусад компьютеруудад халдаах, мөн кибер халдлага хийх үүд хаалгыг нээж өгч байна.

График №1. ХСИС-ийн Мэдээллийн аюулгүй байдлын түвшин

Overall Security - % of Total Events by Severity



Санал

ХСИС нь Мэдээллийн аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах, кибер халдлагаас хэрхэн сэргийлэх вэ гэвэл:

1. Интернет сүлжээний аюулгүй байдлыг хамгаалах төхөөрөмжтэй болох /тухайн төхөөрөмжийг авахад 40 сая төгрөг санхүүжилт хэрэгтэй/
2. Төрийн байгууллагуудын нэгдсэн сүлжээнд өөр өөрсдийн шилэн кабелийг сувагчлалаар татаж холбогдох / Төрийн өмчит компанид ашиглалтын зардал төлөх сар бүр/
3. Төрийн байгууллагуудыг Үндэсний дата төвтэй холбож интернэтийн урсгалыг авч хяналттай болох/Мэдээллийн аюулгүй байдал, Кибер халдлагаас хамгаалах зэрэг болно.

ХӨРВӨХ МЭРГЭЖИЛ ЭЗЭМШҮҮЛЭХ НЬ ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААНЫ НЭГ ТӨРӨЛ БОЛОХ НЬ

Х.Чинтөгс

ОХУ-ын Дотоод хэргийн яамны удирдлагын
Академийн магистрант, цагдаагийн дэд хурандаа

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгаатай холбогдох асуудлыг хөндөхийн өмнө тухайн албаны нийгмийн зориулалтын талаар товч дурдах нь зүйтэй.

Цагдаагийн алба нь дэлхийн аль ч улс оронд нэгэн утгаар ойлгогдох боловч эрх зүйн тогтолцоо, уламжлалт хэв маягаас хамаарч харилцан адилгүй чиг үүргийг хэрэгжүүлж, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, хууль зүйн баталгаа нь хууль тогтоомжийн онцлогоос хамаарч өөр өөр байна.

“Цагдаа” гэх нэр томъёог Монгол хэл зүйн үүднээс тайлбарлавал “цагдан хорих, хоригч, цагдан сэргийлэх албаны ажилтан, манах, хянах байцаах зэргийг гүйцэтгэх хүн”⁴⁸, “улс нийгмийн, ард түмний амгалан тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэг бүхий цагдан сэргийлэгч ажилтан, манах, хянах байцаах хэргийг гүйцэтгэх үүрэг бүхий хүн: ойн цагдаа, замын цагдаа”⁴⁹ гэж тайлбарласан байдаг.

“Police” гэдэг нь олон нийтийн хэв журмыг сахиулах, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий төрийн механизмын нэг хэсэг юм. Өргөн утгаараа цагдаа нь олон нийтийн хэв журмыг сахиулаад зогсохгүй төрийн эсрэг аливаа халдлагаас сэргийлэх замаар улс орны дотоод аюулгүй байдлыг хангах үүрэгтэй боловч нөгөө талаар иргэдийн эрхийг зөрчигдөхөөс хамгаалж, иргэд хоорондын харилцааны зөв хэв маягийг сахиулах үүрэг бүхий хүний эрхийг хамгаалагч юм. Товчхондоо цагдаагийн алба нь иргэдийг гэмт хэрэг, аливаа аюул заналаас урьдчилан сэргийлэх, хамгаалах тогтолцоо юм.⁵⁰

Цагдаагийн албаны анхдагч чиг үүрэг юу болох талаар судлаачид харилцан адилгүй тайлбарлах боловч улс орны дотоод аюулгүй байдал, иргэдийн амгалан тайван байдлыг хангах, иргэдийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэн зохицуулах үндсэн үүрэгтэй төрийн хэрэгсэл гэдэгт нэгдсэн байр суурьтай байна. Эдгээр чиг үүрэг нь нэг талаар Law enforcement буюу хууль сахиулах үйл ажиллагааны нэг хэсэг болохын зэрэгцээ Criminal Justice буюу нийгэмд шударга ёсыг тогтооход чиглэсэн шүүх эрх мэдлийн салшгүй нэг хэсэг гэж үзжээ.

Европын холбооны улсын “Цагдаагийн ёс зүйн дүрэм”⁵¹-ийн 1 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйлд эрх зүйт, ардчилсан төрийн цагдаагийн албаны зорилгыг тодорхойлохдоо “нийтийн амгалан тайван байдал, нийгэм дэх хууль дэг журмыг сахиулах; хүний салшгүй, үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалж, хүндэтгэх; гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх; гэмт хэргийг илрүүлэх; олон нийтэд үйлчилгээ дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх явдал” гэсэн нь уг албаны нийгмийн зориулалтыг бүрэн илэрхийлэх тодорхойлолт юм.

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн⁵² 4 дүгээр зүйлд “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх

⁴⁸Я.Цэвэл. “Монгол хэлний тайлбар толь” УБ., 1966 он. 779 дүгээр тал

⁴⁹И.Дамбажав. “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг” УБ., 2010 он. 889 тал

⁵⁰Black’s law dictionary. Fourth edition. ST. PAUL, MINN. 1968. 1316 дахь тал

⁵¹The European code of Police ethics. Council of Europe Publishing. Strasbourg Cedex. 2002

⁵²Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2017 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

төрийн тусгай алба мөн.” хэмээн тодорхойлж, цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх баталгааг хуульчилсан.

Нийгмийн сайн сайхан, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зориулалт бүхий төрийн тусгай албаны төлөөлөгчийн хувьд цагдаагийн алба хаагчийн эрхийн хамгаалалт, баталгааны тогтолцооны нэг чухал хэсэг нь нийгмийн баталгаа юм.

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгаа нь түүний нийгэмд эзлэх байр суурь, нийгмийн тодорхой хүрээн дэх нэр хүнд, амьдралын чанар, сэтгэл ханамжийн түвшинд эерэгээр нөлөөлөх бодлогын төдийгүй зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээний цогц бөгөөд алба хаагчийн тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, чин шударгаар ажиллах нөхцлийг хангахад чиглэсэн байдаг.

Энэхүү баталгаа нь зөвхөн албан үүрэг гүйцэтгэх хугацаагаар хязгаарлагдахгүй бөгөөд холбогдох хуульд заасан үндэслэлээр цагдаагийн албанаас чөлөөлөгдсөний дараа ч мөн үйлчилж байх онцлогтой. Учир нь олон нийтийн итгэлийг хүлээн, тэдний сайн сайхны төлөө үйлчилж, нийгмийн сөрөг үзэгдэл, “бараан сүүдэр”-тэй тэмцэж байсан төрийн төлөөлөгчийн хувьд албанаас чөлөөлөгдсөний дараах амьдралдаа сэтгэл ханамжтай, нийгмийн нэр хүндтэй гишүүн байх баталгаа хангагдсан байх нь албандаа үнэнчээр зүтгэх, чадварлаг, тогтвортой, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй.

Төрийн албаны тухай, Цагдаагийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудаар цагдаагийн албанаас чөлөөлөгдсөний дараах нийгмийн болон эдийн засгийн заримбаталгааг тодорхой хэмжээнд хангасан боловч хөдөлмөрийн чөлөөт зах зээлд өөр мэргэжлийн салбарт дахин өрсөлдөх, төрийн албанаас бусад энгийн салбарт хөрвөн ажиллахтай холбоотой баталгааг хангасан байдал олон улсын нийтлэг жишигтэй харьцуулахад учир дутагдалтай байсаар ирсэн.

Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.5⁵³-д цагдаагийн дээд боловсрол олгох зардлыг төр хариуцахаар, Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.7-д гадаад улсын цагдаагийн их, дээд сургуульд суралцагч цагдаагийн алба хаагчийн суралцах хугацааны цалин хөлс, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцахаар тус тус хуульчилж, албан үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоог бүрдүүлсэн энэ нь зөвхөн цагдаагийн албаны сургалтын хүрээгээр хязгаарлагдаж байна.

Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.6.-д “Цагдаагийн төв байгууллага нь энэ хуулийн 91.1, 91.2-т заасан насны дээд хязгаарт хүрч албанаас чөлөөлөгдсөн иргэнийг цагдаагийн албаны үйл ажиллагаанд туслах үүрэг бүхий ажилд гэрээгээр ажиллуулж болно.” гэсэн зохицуулалт нь зөвхөн цагдаагийн мэргэжлээр үргэлжлүүлэн ажиллах баталгаанд хамаарч байна.

Цэргийн алба хаагчийн энгийн салбар хөрвөн ажиллах, дахин мэргэжил эзэмших баталгааг анх цэргийн мэргэжил олгох сургалтын явцад бүрдүүлэхээр зохицуулж, цэргийн ба энгийн мэргэжлийг хос хөтөлбөрөөр эзэмшүүлж⁵⁴, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн⁵⁵ 7 дугаар зүйлийн 7.7.-д “Цэргийн тэтгэвэр тогтоолгосон дээд офицер, офицер, ахлагчийг эзэмшсэн мэргэжлийнх нь чиглэлээр төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэлтэйд тооцож, төрийн байгууллагад энгийн албан тушаалд томилон ажиллуулж болно.” гэсэн нь энэхүү баталгааг хангах нэг нөхцөл болж байна.

⁵³Мөн сэтгүүлийн 2002 оны 19 дугаарт нийтлэгдсэн.

⁵⁴<http://www.mndu.gov.mn>, БХИС-ийн захирлын 2016 оны А/57 дугаар тушаалаар баталсан “Батлан хамгаалахын их сургуульд боловсрол олгох сургалтын журам”

⁵⁵Мөн сэтгүүлийн 2016 оны 36 дугаарт нийтлэгдсэн.

Цагдаагийн дээд боловсрол олгох тогтолцооны хувьд 2014-2015 оны хичээлийн жилээс өмнө “Цагдаагийн ажил-эрх зүй” мэргэжлээр суралцаж, эрх зүйн бакалавр зэрэгтэй төгсөгчдийг цагдаагийн албанд томилон ажиллуулж ирсэн бөгөөд энэ нь албанаас чөлөөлөгдсөний дараа хууль зүйн салбарт хөрвөн ажиллах боломжийг хангаж байсан.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78 дугаар тушаалаар “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл, индексийн жагсаалт”-ийг шинэчлэн баталснаар “Эрх зүй” ба “Цагдаа-хууль сахиулах ажил” сургалтын хөтөлбөрүүд нь ерөнхий болон төрөлжсөн чиглэлийн хувьд өөр ангилалд хамаарч, төгсөгч нь энгийн салбарт хөрвөх боломжгүй, цагдаагийн дээд боловсрол эзэмшиж байна.

Иймд Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлд “Цагдаагийн албанд 20-иос дээш жил ажиллаж байгаа, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон цагдаагийн алба хаагч, энэ үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэний хүсэлтийг харгалзан өөр мэргэжил олгох сургалтад хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” гэж, мөн хуулийн 91 дүгээр зүйлд “Цэргийн тэтгэвэр тогтоолгосон дээд офицер, офицер, ахлагчийг эзэмшсэн мэргэжлийнх нь чиглэлээр төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэлтэйд тооцож, төрийн байгууллагад энгийн албан тушаалд томилон ажиллуулж болно.” гэж тус тус хуульчлах замаар цагдаагийн алба хаагчдад хөрвөх мэргэжил дахин эзэмшүүлж, албанаас чөлөөлөгдсөний дараах нийгмийн баталгааг хангах боломжтой юм.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

О.Отгонтуяа

ХСИС-ийн ЭЗНУС-ийн Эрх зүйн онолын тэнхимийн
ахлах багш, цагдаагийн ахмад, хууль зүйн магистр

Товч агуулга

2004 оны 05 дугаар сарын 13-ны өдөр 5 бүлэг, 20 зүйлтэйгээр 2005 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр батлан хэрэгжүүлж байгаа хуулиар гэр бүлийн хүчирхийллийг хүний эрхийн зөрчилд тооцон хүчирхийлэл үйлдэгчид зохих хариуцлага хүлээлгэхээр анх удаа хуульчилан тогтоосон билээ.

Иймд Монгол Улсад гэр бүл, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой хууль, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо боловсронгуй бус, хохирогчдод гэм хор, сэтгэл санаа, хууль эрх зүй, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх, гэр бүл дэх хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг хууль сахиулах бүх түвшинд эрчимжүүлэх нийгмийн хэрэгцээ, шаардлага илүү их байгааг товч үзлээ.

Түлхүүр үг

Гэр бүл, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн гишүүн, гэр бүлийн хамаарал бүхий хүн

Үндсэн хэсэг

Нийгэмд гэр бүлийн хүчирхийллийн талаар янз бүрийн байр суурь, хандлага байгаа ба үүнийг өөр өөрсдийн үзэл бодлоор тайлбарлаж байна.

Гэр бүлийн хэвийн харилцааг хангах, хамгаалах бодлого төрийн бодлогын хамгийн чухал асуудлуудын нэгэнд зүй ёсоор тооцогддог төдийгүй монголчуудын “Төрийн хэлхээ өрх гэр, төрлийн хэлхээ эцэг, эх” гэж хэлдэг нь өргөн, гүн утга агуулгатай ойлголттой аж⁵⁶.

НҮБ-аас гаргасан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай загвар хуульд Гэр бүлийн хүчирхийлэл гэдгийг “Гэр бүл болон ойр дотны харилцаатай этгээд буюу этгээдүүд, бэлгийн харилцааны шинж бүхий үндэслэлээр үйлдэгдсэн бие махбодь, сэтгэл зүйн болон бэлгийн харилцааны шинжтэй хэл амаар доромжлох, айлган заналхийлэхээс эхлээд бие махбодид хүнд гэмтэл учруулах, хулгайлах, бэртээж гэмтээхээр заналхийлэх, айлган сүрдүүлэх, албадах, мөрдөн мөшгөх, орон байранд нь хүчээр болон хууль бусаар орох, шатаах, өмч хөрөнгийг устгах, хүчээр гэр бүл болох, инж сүй буюу төлөөстэй холбоотой хүчирхийлэл, бэлгэ эрхтэнг бэртээж гэмтээх, биеийг нь хүчээр үнэлүүлэх замаар ашиг олох, гэрийн үйлчлэгчийг хүчирхийлэх зэрэг хүчирхийллийн шинжтэй бүх үйлдэл, тийм үйлдэл хийх оролдлого”-ыг хэлнэ хэмээн гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлалтай субъектүүд, гэр бүлийн хүчирхийллийн төрөл, хэлбэрүүдийг тусгасан билээ⁵⁷.

Гэр бүлийн хүчирхийлэл, түүний эрх зүйн зохицуулалтын талаар төрөөс тодорхой бодлого, хөтөлбөр, эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар багагүй ажлыг хийж гүйцэтгэсэн билээ. Үүнд:

⁵⁶О.Амарсайхан, О.Отгонтуяа, “Монгол Улсын Гэр бүлийн хууль, түүний хэрэгжилт”, УБ, 2009 он, 6 дахь тал

⁵⁷Нэгдсэн үндэсний байгууллага, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай загвар хууль, зөвлөмж

- Жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрийг Гэр бүлийн өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлж байхаар шийдвэрлэсэн
- 2004 оныг Гэр бүлийн жил болгон зарласан
- 2003 онд “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого” хөтөлбөр
- 2005 онд “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах” Үндэсний хөтөлбөр
- 2007 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” Үндэсний хөтөлбөр
- 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- 2016, 2017 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга)
- 2016 онд Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн холбогдох зүйлийг нэмсэн.
- 2017 онд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль
- 2006 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” Улсын дээд шүүхийн тогтоол
- ЦЕГ-ын даргын 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх урьдчилан сэргийлэх хэлтсийг анх удаа шинээр байгуулсан
- ЦЕГ-ын даргын 2017 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн тушаалаар ЦЕГ-ны урьдчилан сэргийлэх хэлтэстэй нэртэйгээр өөрчлөгдөн байгуулагдан Хүүхэд, гэр бүл хариуцсан ахлах мэргэжилтэнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн талаар манай улс Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт, Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Эхчүүдийг хамгаалах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 103 дугаар конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц зэрэг⁵⁸ олон улсын гэрээг соёрхон баталж, нэгдэн орсноор үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд “**гэр бүлийн хүчирхийлэлд** эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү, гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нь дээрх этгээдүүдийн сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг хамааруулан ойлгох ба 2017 оны 05-р сарын 11-ний өдөр батлагдаж 2017 оны 07-р сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн Зөрчлийн тухай хууль, 2015 оны 12-р сарын 03-ны өдөр батлагдсан 2017 оны 07-р сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн Эрүүгийн хуулиар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэрэг гэж нарийвчлан тогтоосон билээ.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх захиргааны зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж буй Цагдаагийн байгууллага, албан хаагч нь уг ажиллагаанд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлж байна⁵⁹. Үүнд:

⁵⁸“Төрийн мэдээлэл” эмхтгэл, Тусгай дугаар, Монгол Улсын олон улсын гэрээ, I, II боть

⁵⁹Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, “Төрийн мэдээлэл” сэтгүүд, 2017 он, №5

1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаархи бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээллийг хүлээн авч, шаардлагатай тусламж, зөвлөгөө өгөх, холбон зуучлах утас 24 цагаар ажиллуулах
3. Тодорхой нутаг дэвсгэр хариуцсан хүүхэд, гэр бүл хариуцсан нэгжийг байгуулах
4. Баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулах
5. Хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, хуульд заасан журмын дагуу аюулын зэргийн үнэлгээ хийж, түүнийг үндэслэн хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх
6. Хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийлэл үйлдэх, согтууруулах ундаа хэрэглэхийг зогсоохыг шаардах
7. Аюулын зэргийн үнэлгээ хийх
8. Аюулын зэрэг өндөртэй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан сум, баг, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэх
9. Хохирогчид хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, түүнд үзүүлэх үйлчилгээний талаархи мэдээллийг бичгээр өгөх
10. Хохирогчийн эрхийг хангах арга хэмжээ авах
11. Шаардлагатай бол хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах
12. Галт зэвсэг, хүчирхийлэл үйлдэхэд ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг хураан авах
13. Нэг цэгийн үйлчилгээний аюулгүй байдалд хяналт тавих зэрэг

Цагдаагийн байгууллага, албан хаагч нь гэр бүлийн хүчирхийллийн хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчилсан⁶⁰. Үүнд:

- Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэх⁶¹
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах⁶²
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж боллзошгүй, өртсөн этгээдийн аюулгүй байдлыг хангах⁶³
- Цагдаагийн байгууллага захиргааны хяналтыг хэрэгжүүлэх

Дээрх хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т “эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх” эрхийг тусгасан нь гэр бүлийн хүчирхийлэлд хүүхэд өртсөн байдлыг тогтоох, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх шалтгаан нөхцөлийг тогтоох чухал ач холбогдолтой заалт гэж дүгнэж болно.

Эрүүгийн хуулийн 11.7 дахь хэсэгт зааснаар Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг тусгайлан хуульчилсан билээ.

Уг хуулийн дагаж мөрдсөнөөр хойш улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн талаар хэсэгчилэн авч үзвэл⁶⁴

⁶⁰Цагдаагийн албаны тухай хууль, “Төрийн мэдээлэл” сэтгүүл, 2017 он, №8

⁶¹Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйл

⁶²Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйл

⁶³Цагдаагийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл

2018 оны эхний гурван дугаар сард 10753 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 56.5 хувиар өсч, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 306 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 83 хэргээр буюу 21.3 хувиар, бүх хэрэгт эзлэх хувийн жин 2.8 хувь болж, 2.8 нэгжээр тус тус буурсан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 283 хэрэг буюу 92.5 хувийг хөнгөн, 23 хэрэг буюу 7.5 хувийг хүндхэрэг эзэлж байна.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн төрлөөр нь тусгайлан авч үзвэл:

Хэргийн төрөл	Тоо	Хувь
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	5	1.6
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	276	90.2
Гэр бүлн хүчирхийлэл үйлдэх	84	27.5
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	24	7.9
Хүчиндэх гэмт хэрэг	19	6.2
Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг	2	0.7
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	0.3

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн 71 буюу 23.2 хувь нь согтуугаар, 18 буюу 5.9 хувь нь эмэгтэй, 4 буюу 1.3 хувь нь насанд хүрээгүй хүн оролцож үйлдэгдсэн байна.

Энэ төрлийн гэмт хэрэг гэр, орон сууцанд 271 буюу 88.6, гудамж талбайд 17 буюу 5.6, олон нийтийн газарт 7 буюу 2.3, аж ахуйн нэгжид 3 буюу 1.0, төрийн байгууллагад 1 буюу 0.3, нийтийн тээвэрт 1 буюу 0.3, бусад газар 6 буюу 1.9 хувь нь тус тус үйлдэгдсэн байна.

Нийт гэмт хэрэгт 9263 иргэн өртөж хохирсноос гэр бүлийн хүчирхийлэлд 191 иргэн өртөж хохирсоны 91.2 хувь нь эмэгтэй хүн байна.

Насны байдал	Хүчирхийлэлд өртсөн иргэд		Хүчирхийлэлд холбогдогч	
Хүйс	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
70 –аас дээш		3		
65-69		1		
60-64		1	1	
55-59	1	1	3	1
50-54		10	16	12
45-49	1	10	18	3
40-44	1	18	36	
35-39	2	30	42	
30-34	4	39	55	7
25-29	2	36	50	2
18-24	1	19	40	3
14-17		3	7	
8-13		4		
7 хүртэлх	3	1		

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 99, хамтран амьдрагч 28 дагавар хүүхэд 7, нөхөр 24, төрсөн хүүхэд 5, төрсөн эцэг, эх 5, хадам эцэг, эх 2, төрсөн дүү 2, төрсөн ах, эгч 1, бусад 19 хүн байна.

⁶⁴Цагдаагийн ерөнхий газар, 2018 оны 03 дугаар сар

Гэр бүлийн хүчирхийлэлд холбоотой гэмт хэргийн улмаас 136 хүн гэмтэж, иргэдэд 73,5 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирсан.

Нийт гэмт хэрэгт 2443 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсаны 287 буюу 11.7 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсний улмаас шалгагдаж тэдний 43.6 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдэн бүртгэгдсэн байна.

Нийгмийн байдал	Өртсөн иргэд	Холбогдогч
Хоригдол		1
ТББ-ын ажилтан	7	5
Малчин	8	30
Сурагч, оюутан	8	6
Хувийн хэвшлийн байгууллагын ажилтан	20	25
Төрийн албан хаагч	21	12
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	35	54
Ажилгүй	92	154
Боловсролгүй		8
Бага боловсролтой		22
Суурь боловсролтой		54
Бүрэн дунд боловсролтой		147
Тусгай мэргэжлийн дунд боловсролтой		9
Дээд боловсролтой		47

Улсын хэмжээнд 2018 оны эхний 3 сард бүртгэгдсэн зөрчлийн талаар тусгайлан авч үзвэл⁶⁵:

323,049 захиргааны зөрчил бүртгэгдсэний 930 буюу 0.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж, зөрчил гаргасан 9 хүнд 1.220.000 төгрөгөөр торгох, 921 хүнд баривчлах шийтгэлийг ногдуулсан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн 92.9 хувь нь гэр, орон сууцанд, 2.9 хувь нь олон нийтийн газарт, 2.6 хувь нь гудамж талбайд, 0.4 хувь нь аж ахуйн нэгжид, 0.2 хувь нь төрийн бус байгууллагад, 1.0 хувь нь бусад газарт тус тус үйлджээ.

Хүчирхийлэгч үйлдэгч	Тоо	Хувь
Нөхөр	549	65.3
Хамтран амьдрагч	95	11.3
Төрсөн эцэг	17	2.0
Төрсөн ах	12	1.4
Төрөл, садангийн хүн	10	1.2
Хойд эцэг	9	1.1
Төрсөн эгч	4	0.5
Хүргэн ах	3	0.4
Хүргэн дүү	3	0.4
Бусад этгээд	139	16.5

Дүгнэлт

⁶⁵Цагдаагийн ерөнхий газар, 2018 оны 03 дугаар сар

“Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвийн хүрээнд дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, илрэх хэлбэр, хор уршигийн талаар иргэдэд мэдээлэх ажлыг тодорхой үе шаттайгаар мэргэжлийн баг бүрдүүлэн зохион байгуулах.
2. Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт, зааснаар Монгол Улсын иргэн нь Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэн, сахин биелүүлэх үндсэн үүрэгтэй бөгөөд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт зааснаар хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлын талаар цагдаагийн байгууллагад мэдээлэл өгч болохоор хуульчилсан билээ. Иймд иргэн бүр Үндсэн хууль заасан үүргээ биелүүлэн хүчирхийлэгч нь хохирогч этгээдээ өөрийн эрхшээлдээ байлгадаг, даамжирсан, эргэх холбоонд оршсоор байдаг, сэтгэл зүйн гүн хямралд оруулдаг, нууц шинжтэй чимээгүй тахал болох хүчирхийллийг харьяалах цагдаагийн байгууллага харгалзахгүйгээр мэдээлдэг байх.
3. Дуудлага шалгах цагдаагийн албан хаагч нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх захиргааны зөрчил, гэмт хэргийн талаарх дуудлага, мэдээллийг цаг алдалгүй шуурхай шийдвэрлэхэд ач холбогдол бүхий аюулын зэргийн үнэлгээг тодорхой хугацаанд нөхцөл байдлыг үнэлэн хийх бөгөөд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 208-д заасан шаардлагын дагуу илтгэх хуудсыг бичих бөгөөд аюулын зэргийн үнэлгээнд асуултын хариултад хамаарагдахгүй нөхцөл байдал бий болсон бол тодорхой, дэлгэрэнгүй дурдах. Хүчирхийлэгчийн үйлдэл нь захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол хэргийн бодит байдлыг үнэлгээ анхны нотолгоо юм.
4. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээг байгуулан ажиллуулах
5. Иргэний хуулийн 129 дүгээр зүйлийн 129.1 дэх хэсэгт заасан гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгийг тодорхойлоход “Хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан үйлдлээр шийтгэгдсэн бол” гэж нэмэлт оруулах

ГЭР БҮЛИЙНХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

С.Оюунчимэг

ХСИС-ийн ЭЗНУС-ийн Эрх зүйн онолын тэнхимийн
ахлах багш, ахмад, хууль зүйн магистр

Жендэрт суурилсан хүчирхийллийн түгээмэл хэлбэр нь гэр бүлийн хүчирхийлэл юм. Аливаа хэлбэрийн хүчирхийлэл нь хүний амьд явах эрх болон ялгаварлан гадуурхалт, айдас, дарамт, хүчирхийлэл, эрүүдэн шүүлтээс ангид эрх чөлөөтэй амьдрах эрхийг зөрчдөг. Энэхүү эрх, эрх чөлөө нь үндэсний болон олон улсын хэм хэмжээгээр хамгаалагдсан ч гэр бүлийн хүчирхийлэл нь дэлхийн нийтээр төдийгүй Монгол улсын хэмжээнд тулгамдсан асуудал болж эмэгтэйчүүдийн 80%-90% нь амьдралын явцад ямар нэг төрлийн хүчирхийлэлд өртөж байгаа нь НҮБ-ын судалгаагаар тогтоогдсон байдаг.

Монгол улсын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь 2017 оны 2 сарын 1-ний өдрөөс эхлэн үйлчилж байгаа билээ. Энэхүү хуулийн зорилт гэр бүлийн хүчирхийлэлийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход чиглэгдэж байгаа билээ. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь “ бүтцийн хувьд 6 бүлэг 47 зүйлтэй бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний бодлогыг хуульчлан бэхжүүлсэн хууль болсон юм.

Уг хуулийн агуулгыг бүлэг бүлгээр нь авч үзвэл :

1-р бүлэг: Нийтлэг үндэслэл буюу /1-8-р зүйл / Энэ хуулийн үйлчлэх хэмжээ хязгаар орон зай, цаг хугацаа, хамаарагдах этгээд, хуулийн нэр томьёо, гэр бүлийн хүчирхийлэлийн хэлбэр, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг хориглох агуулга бүхий хэм хэмжээг тогтоон бэхжүүлж өгсөн. Тухайлбал: Хуулийн 3-р зүйлд хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдийг тодорхой дурьдсан бөгөөд илүү өргөн хүрээнд авч үзэх болсон.

Өмнө нь салсан эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, гэр бүлээ бүртгүүлээгүй хүмүүсээс төрсөн хүүхэд, гэр бүлийн баталгаагүй хүмүүсийн хооронд хүчирхийлэл үйлдэгдвэл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль үйлчилдэггүй байсан нь энэ удаагийн хуулиар хамгаалагдах болсон нь энэ хуулийн шинэлэг зохицуулалтын нэг болсон.

Мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд баримтлах зарчмыг улам боловсронгуй болгосон. Тухайлбал: Хохирогчийн нэр төрийг хүндэтгэх, салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, нэгдмэл цогц байх, нууцлалыг хамгаалах зарчмууд гэх мэт.

6 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийллийн төрлүүдийг:

- Бие махбодын хүчирхийлэл
 - Сэтгэл санааны хүчирхийлэл
 - Эдийн засгийн хүчирхийлэл
 - Бэлгийн хүчирхийлэл
- ойлголтуудыг нэлээд дэлгэрүүлж тайлбарлан бэхжүүлж өгсөн.

2-р бүлэг: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо /9-22-р зүйл /

Энэ бүлэгт : “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо”-г боловсронгуй болгосон бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, хохирогчийг хамгаалах зэрэг үйл ажиллагаанд заавал оролцох субъектүүдийн эдлэх эрх, хүлээх үүргийг хуульчилсан нь хууль хэрэгжих баталгаа болж байгаа юм.

Үүнд: Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтан хамрагдахаас гадна шинээр боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын эрх, үүргийг дурьдаж өгсөн нь ихээхэн ач холбогдолтой болсон.

МУ-ын УИХ-ын, ЗГ-ын, төрийн Захиргааны төв байгууллагуудын, ПБ, бүх шатны засаг дарга, хамтарсан баг, түүний эрх, үүргийг тодорхойлон заасан.

3-р бүлэг: Гэр бүлийн хүчирхийллийг, таслан зогсоох арга хэмжээ /23-27-р зүйл/

Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, урьдчилан сэргүүлэх таслан зогсоох, мэдээлэхэд сум дүүргийн засаг даргын, цагдаагийн байгууллагын болон албан хаагчийн, нийгмийн болон эрүүл мэндийн ажилтны үүрэг оролцоог тодорхойлон заасан.

Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг мөн адил нарийн хуульчилж өгснөөс иргэнд үүрэг болгосон зохицуулалт орж ирсэн тул мэдсээр байж мэдээлэл өгөөгүй, иргэнийхээ үүргийг биелүүлээгүй тохиолдолд Захиргааны хариуцлагын тухай хуулинд зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох шийтгэлийг хуульд оруулсан нь иргэдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлсэн зохицуулалт болсон юм.

Мөн гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн нууцыг чандлан сахиж, болзошгүй эрсдлээс хамгаалах зэрэг зохицуулалт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэхэд чухал байр суурийг эзлэх болно.

4-р бүлэг: Хүүхдийг гэр бүлийн хүчирхийлэлээс хамгаалах /28-30-р зүйл/ хуульчилж өгсөн.

Гэр бүлийн хүчирхийлэлээс хүүхдийг хамгаалах зохицуулалт шинээр орж ирсэн /2004 оны “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулинд энэхүү заалт байгаагүй/ нь ихээхэн ач холбогдолтой. Учир нь гэр бүлийн хүчирхийлэл, түүний нөлөөнд бий болж байгаа гэр бүл салалт нийгэмд ихэссээр байна.

Үүний гол хохирогч нь хүүхэд болж үлддэг. Тэдний эрх ашгийг хамгаалах механизм нийгэмд зайлшгүй шаардлагатай бөгөөд ийнхүү хуульчилсан нь хүүхдийн эрхийг хамгаалах нэг механизм болсон юм.

5-р бүлэг: Аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ, хохирогчдод үзүүлэх үйлчилгээ /31-44-р зүйл /

Энэ бүлэгт : Цагдаагийн албан хаагчийн аюулгүй зэргийн болон нийгмийн ажилтны нөхцөл байдлын үнэлгээ болон хохирогчдод үзүүлэх үйлчилгээний төрлүүд, хохирогчид үзүүлэх аюулгүй байдлын хэлбэрүүдийг тогтоон бэхжүүлсэн.

“Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид дараах үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ “ хэмээн хуульчилжээ .

Үүнд:

- ✓ Аюулгүй байдлын хамгаалал
- ✓ Эмнэлэгийн тусламж үйлчилгээ
- ✓ Эрх зүйн туслалцаа
- ✓ Сэтгэл зүйн туслалцаа
- ✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ
- ✓ Хүүхэд хамгаалалтын үйлчилгээ
- ✓ Холбон зуучлах үйлчилгээнүүдийг бэхжүүлж өгчээ.

Мөн хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах журам, уулзуулахыг хориглох заалтуудыг, гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалт, түүний хэлбэрийг зохицуулж өгсөн нь тухайн асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, ухааруулах боломжийг олгож буй шинэлэг зохицуулалт болсон юм.

Гэр бүлийн зөрчлийн асуудлаа хүчирхийллийн бус аргаар шийдэхэд суралцуулах, өөрийнхөө бурууг ойлгож засах үүний дараагаар гэр бүлдээ очих боломжийг олгох зорилгоор зан үйлд нь нөлөөлөх сургалтыг зохион байгуулахаар хуулинд тусгагджээ.

Өөрөөр хэлбэл: Энэхүү хууль нь хүчирхийлэл үйлдлээ гээд нэг бол гэрлэлтийг нь шууд цуцлахэсвэл хүнд ял эдлүүлэхээс аль болох татгалзах, эргээд хүчирхийлэлтэй харилцаанаас салах боломжийг гэр бүлд олгосон, хүний эрхийг баталгаажуулсан, гэр бүлийн хүчирхийлэлээс ангид байх боломжийг олгосон хууль болсон гэж хувь судлаачийн хувьд ач холбогдлыг тодорхойлж байна.

6-р бүлэг: Бусад зүйл / 45-47-р зүйл /

Энэ бүлэгт: Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих хэлбэрүүдийг, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан зохицуулсан.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо өөрчлөгдсөн. Тухайлбал: Өмнө нь гэр бүлийн хүчирхийллийг иргэд хоорондын маргаантай адилхан шийдвэрлэдэг байсан. Эдийн засгийн, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэл үйлдсэн нь тогтоогдсон бол шүүхээр асуудлаа шийдүүлдэг байсан. Уг хууль батлагдан гарч үйлчилснээр гэр бүлийн хүчирхийллийг хүний эрхийн ноцтой зөрчил гэж үзэж гэмт хэрэгт тооцох болсон нь уг гэмт гаралтад нөлөөлөх буйзаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг дагалдаад, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд зарим нэг зарчмын шинжтэй өөрчлөлтүүд орсон.

Тухайлбал: Зөрчилд зодох, хүсэл зоригийнх нь эсрэг албадах, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох, эд хөрөнгө эзэмших, ашиглах захиран зарцуулах эрхэд халдах гэх мэт 7 үйлдэл Захиргааны зөрчил болсон.

Хэрэв энэ үйлдлүүдээ давтан хийсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэдгийг хуульчилсан. Зөрчилд 7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулна, гэмт хэрэг үйлдсэн бол эхний удаа, хөнгөрүүлэх нөхцөлтэй бол 1-6 сар хүртэл баривчлах, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй, жирэмсэн эмэгтэйг зодох, хүүхдийг байнга зодсон тохиолдолд хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялтай.

Хэрэг шалгах явцад хохирогчийг заналхийлдэг, өргөдөл гомдлоо буцаагаад авахыг дарамталдаг. Үүнийг зогсоох зорилгоор Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулсан. Хохирогчид тодорхой зайд ойртох, ажлын байран дээр нь очих дарамтлахыг хориглосон. Хэрэв тогтоосон хязгаарлалтыг зөрчвөл цагдан хорих гэх мэтээр дараагийн арга хэмжээг авна гэж тус тус хуульчлан зохицуулсан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн ОНЦЛОХ заалтуудыг дурдвал:

1. 2017 оны есдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн гэмт хэрэгт тооцдог болж байгаа нь уг хуулийн хамгийн гол өөрчлөлт билээ.

2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгааг мэдэгдсэн дуудлагыг цагдаа байгууллага авсан даруйдаа хамгийн түрүүнд очно гэсэн шинэ заалт оруулсан байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж буй ямар нэгэн аргаар хууль сахиулах байгууллагад мэдэгддэг ч зарим тохиолдолд цагдаа нар дуудлага авсан даруйдаа ирдэггүй байсныг ийнхүү хуулиар зохицуулжээ.

3. Хүүхэд хууль ёсны төлөөлөгчийнхөө хүчирхийлэлд өртсөн бол цагдаа тэдгээр хууль ёсны төлөөлөгчийн саналыг харгалзалгүйгээр хүүхдийг хамгаална гэсэн заалт шинээр оруулсан байна. Хүүхдийг хууль ёсны төлөөлөгч гэж эцэг эх, ах эгч нар, хүүхэд асрах төвийнхөн, халамжийн төвийнхөн, үрчилж авсан хүмүүсийг хэлнэ.

4. Гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлээгүй иргэнд Зөрчлийн хуульд заасны дагуу хариуцлага тооцохоор болсон байна.

Ийнхүү “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” тухай хууль УИХ-аас батлагдан хэрэгжиж эхэлснээр тухайн төрлийн гэмт хэргийн гаралтын тоо буурч байгаа

сайшаалтай хэдий ч цаашид уг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимтэй зохион байгуулах шаардлагатай байна.

Ер нь аливаа гэмт хэрэгтэй хийх тэмцэл нь урьдчилан сэргийлэх ажлаас эхлэдэг. Урьдчилан сэргийлэх ажлын үр дүн нь гэр бүлийн хүчирхийлэлийг “нуугдмал бус” байлгах, тасланзогсоох гэмт хэргийн тоо буурахад нөлөөлнө. Тиймээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэр бүлийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэр бүл дэх сөрөг үр дагаврыг арилгахад чиглэгдсэн нийгмийн сэтгэл зүй сурган хүмүүжүүлэх, эрх зүйн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Мөн үүнээс гадна хамгийн гол нь нийгмийн, олон нийтийн хандлагыг өөрчлөх хэрэгтэй. Хандлага өөрчлөгдснөөр хуулийн үйлчлэл сайжирч хууль маань жинхэнэ утгаар хэрэгжих болно.

**ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЖОЛООЧ НАРЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД
ОРОЛЦОХ САХИЛГА, СОЁЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ**

В.Ганболор

ХСИС-ийн Гэмт явдал судлал-эрх зүйн магистрант

Дэлхий нийтээр даяарчлагдаж байгаа энэ үед автомашин хүний амьдралын наад захын хэрэгцээ болоод зогсохгүй, түүнгүйгээр хүмүүсийн ажил, амьдрал нь төсөөлөгдөхгүй болсон байна. Хүн төрөлхтний зохион бүтээсэн аугаа үйлсийн нэг нь автомашин юм. Жил ирэх тутам автомашины тоо нэмэгдэж байгаа нь хүмүүсийн амьжиргаа сайжирч байгаагийн жишээ боловч нөгөө талаас аюулгүй байдлыг хангах асуудал дэлхий нийтийн өмнө тулгарч байгаа чухал асуудлуудын нэг болоод байгаа билээ. Хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой осол, хэрэг ихсэхийн зэрэгцээгээр түүнээс үүдэн гарах хүний амь бие, эрүүл мэндийн болон эд зүйлийн хохирол нэмэгдсээр байгаа нь осол, хэргээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд замын хөдөлгөөнд оролцогч гэдгийг “Замаар яваа жолооч, явган зорчигч болон тээврийн хэрэгслээр зорчигч” гэж тодорхойлжээ⁶⁶. Үүнээс үзвэл замын хөдөлгөөнд оролцдоггүй нэгээхэн ч хүн байхгүй гэж бардам хэлж болох бөгөөд нас, хүйс, үндэс угсаа, мэдлэг боловсрол үл хамаарна. Зарим хүмүүс зам тээврийн осол нэмэгдэж байгааг тээврийн хэрэгслийн тоо юмуу, эсхүл замын ачаалалтай холбон тайлбарладаг. Тэгвэл зөвхөн дээрх хоёр хүчин зүйлийг дангаар нь авч үзэх нь ихээхэн учир дутагдалтай бөгөөд бусад нөлөөлж байгаа элементүүдийг нэгтгэн системчлэн авч үзэх шаардлагатай юм. Тухайлбал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад “хүн” асар их үүрэгтэй. Германы философич Мартин Хайдеггер “машин техник, үйлдвэрлэлийн буруу горимоос хүнд аюул нүүрэлдэг юм биш. Жинхэнэ аюул занал хүний өөрийнх нь мөн чанар дотор нэгэнт нүүрлээстэй явдаг юм” гэжээ. Хүн замын хөдөлгөөний дүрмийг хэдий чинээ дагаж мөрдөнө төдий чинээ ослоос өөрийгөө гэтэлгэж чадна. Мөнүүнээс гадна замын хөдөлгөөнийг хүний ухамсарт үйл ажиллагаагүйгээр ярихын ч хэрэггүй гэж үздэг. Өөрөөр хэлбэл, бидэнд хамгийн ихээр үгүйлэгдэж байгаа хөдөлгөөний соёлыг яриад байгаа юм. Хөгжилтэй орнуудад замын хөдөлгөөний 65 орчим хувь нь эрх зүйгээр, 35 орчим хувь нь ухамсарт үйл ажиллагаагаар зохицуулагддаг гэж үздэг. Осол, хэрэг яг өнөөдрийн байдлаар юунаас болж өсөж байна, хэн үүнд буруутай, явал зам тээврийн осол багасах вэ? гэдэг тал дээр бид өнөөдөр анхаарах цаг болсон тул энэхүү өгүүллээ бичихийг хичээлээ.

“Замын хөдөлгөөн” гэдэгт нийтийн хэрэгцээний зам ашиглан ачаа ба зорчигчдыг тээврийн хэрэгслээр шилжүүлэн зөөх, явганаар болон дугуй, ердийн хөсгөөр зорчих үйл ажиллагааг ойлгоно хэмээн Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд⁶⁷ заасан байдаг. Хөдөлгөөн гэдэгт аливаа биетийн шилжилт гэж ойлгодог боловч замын хөдөлгөөн нь дээрх тодорхойлолтын дагуу нийгмийн харилцаан дахь автозамын хөдөлгөөнтэй холбогдох зохицуулалтын хүрээгээр хязгаарлагдаж буй тодорхой дүрэм, журмаар зохицуулагддаг жолооч, явган зорчигч, тээврийн хэрэгслээр зорчигчийн хөдөлгөөнийг ойлгоно.

⁶⁶ Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм. Засгийн газрын 2004 оны 74 дүгээр тогтоол.

⁶⁷ <http://www.legalinfo.mn/law/details/11224?lawid=11224>

Бидний хэлж заншсан “авто ослын” хэрэг буюу одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлд⁶⁸ заасан “Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих”⁶⁹ гэмт хэрэгт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмээр тогтоосон хэм хэмжээг гэм буруутайгаар зөрчсөн үйлдлийг² хамааруулдаг.

Гэхдээ дээр дурьдсан хууль, дүрмийг зөрчсөн л бол Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт холбогдлоо гэж үзэж болохгүй юм. Энэ хэргийн улмаас хүний амь нас, бие махбодь, эд хөрөнгөнд хохирол учирснаар тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж (объектив тал) бүрддэг. Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөний улмаас наад зах нь хүний бие махбодид хүндэвтэр гэмтэл учирсанаар гэмт хэргийн шинжтэй гэж үзэж байцаан шийтгэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулна. Хүний биед учирсан гэмтлийн зэргийг шүүх эмнэлэгийн шинжээчийн дүгнэлтээр заавал тогтоосон байх шаардлагатай. Харин дээрх гэмт хэргийн улмаас тээврийн хэрэгсэлд учирсан эвдрэлийн үнэлгээ, хэмжээг хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй иргэн хуулийн этгээдээр тогтоолгоно. Тээврийн хэрэгсэлд учирсан хохирлыг тогтоохдоо түүний эд ангийн элэгдэл хорогдлыг хасч, түүнийг засаж сэргээхэд шаардагдах эд анги бусад материалын үнийг оруулан тооцох ба түүнийг засаж сэргээхэд шаардагдах ажлын хөлсийг тухайн этгээдийн гэм буруутай эсэхийг хэлэлцэх хохирлын хэмжээнд оруулан тооцохгүй бөгөөд хохирогч этгээд энэ зардлаа холбогдох баримтыг бүрдүүлэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар нэхэмжилж болно.

Мөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хэрэг ослын улмаас эвдэрч гэмтсэн тээврийн хэрэгслээрээ олох байсан орлогыг хохирлын хэмжээнд оруулан тооцдоггүй. Хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тодорхойлохдоо тээврийн хэрэгсэлд учирсан хохирлоос гадна бусдын бие махбодь, эрүүл мэнд эд хөрөнгөнд тухайн гэм буруутай этгээдийн үйлдлийн улмаас учирсан шууд хохирлыг л оруулдаг.

Шүүх эмнэлэгийн шинжээчийн дүгнэлтээр гэмтлийн зэрэг тогтоогдоогүй эсвэл хөнгөн зэргийн гэмтэл тогтоогдсон бол жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчсөн нь тогтоогдсон байсан ч түүний үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй болно. Энэ тохиолдолд гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй, харин Зөрчлийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэдэг.

Хөдөлгөөний аюулгүй байдал нь хүний мэдээллийг хүлээн авах чадвар, мэдээллийг боловсруулах чадвар, тосон хариулах чадвар, ухамсарт үйл ажиллагаа, замын хөдөлгөөнд бэлтгэгдсэн байдал зэргээс хамаарах юм. Зам тээврийн ослын 70-80 хувь нь жолоочийн буруугаас гарсан гэсэн судалгаа байдаг. Зам тээврийн ослыг хувийн жингээр нь авч үзвэл хөдөлгөөний хурдыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлсэн зөрчил зонхилж, согтуугаар автомашин жолоодсон явдал, түүний дараа орж байна гэж олон улсын судалгаагаар тооцоолсон байна.

Жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийн заалтыг зөрчиж осол гаргаагүй ч зам тээврийн осол гаргахад шууд бусаар нөлөөлдөг гэдгийг ойлгох хэрэгтэй. Хууль дүрмийн заалтыг санаатай болон санамсаргүй зөрчиж байгаа нь жолоочийн мэдлэг ухамсар, сахилгатай шууд холбоотой юм.

Үүнтэй холбоотой нэг жишээ авъя. Шатахуун дуусаж зогсох:

Дээрх техникийн саатал тохиолдож зогсох үйлдлийг замын хөдөлгөөний дүрмийн зайлшгүй зогсолт гэсэн тодорхойлолттой холбон авч үзвэл шатахуун дуусаж зогсох нь зайлшгүй зогсолт биш бөгөөд жолоочийн хариуцлагатай шууд холбоотой юм. Хөдөлгөөнд оролцож байгаа бүх төрлийн механикжсан тээврийн хэрэгслүүд шатахууны түвшин заагууртай байдаг учир жолооч түүнийг хянаж явах үүрэгтэй. Иймд шатахуун

⁶⁸ <http://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

⁶⁹ Монгол Улсын Эрүүгийн хууль.2015

дуусаж хориглосон газар зогсож зам зорчих хэсгийг чөлөөлж зогсоогүй, бусдын хөдөлгөөнд саад учруулсан тээврийн хэрэгслийн жолоочтой хариуцлага тооцох хэрэгтэй.

Ер нь замын хөдөлгөөнд бие биедээ хүндэтгэл үзүүлэх, соёлтой оролцох, уулзвар гарц нэвтрэх үед нэг нь нөгөөгөөсөө өрсөх биш нэг нь нөгөөдөө хүндэтгэл үзүүлээд өнгөрүүлчихдэг хөдөлгөөний соёл ихээхэн үгүйлэгдэж байна. Иймээс бидэнд ихээхэн үгүйлэгдэж байгаа тэр соёлын талаар тухайлбал жолоочийн сахилга, соёлын талаар дараах зүйлд анхаарлаа хандуулах нь зүйтэй.

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах гол үзүүлэлтийн нэг бол хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, замын хөдөлгөөний дүрэм, журмын тухай цэгцтэй ойлголттой байх явдал юм. Тээврийн хэрэгслийн жолоочийн мэдлэг, чадвар хангалтгүй бол зам тээврийн осол ихсэх нь дамжиггүй. Иймд Замын хөдөлгөөний дүрмийг сурталчилан таниулах ажиллагааг чанаржуулж, хөдөлгөөний соёлыг дээшлүүлэх талаар системтэй ажил зохиох шаардлагатай байна.

2. Хувь хүн өөрөө дүрэм, журмаа биелүүлж, сахилгатай, соёлтой хөдөлгөөнд оролцох нь бусдыг сайнаар үлгэрлэдэг байна. Өөрөөр хэлбэл, бусад хөдөлгөөнд оролцогч дүрмээ биелүүлж, соёлтой байх угтвар нөхцөлийг бүрдүүлдэг байна. Иймд хүн бүр хөдөлгөөний соёл надаас эхлэнэ гэж алхам тутамдаа бодож явахад илүүдэхгүй. Жишээ нь: явган хүний гарцаар зам хөндлөн гарах гэж байгаа хүнд зам тавьж өгөлгүй түүний хөдөлгөөнд саад учруулах, гарцад ойртох үедээ хурд хасахгүй байх, дуут дохио өгөх зэрэг жолоочийн буруутай үйлдлээс болж явган зорчигчийн итгэл алдарч, хаагуурч гарсан ялгаагүй гэдэг сэтгэгдэл төрүүлдэг.

3. Манайд бас нэг хэлэхгүй өнгөрч болохгүй зүйл бол жолооч нарын анхааруулах дохиог хэрэглэж сураагүй эсвэл маш бүдүүлэг хэрэглэх явдал. Тээврийн хэрэгслийн дохио бол түүний “Хэл” байх ёстой. Ер нь хүмүүс хэлээрээ ойлголцог. Тэгвэл автомашинууд өөр хоорондоо хэлээрээ л ойлголцоно шүү дээ. Өөрөөр хэлбэл, анхааруулах дохиог хэрхэн хэрэглэхээс ихээхэн зүйл хамаарна гэдгийг ойлгох хэрэгтэй. Жишээ нь хөдөлгөөний чиг өөрчлөх анхааруулах дохиог өгөхдөө цаг хугацаа болон орон зайг зөв сонгох хэрэгтэй. Дуут дохиог зөвхөн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор зайлшгүй хэрэглэдэг гэдгийг дахин дахин сануулах ёстой. Барууны орнуудад дуут дохиог өгөх туйлын дургүй, дуут дохио өгсөн нэгийг хамгийн бүдүүлэг гэж үздэг. Өндөр хөгжилтэй улсуудад гэрэл шилжүүлэх дохиог өөр хоорондоо хүндэтгэл үзүүлэх, зам тавьж өгөх зэрэг тохиолдолд өгдөг бол манайд эсрэгээрээ ашигладаг. Мөн үүнээс гадна бид соёлтой улсуудад жолооч нарын дунд хэрэглэгддэг талархлын дохионуудыг нь сурах хэрэгтэй. Зам тавиулсан жолооч жолоодлогоо хүндрүүлэхгүйгээр автомашины бүхээг дотроос гараар дохих буюу ослын дохиог хоромхон зуур асааж талархалаа илрхийлдэг.

4. Замын хөдөлгөөнийг түгжиж байгаа нэг зүйл бол гэрлэн дохионы заалтыг тэр болгон баримтлахгүй байх явдал. Ногоон гэрэл асчихаад байхад өөр зүйлд анхаарлаа хандуулж хөдөлгөөний нягтралыг зохиомлоор бий болгодог. Суурин соёл иргэншсэн орны хүмүүс хөдөлгөөнд оролцохдоо дарааллын /хэн хамгийн түрүүнд ирсэн тэр эхлэх/ зарчмыг баримталдаг бол нүүдлийн соёл иргэншилтэй хүмүүс бид би л болж байвал гэсэн зарчмыг баримталдаг. Эндээс нэг гээх ёстой зүйл бол яах аргагүй аминчхан үзэл юм.

5. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ, аль эсвэл эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодох явдал багасахгүй байна. Согтууруулах ундааны зүйл, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох нь туйлын аюултай гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Сүүлийн үед хариуцлага улам чангарч байгаа зүйтэй гэж үздэг.


6. Монгол Улсын замын нөхцөл байдлыг хөгжилтэй орнуудынхтай харьцуулах нь илүүц биз. Замын эвдрэл гэмтэл, замын байгууламж, зорчих хэсгийн өргөний хэмжээ гээд тоочоод байвал жолооч нарт бэрхшээл мундахгүй. Замын ийм нөхцөл байдлаас шалтгаалан хөдөлгөөний нягтрал үүсэж, ихээхэн бухимдлыг бий болгож байгаа нь хэн бүхэнд ойлгомжтой. Нөгөө талаас бид энэ бухимдлыг өөрсдийн үйл ажиллагаагаараа зохиомлоор нэмэгдүүлж байна. Иймд жолооч нар энэ бухимдлыг багасгахад туйлын их үүрэгтэй. Хамгийн гол ярих ёстой зүйл бол жолооч нар тээврийн хэрэгслээ зөв байрлуулах явдал юм. Тээврийн хэрэгслийг аль болохоор зорчих хэсгээс чөлөөлж зогсоох шаардлагатай.

7. Автомашиныг гэрэлтүүлэг, дохиоллын системгүйгээр төсөөлөхийн аргагүй. Хоногийн харанхуй үед автомашин жолоодож замын хөдөлгөөнд оролцох нь өдрийн цагийнхаас бэрхшээлтэй бөгөөд аюултайд тооцогдоно. Олон улсын статистик судалгаагаар зам тээврийн ослын 50-иас илүү хувь нь хоногийн харанхуй үед гардаг бөгөөд энэ үед хөдөлгөөний эрчим 10 дахин багассан байдаг гэж үзжээ. Зам тээврийн осолд хүргэх үндсэн шалтгааны нэг нь жолооч холын гэрлийг ойрын гэрэлд шилжүүлдэггүйгээс эсрэг талаас ирж байгаа хөдөлгөөнд оролцогчын нүд гялбаж гэрэлд цохигдсоноос болдог ажээ. Хүний нүд харанхуй орчноос гэрэлтэй орчинд, гэрэлтэй орчноос харанхуй орчинд шилжих үед хүүхэн хараа томрох буюу жижигрэх учир харах чадвар тогтворжиход 10 секунд шаардагддаг байна. Тэгвэл 50 км/цаг хурдтай явж байгаа жолооч 139 метр замын турш хөдөлгөөнийг хянах баримжаа алдана гэсэн үг. Мөргөлдөх, шүргэлцэх, онхолдох, явган зорчигч дайрах осол нь тээврийн хэрэгслийн гэрэл хэрэглэх журам зөрчсөн, гэрэлтүүлэх хэрэгсэл ажиллахгүй болсноос шалтгаалдаг гэдгийг санах хэрэгтэй. Харанхуй, үзэгдэх орчин хязгаарлагдсан үед тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгслийг зөв ашиглах нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаад зогсохгүй хөдөлгөөний том соёл юм.

Замтээврийнослгарсанишалтгаан

2017 онд нийслэлд /6 дүүрэг/ бүртгэгдсэн 27491 зам тээврийн ослын 26156 буюу 95.1 хувь нь жолоочийн буруугаас, 1332 буюу 4,8 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс гарчээ. Замын нөхцөлөөс 3 осол гэж бүртгэсэн боловч зам засвар, арчилгааны байгууллагыг буруутган арга хэмжээ тооцсон мэдээлэлгүй зөвхөн жолоочид арга хэмжээ авагдсанаар хаагдсан байна.

График №1.



Өнгөрсөн оны ослын шалтгаантай харьцуулан үзвэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, хурд хэтрүүлсэнээс гарсан осол 14.0-24.5 хувиар буурсан байхад эгнээ байр


эзлэх, ухрах үйлдэл хийх, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, хажуу хоорондын зай тохируулаагүйгээс гарсан осол 2-2.1 дахин өссөн байна.

Замын нөхцөлөөс шалтгаалан гарсан осол нийслэлд 3 бүртгэгдсэн боловч зам засвар, арчилгааны байгууллагыг буруутган арга хэмжээ тооцсон мэдээлэл байхгүй жолоочид арга хэмжээ авагдсанаар хаагдсан байна. Энэ шалтгаанд техникийн гэмтэл, гадны гэрэл/замын гэрэл/, зам орчны нөхцөл зэргийг багтаан авч үзэж байгаа боловч авто зам, замын байгууламж хариуцсан байгууллагад техникийн акт тавьж арга хэмжээ тооцсон бүртгэл байхгүй байгаагаас замын нөхцөлөөс гарсан ослын үзүүлэлт бага бүртгэгдсэн хэвээр байна.

Зам тээврийн осол гарсан хэлбэр

Нийслэлд 2017 онд гарсан зам тээврийн ослын 22340 буюу 81.3 хувь нь мөргөлдөх, 4619 буюу 16.8 хувь нь явган зорчигч мөргөх, 124 буюу 0.4 хувь нь онхолдох, 329 буюу 1.2 хувь нь үл хөдлөх зүйл мөргөх/хашаа, хайс, гэр, шон/ 39 осол зорчигч унагах, 25 осол дугуйтай хүн мөргөх, 14 осол мал амьтан дайрах, 1 осол бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.

График №2.



Нийслэлд автомашин мөргөлдөх, шүргэлдэх хэлбэрээр дийлэнх осол гарч байгаа нь автомашинууд даатгалд хамрагдсантай холбоотойгоор шүргэлдэх төдийд ослын дуудлага өгч байгаагаар холбоотой юм.

Зам тээврийн осол гарсан гараг, цаг хугацаа

Осол гарсан цагийн нарийвчилсан судалгаанаас харвал:

- 06.00-12.00 цагийн хооронд 4579 буюу 16.8 хувь
- 12.00-18.00 цагийн хооронд 8308 буюу 30.4 хувь
- 18.00-22.00 цагийн хооронд 7739 буюу 28.3 хувь
- 22.00-06.00 цагийн хооронд 6684 буюу 24.5 хувь нь тус тус

бүртгэгджээ.

Осол их бүртгэгдэж байгаа цагийн байдлаас харахад 12.00-18.00 цагт дийлэнх хувийг эзэлсэн тоон үзүүлэлт гарсан байна⁷⁰.

- Даваа -4096 буюу 14.9%
- Мягмар-4014 буюу 14.6%
- Лхагва-3959 буюу 14.4%
- Пүрэв-3876 буюу 14.1%
- Баасан-4344 буюу 15.8%
- Бямба-3794 буюу 13.8%
- Ням-3408 буюу 12.4% нь тус тус бүртгэгдсэн тоон үзүүлэлт гарч

байна.

⁷⁰Цагдаагийн ерөнхий газрын, Замын цагдаагийн газар “Монгол улс дахь зам тээврийн хэрэгслийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлт” УБ., 2018

График №4.





График №5.



Дүгнэлт

Сүүлийн жилүүдэд хот руу тэмүүлсэн нүүдэл жил ирэх тусам өсч хүн ам, тээврийн хэрэгслийн тоо эрс ихэссэнээс нийслэлд замын ачаалал бий болж, үүнтэй холбоотойгоор зам тээврийн осол хэрэг өсөх хандлагатай байна. Мөн импортоор орж ирэх автомашины тоо өсөн нэмэгдэж үүнийг дагаад сөрөг үзэгдэл болох хөдөлгөөний нягтрал, ачаалал ихэсч, замын хөдөлгөөнд оролцогчдын хууль эрх зүйн мэдлэг сул, сахилга дэг журам соёл хангалтгүй байгаагаас зам тээврийн осол хэрэг ихэсч эрдэнэт хүний амь нас, эрүүл мэнд хохирох, эд материалын хохирол учрах явдал улам бүр өсөн нэмэгдэж байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”, Монгол Улсын Үндсэн хуульд “Иргэн амьд явах эрхтэй, эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасныг хэрэгжүүлж замын хөдөлгөөний саатал, замын хөдөлгөөнд оролцогчдын дүрмийн бус үйл ажиллагааг багасгах, хөдөлгөөний соёл, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, иргэдийн үүрэг оролцоог тодорхойлж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг хамгаалах ажлыг эрчимжүүлэх нэн шаардлагатай юм.

Ийнхүү замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад замын хөдөлгөөний эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил ослыг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, зөрчилд ногдуулсан хариуцлагын үр нөлөөг дээшлүүлэх зэрэг асуудлыг бүрэн судалж, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг тодруулан арилгах арга хэмжээг боловсруулснаар тодорхой үр дүнд хүрэх шаардлагатай байна.

Зам тээврийн осол хэрэг гарч байгаа үндсэн шалтгаанууд нь хөдөлгөөнд оролцогч замын хөдөлгөөний дүрмийн заалтыг ноцтойгоор зөрчих, зам орчны нөхцөл нь шаардлага хангахгүй байх, тээврийн хэрэгсэл нь техникийн хувьд бүрэн бус байх, мөн жолооч нарын хөдөлгөөнд оролцох сахилга, соёлын асуудал юм.

Ер нь замын замын хөдөлгөөнд бие биедээ хүндэтгэл үзүүлэх, соёлтой оролцох, уулзвар гарц нэвтрэх үед нэг нь нөгөөгөөсөө өрсөх биш нэг нь нөгөөдөө хүндэтгэл үзүүлээд өнгөрүүлчихдэг хөдөлгөөний соёл ихээхэн үгүйлэгдэж байна. Соёлтой орнуудад гарцаас гарах гэж байгаа жолооч бусдад гараар дохио өгч ойлгуулаад, бусад нь түүнийг ойлгож өнгөрүүлээд цааш хөдөлгөөнөө үргэлжлүүлдэг, тэр жолооч хариу талархал илэрхийлээд явдаг “бичигдээгүй хууль” үйлчилдэг байна. Энэ нь замын хөдөлгөөний дүрмийн заалтыг зөрчиж байгаа хэлбэр биш бөгөөд хүн хүндээ хүндэтгэл үзүүлж сурсаны нэг жишээ юм.

Замын хөдөлгөөний дүрмийн заалт шаардлагыг Монгол Улсын нутагт нийт иргэд дагаж биелүүлэх үүрэгтэй. Гэтэл энэ нь зөвхөн жолоочийн дүрэм, үүрэг гэж үздэг сэтгэлгээ түгээмэл байгаа нь явган зорчигч нар зам тээврийн осол гарахад нөлөөлж байна.

Явган зорчигчид гарцын шугам, гарамгүй газраар зам хөндлөн гарах, гэрлэн дохио зөрчих, ойртон ирж байгаа тээврийн хэрэгслийн урдуур гэнэт гүйх, автобуснаас буугаад зогсож байгаа тээврийн хэрэгслийн урдуур зам руу орох, зорчих хэсгээр согтуу явах зэргээр тээврийн хэрэгсэлд дайрагдаж амь нас эрүүл мэндээ хохироох явдал их байна. Мөн жолооч тээврийн хэрэгслийг гэмтэлтэй гэдгийг мэдсээр байж аргалаад явдаг зөрчил нь осол гаргах бас нэг шалтгаан болдог.

Хүүхдийг замын хөдөлгөөнд сахилга соёлтой оролцуулж сургах, ЗХД-ийн мэдлэг олгох сургалт явуулахад хамгийн үр дүнтэй газар бол яахын аргагүй сургууль, цэцэрлэг хүүхдийн байгууллага мөн. Хүүхэд бага наснаасаа замын хөдөлгөөний талаар тогтсон зөв ойлголттой, дүрэм заавраа системтэй мэддэг болсон байвал хожим нь гудамж замаар сахилга соёлтой зорчиж амь нас, эрүүл мэндээ хамгаалах хэвшилтэй болоод зогсохгүй тээврийн хэрэгслийг аюул осолгүй жолоодож сурах болно.

**ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН УЛАМЖЛАЛ ШИНЭЧЛЭЛ, ХӨГЖЛИЙН ЧИГ
ХАНДЛАГА, ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ**

Ж.Ууганчимэг

ХСИС-ийн ЭЗНУС-ийн Эрх зүйн онолын
тэнхимийн ахлах багш, ахлах дэслэгч

Удиртгал

Манай улсын хувьд мэргэд өвгөдөөс үлдээсэн эв эеэ хичээх тухай сургаалаар баялаг орон билээ. Харин 21-р зууны эрх зүйн тогтолцоонд энэхүү сургаал нь бүрэн дүүрэн хэрэгжих нөхцлийг бүрдүүлсэн. Шүүхийн шинэчлэлийн багц хуулийн хүрээнд шүүхийн ачааллыг бууруулах, нөгөө талаас маргаан шийдвэрлэх сонголтод хувилбарыг хөгжүүлэх үүднээс эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг 2012 онд батлан гаргасан ба Иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан, гэр бүлийн маргаанд эвлэрүүллийн зуучлалыг хэрэглэхээр хуульчилж өгсөн бөгөөд манай улсын хувьд 2015 оны байдлаар шүүхээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар нийт 3923 өргөдөл, нэхэмжлэл хүлээн авсаны 1887 буюу 48% нь гэр бүлийн маргаан, үүний 272 буюу 16 % нь амжилттай, 1348 буюу 84 % нь амжилтгүй явагдсан байна. Харин 2016 онд /11854/, 2017 /12589/ онуудад эвлэрүүлэн зуучлалаар шийдэгдсэн маргааны 20 гаруй хувийг гэр бүлийн маргаан эзэлж байгаа бөгөөд амжилттай эвлэрлийн төвшин 12% буюу маш бага байгаатай холбогдуулан гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааг иргэний болон хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны эрх зүйн зохицуулалтаас илүү ул суурьтай хөндөж судлахыг зорьж өөрийн санал, дүгнэлтээ дэвшүүлсэн болно. Мөн судлаач миний хувьд энэхүү судалгаагаараа гадны орны жишгийг өөрийн орны эвлэрүүлэн зуучлалын тогтолцоотой харьцуулан судалж зохих дүгнэлт, саналыг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг

Эвлэрүүлэн зуучлал, эрх зүйн маргаан, ганцаарчилсан маргаан, Гэр бүлийн маргаан, Орчин үеийн чиг хандлага

**1. Эвлэрүүлэн зуучлалын тухай ойлголт, эрх зүйн зохицуулалтын
уламжлал**

Эвлэрүүлэн зуучлал гэдэг нь маргалдагч талуудыг гуравдагч этгээдийн оролцоотойгоор харилцан тохиролцоонд хүргэх ажиллагаа бөгөөд шүүхийн бус аргаар хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагааны нэг төрөл юм.

Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулбал эвлэрүүлэн зуучлах ажилагааны давуу талыг дараахь байдлаар тодорхойлж болно.

1. Шүүхээр маргаан шийдвэрлүүлэхтэй холбогдон үүсэх зардалтай харьцуулахад зардал харьцангуй бага
2. Хурдан шуурхай- хуульд зааснаар эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 30 хоногт багтаан явуулдаг.
3. Нээлттэй бус байдаг- талууд оролцуулахыг зөвшөөрснөөс бусад этгээдийн хувьд хаалттай
4. Талуудын хоорондын харилцааг хадгалж үлдэх боломжтой.
5. Үйл явцыг зохигч удирдах боломжтой байдаг.
6. Уян хатан байдлаар тохиролцоонд хүрэх боломжтой.

Шүүхийн шинэчлэлийн багц хуулийн хүрээнд шүүхийн ачааллыг бууруулах, нөгөө талаас маргаан шийдвэрлэх сонголтод хувилбарыг хөгжүүлэх үүднээс эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг 2012 онд батлан гаргасан ба Иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан, гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхээр⁷¹ хуульчилсан бөгөөд манай улсын хувьд 2017 оны байдлаар шүүхээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар нийт 9932 өргөдөл, нэхэмжлэл авсаны 48 хувь нь гэр бүлийн маргаан үүний 36 хувь нь амжилттай, 64 хувь нь амжилтгүй явагдсан байна. харин хөдөө орон нутагт тухайлбал Говьсүмбэр аймгийн тухайд авч үзвэл

Говьсүмбэр аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлал нь 2016 оны 12 сарын 20-с 2017 оны 11 сарын 20-ны хооронд шинээр нийт 218 өргөдөл хүлээн авсанаас Иргэний эрх зүйн маргаантай өргөдөл 194, Гэр бүлийн эрх зүйн маргаантай өргөдөл 24 байна.

Үүнээс: Эвлэрэл амжилттай болсон 135 материалыг шүүгчийн захирамжаар баталгаажуулсан байгаагаас иргэний эрх зүйн маргаантай 130, Гэр бүлийн эрх зүйн маргаантай 5 байна.

Өнөөдрийн байдлаар оны эхний үлдэгдэл 4 материалтай нийлээд нийт 222 өргөдөл байна үүнээс иргэний эрх зүйн маргаантай 196, гэр бүлийн эрх зүйн маргаантай 26 өргөдөл байгаагаас эвлэрлийн гэрээ байгуулсан 135, дуусгавар болгосон 54, үлдэгдэл 33 байна. Өнгөрсөн оны мөн үед 211 өргөдөл хүлээн авч байсанаас эвлэрлийн гэрээ 195 байгуулж байсан ба дуусгавар болгосон материал 21 байсан байна.

Өнгөрсөн оны мөн үед нийт 211 өргөдөл хүлээн авч байсан байна. Энэ оны өнөөдрийн байдлаар 9.5%-иар өссөн байна. Оны эхнээс өнөөдрийн байдлаар эвлэрэл амжилтгүй болж дуусгавар болгосон 54 байгаагаас иргэний эрх зүйн маргаантай 35, Гэр бүлийн эрх зүйн маргаантай 19 байна. Өнгөрсөн оны мөн үед 21 материал дуусгавар болсон байна.

Хэдийгээр Монгол улсад Эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн орчин хожуу бий болсон ч Монголчууд бидний хувьд тийм ч хол ойлголт биш юм. Учир нь Монголчууд Ахаа алд хүндэл..., мэргэдийн үгийг өв болгон хичээ гэх мэтээр эв эсийн тухай сургаалаар амьдрал ахуйд гарсан маргаанаа шийдвэрлэдэг байсан.

Тухайлбал: гэр дотор маргаанаас гэрийн эзэн хэрэг заргыг шүүж, нэгэн хот айл дунд маргаанаас өвгөд настангаа сонсож... Эвлэрүүлэн зуучлалыг сүүлийн үед АНУ, Европ, Австралийн олон нийт хуульчид өргөнөөр хэрэглэж байгаагаас гадна Азийн орнуудын шүүхийн практикт эрчимтэй нэвтэрч байна. Эвлэрүүлэн зуучлал нь Япон улсад 94 жилийн өмнөөс, харин дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад 100 гаран жилийн түүхтэй ажиллагаа юм.

Эвлэрүүлэн зуучлалын давуу талуудыг дэлхий дахинд дараахь байдлаар тодорхойлж байна.

- Хувийн нууцтай холбоотой мэдээлэл олон нийтэд задардаггүй.
- Ажиллагааны уян хатан хэвшсэн байдаг
- Процессийн харилцан буулт хийх, зөвшилцөх, хүлээцтэй байх чадвар
- Мэтгэлцээний хамтын ажиллагаагаар солих
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал, зарлагыг багасгах буюу хорогдуулах замаар

20-р зуунд АНУ болон Европын улс орнуудад эвлэрүүлэн зуучлалыг хөдөлмөрийн маргаанд хэрэглэж байсныг эс тооцвол орчин үеийн эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн үндсийг тавьсан хүн бол харвардын Их сургуулийн профессор Франк Сандер гэж үздэг. Тэрээр 1976 оны “Паунд” эрдэм шинжилгээний хурал дээр “Маргааныг

⁷¹ Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 3-р зүйл

шийдвэрлэх өөр арга замууд” илтгэлдээ анх “Alternative dispute resolution- шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх” гэдэг нэр томъёог анх хэрэглэснээр энэ салбарын эцэг хэмээн нэрлэгдэх болсон.⁷² Үүнээс хойш АНУ-ын туршлагаас Канад, Герман, Австрали, Шинэ Зеланд, Скандиновын болон Зүүн Европын орнууд зуучлалыг шүүх болон арбитрын практикт нэвтрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд гадаад орнуудад маргаан шийдвэрлэх шүүхийн бус аргаар шийдвэрлэсэн хэргийн тоо жилээс жилд нэмэгдэж, эдгээр аргыг олон улсын худалдаа, интернетийн сүлжээ, үйлчилгээ эрчимтэй хөгжиж байгаа бусад салбарт өргөн хэрэглэх болжээ.

2. Эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах нь

АНУ-д анх эвлэрүүлэн зуучлал нь шүүхийн тогтолцоонд хамаарч байсан бөгөөд хөгжлийнхөө дараагийн шатанд байгууллагын хэлбэрт шилжсэн байна. Засгийн газраас бусад хуулийн этгээдүүд үйл ажиллагааныха нэг хэсэг болгож улмаар сургууль, засгийн газрын байгууллагууд тэрхүү шүүхийн системд хамаарч байсан эвлэрүүлэн зуучлалын процессийг хэрэглэх болсон.⁷³

АНУ-д эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэгжүүлэхдээ зарим байгууллагууд нь цахим хэлбэрээр маргаан шийдвэрлэдэг болсон. АНУ-ын өмгөөлөгчдийн холбоо нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан, дэлхий дээрх маргаан шийдвэрлэх хамгийн том мэргэжлийн холбоо бөгөөд 18000 гаруй гишүүнтэй байгууллага юм.

Энэхүү тогтолцоонд төрийн болон төрийн бус байгууллагууд сайн дурын үндсэн дээр эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг явуулах нь нилээд түгээмэл байдаг. Эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэж болох маргааны төрөл нь маш өргөн хүрээнд тодорхойлогдож байдаг. Тухайлбал: хувийн эрх зүйн маргаануудаас гадна татварын, эрүүгийн зарим хэргүүдийг ч шийдвэрлэх боломжтой байдаг.

Австрали улсын хувьд шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх ажиллагаа нь өнөөгийн хөгжлийн түвшнээс ялгаатайгаар олон жилийн өмнө аж үйлдвэрийн харилцаанд суурилан хөгжиж эхэлсэн байна. 1904 онд Австралийн хамтын ажиллагаатай парламентаас Зуучлал, арбитрын тухай эрх зүйн баримт бичгийг анхлан боловсруулж байсан. Австралийн эвлэрүүлэн зуучлал нь олон нийтийн, нөхөрсөг зуучлал, арилжаа худалдааны, үндэстний гэсэн төрөлтэй бөгөөд эдгээрээс нөхөрсөг зуучлал нь өөрийн насны, өөрийн мэргэжлийн чиглэлээр зуучлалаар бусдад тусладаг бол Италид эвлэрүүлэн зуучлах аргаар маргааныг шийдвэрлэх хувилбарын талаар үйлчлүүлэгчдэдээ мэдээлэл өгөх нь хуульчдын үүрэг байдаг байна. Тус улсад хөдөлмөрийн маргаан, гэр бүл цуцлах, хөдөө аж ахуйтай холбоотой төрөл бүрийн маргааныг шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар заавал шийдэж байхаар тогтоосон байдаг.

Герман улсын хувьд 2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай шинэ хуулийг батласан ба энэхүү хуулиараа Европын холбооны дүрмийг өөрийн дотооддоо мөрдөх, эвлэрүүлэн зуучлалын хэм хэмжээг тусгаж өгсөн.

“Герман улсад эвлэрүүлэн зуучлалыг шүүхийн тогтолцооны нэг гэж үздэг бөгөөд эвлэрүүлэн зуучлал нь бүхэлдээ сайн дурын үндсэн дээр явагддаг”⁷⁴

Их Британид эвлэрүүлэн зуучлал болон эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зохицуулсан Эвлэрүүлэн зуучлалын тухай тусгайлсан хууль байхгүй бөгөөд эвлэрүүлэн зуучлагчдын сургалтын үйл ажиллагаа, томилгоог төрийн зүгээс хянаж зохицуулагдгүй. Харин засгийн газар, хууль шүүхийн байгууллагууд болон хувийн компаниудын зүгээс

⁷² “Хууль дээдлэх ёс” сэтгүүл №6, МУИС-ХЗС-ийн дэд профессор, хууль зүйн ухааны дозтор Д.Ганбаатар “Гадаадын орнуудын туршлага ба эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дагаврыг үнэлэх нь” 61-62 дахь тал.

⁷³ Penny Brooker “Mediation law journey” 2013.,р,14

⁷⁴ “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн онол арга зүйн тайлбар” УБ., 2015 он 51 дэх тал

эвлэрүүлэн зуучлалыг хөхүүлэн дэмжиж маргагч талуудыг эвлэрүүлэн зуучлалын замаар маргаанаа шийдэхийг уриалдаг байна.

Япон улсад 1983 оноос эхлэн шүүхийн журмаар шийдвэрлэгдсэн хэргийн тоо өсч байгаа хэдий ч шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх ажиллагаа ажиллагаа өргөнөөр хэрэглэгддэг хэвээр байна.

Өнөөгийн Япон улсад шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх ажиллагаа нь эвлэрүүлэл ба зуучлал гэсэн үндсэн хэлбэртэй байдаг. Эвлэрүүллийг Иргэний Эвлэрүүллийн хуулиар зохицуулдаг ба хуулийн зорилго нь маргааныг эвийн журмаа харилцан зөвшилцлийн хэлбэрээр шийдвэрлэхэд чиглэгддэг. Эвлэрүүлэх ажиллагааг дүүргийн шүүх эсвэл анхан шатны түргэвчилсэн шүүх дээр хэрэгжүүлэх ба гэр бүлээс үүссэн маргааныг гэр бүлийн шүүхэд хэрэгжүүлдэг.

3. Монгол улс дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, түүний өнөөгийн байдал

Манай улсын хувьд эвлэрүүлэн зуучлалыг нэвтрүүлэх ажлыг Япон улсын JICA олон улсын хамтын ажиллагааны байгууллагын санаачлагаар 2010 оны 05-р сард эхлүүлсэн ба үүнээс үндэслэн эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг баталж эхлэсэн билээ.

Уг хуулийн 3-р зүйлд зааснаар:

Эвлэрүүлэн зуучлалд хамаарах маргааны төрөл нь:

- Иргэний эрх зүйн маргаан
- Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан
- Гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаан юм.

Мөн эдгээрээс бусад харицаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг зөвхөн тусгайлан хуульд заасан тохиолдолд хэрэглэж болно” гэжээ. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талууд нь:

- Иргэн
- Хуулийн этгээд
- Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна.

Монгол улсын хувьд эвлэрүүлэн зуучлах ажиллагаан дахь шүүгчийн оролцоог хуульчлахдаа тэрээр уг ажилагааг эхлүүлэхэд голлох үүрэгтэй болохыг зааж өгсөн. Тухайлбал:

➤ Шүүгч маргалдагч талуудад эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдээллийг бүрэн өгөх үүрэгтэй.

➤ Эвлэрүүлэн зуучлалын тухай Монгол улсын хуулийн 6-р зүйлийн 6.2-т “Шүүхшүүхэд иргэний хэрэг үүсгэхээс өмнө болон хойно , хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шат бүрт талуудыг эвлэрэх боломжоор хангаж, эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаа авах талаар сануулах үүрэгтэй” гэж хуульчлан зааж өгсөн байна. Ийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанад шүүгч талуудад эдлэх эрхийг тайлбарлан өгөхдөө “Эвлэрүүлэн зуучлагчийг туслалцаа авах талаар сануулах үүрэгтэй ба ингэхдээ зохигч болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс нотлох баримт гаргаж өгөх үед нь шууд зохигчид болон эсвэл төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан сануулж болно. “

➤ Шүүгч эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой маргаан болон зохисгүй маргааныг тодорхойлох чадвартай байх ёстой. Эвлэрүүлэн зуучлалын тухай Монгол улсын хуулийн 21-р зүйлийн 21.1-т “...Шүүгч эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой гэж үзэж санал болгосон...” хэмээн заасан нь дээр дурьдсан чадварыг шүүгчээс шаардаж байгаа хэрэг юм. Мөн түүнчлэн уг хуулийн 3.1-т : “иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан болон гэр бүлийн маргаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ” гэж заасан нь эдгээртэй холбоотой бүхий л маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ нь зохистой гэсэн үг биш юм.

➤ Эвлэрүүлэн зуучлах ажиллагаан дахь шүүгчийн гол оролцоо нь эвлэрлийн гэрээг баталгаажуулж, захирамж гаргах явдал юм. Дээрхи хуулийн 27.2-т “Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулж, захирамж гаргана.” гэж заасан. Харин төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг шүүхээс баталгаажуулахгүй бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хандах эрх нь нээлттэй байдаг.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд зааснаар шийдвэрлэх маргаануудын төрлөөс гэр бүлийн холбогдолтой маргааныг дээрхи журмаар шийдвэрлэхэд гарч буй бэрхшээл, тусламдсан асуудлын талаар тухайлан судлаж үзэхийг зорьсон юм.

Гэр бүлийг эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа Эвлэрүүлэн зуучлал (mediation) Хараат бус бие даасан зуучлагчаас маргалдагч талуудын хооронд шууд хэлэлцээр хийлгэх замаар тэдний асуудлыг шийдвэрлэх процесс юм.

Гэр бүлийн холбогдолтой маргаан нь эхнэр нөхөр, эцэг, эх, хамаатан садан зэрэг ойр дотны холбоотой хүмүүсийн хооронд үүсдэг бөгөөд хуульд үндэслэн нэг мөр эцэслэн шийдвэрлэхээс илүүтэйгээр тухайн маргааны нөхцөл байдалд тохируулан, ямар нэг хатуу тогтоосон арга хэлбэрт баригдалгүй, бүрэн хэмжээнд харилцан ярилцаж ойлголцсоны үндсэн дээр маргааныг шийдвэрлэх нь зохимжтой гэж үздэг. Тухайн маргаан нь гэр бүлийн гишүүдийн бие биедээ итгэх итгэл, урам хугаралт, амьдралыг үзэх үзэл өөрчлөгдсөнтэй холбоотой нарийн төвөгтэй шалтгаантай бөгөөд сэтгэл хөдлөлийн байдал ихээхэн давамгайлсан байдгаараа онцлогтой.

Эвлэрүүлэн зуучлалын тухай Монгол улсын хуулийн 32-р зүйлд :

- Шүүхээс тогтоосон хугацаанд гэрлэгчид эвлэрээгүй бол шүүх гэрлэгчдийн хооронд үүссэн гэрлэлт цуцлахаас бусад тэтгэвэр, тэтгэлэг, тэтгэмж, дундын хөрөнгө, хуваахтай холбогдсон маргаанд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл сонгосон эвлэрүүлэн зуучлагчийг оролцуулж болно.

- Гэрлэгчдийг эвлэрүүлэх ажиллагаанд сэтгэлзүйч болон төрөл, сандан, найз нөхөд, хамтран ажиллагсдыг оролцуулж болно гэж тус тус заасан байна.

Мөн түүнчлэн ИХШХШТХ-д зааснаар:

- Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна.

- ИХШХШТХ-д заасан эвлэрүүлэх арга хэмжээг зөвхөн нэг удаа хэрэглэнэ. Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэ журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон байх нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн маргааны талаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас татгалзах үндэслэл болохгүй

- ... гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол, хор уршиг учирч болзошгүй, эсүл учирсан нь тогтоогдсон бол шүүгч эврэлүүлэх арга хэмжээ авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.

- Гэрлэгчид шүүхээс эвлэрүүлэх арга хэмжээ авсан хугацаанд эвлэрээгүй бол шүүгч гэрлэлтийг цуцлах шийдвэр гаргана... гэсэн заалтуудаас харахад гэр бүлийн маргаанд дээд дурдсан тохиолдлуудаас бусдад нь заавал эвлэрүүлэн зуучлал хэрэглэх ёстой байна.

Манай улсын хувьд 2017 оны байдлаар нийт хүлээн авсан өргөдөл нэхэмжлэлийн 48% нь гэр бүлийн маргаан байгаагаас 10 хувь нь амжилттай, 84 хувь нь амжилтгүй явагдсан байна. Европын улсуудаас Франц улсад гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа илүү хөгжсөн бөгөөд гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн

зуучлагч нь тугай сургалтанд хамрагдаж диплом авсан байхыг шаарддаг байна.⁷⁵ Америк, Австрали болон Европын зарим оронд эхэн үедээ гэр бүлийн Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг нэг л зуучлагч үзүүлдэг байсан бол сүүлийн жилүүдэд 2 ба түүнээс дээш тооны зуучлагч нар хамтарч ажиллах болсон бөгөөд нэр бүлийн эвлэрүүлэн зуучлагч нар нь олон мэргэжлийн хүмүүс байдгаас ихэвчлэн нийгмийн ажилтан, хуульч, сэтгэл судлаачид энэхүү ажиллагааг гүйцэтгэх хандлагатай байна.

Харин манай улсын хувьд эвлэрүүлэн зуучлагч нь:

- Эрх зүйн бүрэн чадамжтай
- Дээд боловсролтой
- Сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх
- Эрх бүхий байгууллагын эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн байх
- Ял шийтгэлгүй байх шаардлагуудыг тавьдаг.

Герман улсад зуучлагчийн үүргийг өмгөөлөгч, эвлэрүүлэх албад, нотариатч болон үйл ажиллагааны янз бүрийн шинжээч нар гүйцэтгэдэг байна.

Япон улсын хувьд дээрхи улсуудаас ялгаатай нь уламжлал, ёс заншилд тулгуурладаг ба 40-70 настай бол эвлэрүүлэн зуучлагч болдог.

Дүгнэлт. Иргэний эрх зүйн маргааныг Эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэхэд онцлог тал нь талууд анхны уулзалтаар эвлэрэх магадлал маш өндөр байдаг ба ихэнхи хувь нь хамаатан сандан болон найз нөхөдийн хооронд хийгдсэн гэрээ, хэлцэлтэй холбоотой байдаг байна. Иргэний эрх зүйн маргааны хувьд дан ганц эд хөрөнгийн харилцаа голлодог тул хохирол нөхөн барагдуулсан тохиолдолд эвлэрүүлэх магадлал гэр бүлийн маргаанаас туйлын өндөр юм.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 13-р зүйлийн 13:2.3-т “Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвх санаачлагатай оролцох, эвлэрүүлэн зуучлагчийн дуудлага товлосон уулзалтанд хүрэлцэн ирэх үүрэгтэй” гэж заасан байдаг.

Гэр бүлийн холбогдолтой маргааны дийлэнхи хувь нь гэрлэлт цуцлалттай холбоотой маргаан байдаг бөгөөд талууд олон жил амьдраагүй, талуудын аль нэг нь өөр хүнтэй гэр бүлийн харилцаатай эсхүл хамтран амьдардаг болсон мөн үр хүүхэдтэй болсон зэрэгтэй холбоотойгоор эвлэрүүлэх ажиллагаа үр дүнгүй болдог. Мөн нөхрийн хувьд хүүхдийн тэтгэмж, тэтгэлгийн асуудлаас зайлсхийн товлосон уулзалтад ирэхгүй байх нь практикт түгээмэл гардаг. Хэрэв дээр дурдсан урьдчилсан нөхцөл байдал байвал эвлэрүүлэн зуучлалд хандахгүйгээр шууд шүүхээр шийдвэрлүүлэх байдлаар зохицууж өгөх нь зүйтэй. Үүнээс үүдэн гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлагчийн чадвар, идэвхи оролцоо маш чухал болох нь харагдаж байна.

Манай улсын хувьд нэн тэргүүнд гэр бүлийн хөгжилд анхаарах шаардлагатай бөгөөд гэр бүлийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бий болгох, анхан шатны шүүх бүрт гэр бүлийн дагнасан шүүх байгуулж, мэргэшсэн сэтгэлзүйч, хуульчдыг ажиллуулан эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэн би дараахь саналыг дэвшүүлж байна.

- Гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлахтай холбогдсон эрх зүйн орчинг уян хатан болгох
- Япон улсын адилаар гэр бүлийн шүүх байгуулах, гэр бүлийн зөвлөгөө өгөх газруудыг нээн ажиллуулах, Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлагчдыг сэтгэл зүйч, хуульчдаар хийлгэх

⁷⁵ Д.Гангабаатар “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2013 он №06/46/”Гадаад орнуудын туршлага ба эвдэрүүлэн зуучлах ажиллагааны үр дагаврыг үнэлэх нь” 63 дахь тал

НЕПРИКОСНОВЕННОСТЬ ЛИЧНОСТИ И ПРИНУЖДЕНИЕ В УГОЛОВНОМ ПРОЦЕССЕ МОНГОЛИИ В ВИДЕ АРЕСТА ПОДОЗРЕВАЕМОГО

Даш Тамир

Адъюнкт кафедры уголовного процесса
Омской Академии МВД России, 644092, г. Омск, Комарова 7,
Тел: +79994571989, Email: dash_tamir2001@yahoo.com
УДК 343.13 © Даш Тамир, 2018

Товч агуулга

Уг нийтлэлд сэжигтнийг баривчлах албадлагын арга хэмжээг хэрэглэх явцад, сэжигтний хууль ёсны ашиг сонирхол, эрхийг хангах, болон хүний халдашгүй байх эрхийг хангах зарчмыг баримтлахад тулгамдсан асуудлуудыг хөндсөн.

Түлхүүр үг

Албадлагын арга хэмжээ, сэжигтнийг баривчлах, сэжигтний эрх, хүний халдашгүй байх эрхийг хангах зарчим

Аннотация: в статье рассматриваются вопросы соблюдения принципа неприкосновенность личности и обеспечения прав и законных интересов подозреваемого при применении меры уголовно-процессуального принуждения в виде ареста подозреваемого.

Ключевые слова: мера принуждения, арест подозреваемого, права подозреваемого, принцип неприкосновенность личности.

Общеизвестно, что уголовное судопроизводство невозможно без применения государственно-правового принуждения. Считается, что «общепризнанные методы правового регулирования: диспозитивный и императивный, в той или иной мере содержат в себе элементы принуждения, именно поэтому принуждение является «генеральным», основополагающим методом в деятельности государства»⁷⁶.

Права каждого человека на свободу и личную неприкосновенность, а также на судебную защиту в случае ареста и заключения под стражу относятся к общепризнанным принципам и нормам международного права.

Правовая регламентация ареста подозреваемого как процессуального действия, непосредственно затрагивающего конституционные права человека на свободу и личную неприкосновенность, традиционно представляет интерес для уголовно-процессуальной науки⁷⁷.

Правовой смысл понятия «право на свободу и личную неприкосновенность», сформулированные в ст. 5 Конвенции (Совета Европы) о защите прав человека и

⁷⁶ Давлетов А. А., Азарёнок Н. В. Программа уголовного судопроизводства. - М.: Издательство «Юрлитинформ», 2009. С. 151.

⁷⁷ Дадиева Х.Г. Обеспечение прав лица, задержанного по подозрению в совершении преступления // Вестник Дагестанского государственного университета. 2010. Вып. 2 - С. 136.

основных свобод⁷⁸, нашли достаточно полное отражение и в Уголовно-процессуального кодекса Монголии (далее УПК Монголии).

В международно-правовой практике сложились определенные стандартные правила обращения с задержанными и заключенными под стражу. Эти правила нашли нормативное закрепление в различных международно-правовых документах, прежде всего - резолюциях, декларациях и других актах Организации Объединенных Наций⁷⁹.

Международные минимальные стандарты обращения с задержанными, сформулированные в международно-правовых актах, нашли достаточно полное отражение и в законодательстве Монголии. В частности, законе от 01 июля 1999 г. «О содержании под стражей подозреваемых и обвиняемых в совершении преступлений» отмечено, что арест и содержание под стражей осуществляется в соответствии с принципами законности, равенства всех граждан перед законом, гуманизма, уважения человеческого достоинства, в соответствии с Конституцией Монголии, принципами и нормами УПК Монголии и международного права, а также международными договорами Монголии и не должно сопровождаться пытками, иными действиями, имеющими целью причинение физических или нравственных страданий подозреваемым и обвиняемым в совершении преступлений, арестованным и содержащимся под стражей⁸⁰.

В ст.1.14 и ст.7.4 УПК Монголии изложены нормы, отражающие важнейшее конституционное положение о том, что каждый гражданин имеет право защищать самого себя, либо пользоваться помощью адвоката, если нарушены его законные права и интересы предусмотренные законодательством Монголии и международным договором Монголии (ч. 13, 14 ст.16 Конституции Монголии).

Доктор юридических наук, профессор С.Жанцан дает толкование понятия «конституционное право защищать самого себя, либо пользоваться помощью адвоката», о том, что подозреваемый, обвиняемый, подсудимый, потерпевший защищает самого себя иными средствами и способами, не запрещенными законодательством, и может пользоваться услугами квалифицированной юридической помощи, при этом верит, что ему смогут оказать такую помощь⁸¹. В этом контексте подозреваемый приобретает значение эффективного средства его защиты.

Так, Попков Н. В. пишет о том что, о наличие процессуальных проблем задержания подозреваемого объясняется, в том числе, и сложностью обеспечения равновесия и баланса между правом подозреваемого на свободу и личную неприкосновенность и необходимостью раскрытия преступления и обеспечения неотвратимости наказания путем привлечения виновного к уголовной ответственности. Осуществление указанной цели невозможно обеспечить без ограничения права подозреваемого на свободу. Указанное противоречие показывает, что институт

⁷⁸ "Конвенция о защите прав человека и основных свобод" (Заключена в г. Риме 04.11.1950) (с изм. от 13.05.2004) (вместе с "Протоколом /№ 1/" (Подписан в г. Париже 20.03.1952), "Протоколом № 4 об обеспечении некоторых прав и свобод помимо тех, которые уже включены в Конвенцию и первый Протокол к ней" (Подписан в г. Страсбурге 16.09.1963), "Протоколом № 7" (Подписан в г. Страсбурге 22.11.1984) // [Электронный ресурс]. «КонсультантПлюс»

⁷⁹ Подробнее об этом см.: Григорьев В. Н. Задержание подозреваемого . - М.: Учебно-консультационный центр «ЮрИнфоР», 1999. С. 29.

⁸⁰ Закон от 01 июля 1999 г. «О содержании под стражей подозреваемых и обвиняемых в совершении преступлений» (по состоянию 09 марта 2018 г., на монгольском языке). // Государственная информация. 2017. №8.

⁸¹ С.Жанцан, Г.Баясгалан, Ж.Бямбаа Комментарии к Уголовно-процессуальному кодексу Монголии (постатейный). г. Улаанбаатар. 2003. С. 47.

задержания подозреваемого является одним из наиболее сложных в уголовном процессе, актуальность и важность его исследования никогда не ослабевает⁸².

Действующий УПК РФ сделал шаг вперед в вопросах регламентации мер процессуального принуждения по сравнению с УПК РСФСР. Так, законодатель в ст. 5 УПК РФ обозначил такие определения, как «задержание подозреваемого» (п. 11), «избрание меры пресечения» (п. 13), «момент фактического задержания» (п. 15), «применение меры пресечения» (п. 29), «содержание под стражей» (п. 42). В структуре Кодекса выделен специальный раздел 4 «Меры процессуального принуждения», в котором дана классификация мер процессуального принуждения: задержание подозреваемого (гл. 12); меры пресечения (гл. 13); иные меры процессуального принуждения (гл. 14). В связи с этим более детально регламентированы основания и порядок применения принуждения. Усовершенствована система мер уголовно-процессуального принуждения.

Таким образом, нормативное регулирование данного условия в УПК РФ в целом соответствует как типу современного уголовного процесса России, так и конституционным требованиям обеспечения прав, свобод и законных интересов личности, а также с одной стороны, помогает решению задач, стоящих перед правоприменителем, а с другой - гарантирует соблюдение прав и свобод человека⁸³.

Следователи нередко, воспользовавшись незнанием закона лиц, подозреваемых в совершении преступлений, применяют арест подозреваемого при отсутствии законных оснований. Имеют место факты нарушения права арестованных лиц на защиту: не разъясняются права, не создаются условия, необходимые для того, чтобы подозреваемый имел возможность осуществить свою защиту. Незаконное и необоснованное применение ареста влечет за собой существенный ущерб правам и свободам человека и гражданина.

Согласно ст. 31.9 УПК Монголии с момента предъявления подозреваемому для ознакомления решения суда об аресте, либо разъяснения прав предусмотренной части 1 статьи 31.6 УПК исчисляется 48- часовая срок кратковременного лишения свободы, в котором фактический арест подозреваемого вообще не учитывается⁸⁴.

Исходя из сказанного следует отметить, что законодательное нерегулированность фактического ареста в УПК Монголии влечет за собой незаконного удержания лица, нарушающего неприкосновенность личности в предусмотренным ст. 1.8 УПК Монголии. Необходимо учитывать время фактического ареста в срок содержания под стражей и предусмотреть это в УПК Монголии.

Представляется, что применение мер процессуального принуждения, в частности ареста, должно соответствовать принципам уголовного судопроизводства. Особое внимание должно уделяться правильному толкованию оснований, мотивов ареста подозреваемого, что позволит избежать вынесения незаконных и необоснованных решений.

Вышеизложенное указывает на необходимость разработки рекомендаций по применению меры уголовно-процессуального принуждения в виде ареста подозреваемого, а также предложений по дальнейшему совершенствованию уголовно-процессуального законодательства Монголии.

⁸² Попков Н. В. Задержание подозреваемого и обвиняемого как вид государственного принуждения: Дис. ...канд. юрид. наук. Нижний Новгород, 2007. С. 135-136.

⁸³ Давлетов А. А., Азарёнок Н. В. Программа уголовного судопроизводства. - М.: Издательство «Юрлитинформ», 2009. С. 153-154.

⁸⁴ Чимэддорж Д. Меры уголовно-процессуального принуждения, связанные с изоляцией от общества, в уголовном процессе Монголии и России // Автореферат диссертации на соискание ученой степени кандидата юридических наук Санкт-Петербург 2005.